

Улсын бүртгэлийн
Дугаар 9071019012
Аравтын бүрэн
ангиллын код

Нууцын зэрэглэл Б

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: ШУ ½ - 2019/23



**БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ**



ШУТСаn
УЛСЫН ХӨГЖИЛ ШИНЖЛЭХ УХААНААС ЭХТЭЙ

МОНГОЛ УЛСЫН “БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА, БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЗАГВАР БОЛОВСРУУЛАХ” ТӨСӨЛ

Шинжлэх ухаан, технологийн захиалгат төслийн эцсийн тайлан

2019-2021 он

Төслийн удирдагч:

Гүрбазарын Баттүвшин, ШУТИС-ийн БАТС-ийн
Захирал, Бизнесийн удирдлагын доктор, профессор

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан, технологийн сан

Захиалагч байгууллага:

Боловсрол, шинжлэх ухааны яам

Тайлан өмчлөгч байгууллага:

Хүний хөгжлийн судалгаа, сургалтын төв

Сүхбаатар дүүрэг 9-р хороо Алтайн гудамж 17-р байр
202 976 Ulaanbaatar, Mongolia

Утас: 7709 0648

info@human-development.mn

Улаанбаатар 2022

Улсын бүртгэлийн
Дугаар 9071019012
Аравтын бүрэн
ангиллын код

Нууцын зэрэглэл Б

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: ШУ ½ - 2019/23

“МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА, БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЗАГВАР БОЛОВСРУУЛАХ” ТӨСӨЛ

Шинжлэх ухаан, технологийн захиалгат төслийн эцсийн тайлан

2019-2021 он

Төслийн удирдагч:

Гүрбазарын Баттүвшин, ШУТИС-ийн БАТС-ийн
Захирал, Бизнесийн удирдлагын доктор,
профессор

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан, технологийн сан

Захиалагч байгууллага:

Боловсрол, шинжлэх ухааны яам

Тайлан өмчлөгч байгууллага:

Хүний хөгжлийн судалгаа, сургалтын төв

Гүйцэтгэгчийн шуудангийн хаяг, утас,
e-mail:

Сүхбаатар дүүрэг 9-р хороо Алтайн гудамж 17-р
байр 202 976 Ulaanbaatar, Mongolia

Утас: 7709 0648

info@human-development.mn

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	I
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	II
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	III
I. ТӨСЛИЙН ТОЙМ	1
1.1. Төслийн үндэслэл.....	1
1.2. Төслийн агуулга, зорилго.....	2
1.3. Төсөл хэрэгжүүлсэн бүтэц, зохион байгуулалт.....	6
1.4. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө.....	7
II. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ҮНДЭСНИЙ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ ИНСТИТУЦИЙН БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ	9
1.1. Удиртгал.....	9
1.2. Судалгааны арга зүй.....	10
1.3. Хууль, эрх зүйн агуулгын шинжилгээ.....	12
1.4. Бодлогын судалгааны улс төр, засаглал, боловсролын институцийн хөгжил.....	18
1.5. Дүгнэлт.....	29
III. ҮНДЭСНИЙ БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ОЛОН УЛСЫН ШИЛДЭГ ТУРШЛАГА: БНСУ БОЛОН СИНГАПУР УЛС	31
1.1. ЯАГААД БОДЛОГЫН СУДАЛГАА ЧУХАЛ ВЭ?.....	31
3.1. Олон улсын нийтлэг ойлголтууд.....	34
3.2. Дэлхий улс орнууд бодлогын судалгаа, шинжилгээний ажлын чанарыг хэрхэн хэмждэг вэ?.....	37
3.3. Бодлогын судалгаа, шинжилгээг хэн хийдэг вэ? – Олон улсын туршлага.....	39
3.4. БНСУ-ын боловсролын бодлогын судалгааны туршлага.....	45
3.5. Сингапур улсын туршлага.....	53
3.6. Дүгнэлт.....	58
IV. БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ӨРТГИЙН ҮР ДҮН, ӨРТГИЙН ҮР АШГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗАГВАР, АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА	60
4.1. ӨРТГИЙН ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ.....	60
4.2. ӨРТГИЙН ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ.....	62
4.3. Дүгнэлт.....	65
4.4. Гарын авлага: Бодлогын шинжилгээ – Боловсролын жишээн дээр.....	66
5. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ: БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ИНСТИТУТ БАЙГУУЛАХ АСУУДАЛ 72	
5.1. Хураангуй.....	72
5.2. Бодлогын судалгааны хүрээлэн буюу “ТИНК ТАНК”.....	73
5.3. Бодлогын санал, зөвлөмж.....	78
5.4. Дүгнэлт.....	85
6. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛОН ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ СУРГАЛТ	86
6.1. “Боловсрол ба бодлогын судалгааны институт: Олон улсын туршлага” хэлэлцүүлэг.....	86
6.2. Боловсролын бодлогын шинжилгээ СЕМИНАР – 2021.....	89
Ном зүй.....	97

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БАТС	Бизнесийн ахисан түвшний сургууль
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУСЯ	Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яам
БуХС	Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
МБ	Манлай баг
МҮТИС	Монголын үндэсний техникийн их сургууль
ПИСА(PISA)	Олон улсын сурагчдын үнэлгээний хөтөлбөр (Program of for International Student Assessment)
СӨБ	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
УБ	Удирдлагын баг
ҮӨХ	Үр ашиг, өртгийн харьцаа
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ЦӨНӨ	Цэвэр өнөөгийн үнэ цэнэ
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Төслийн хамтарсан удирдлагын баг	6
Хүснэгт 2: Төслийн манлай баг	7
Хүснэгт 3: Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн онцлог зүйл, заалт	13
Хүснэгт 4: Бусад хууль, журам төрийн бодлогын зорилго, үр нөлөө.....	15
Хүснэгт 5: Бодлогын судалгааны институтийн олон улсын жишигтэй Боловсролын хүрээлэнгийн одоогийн байдалтай харьцуулсан шинжилгээ.....	24
Хүснэгт 6: Солонгосын боловсролын хүрээлэнг байгуулсан, оршин тогтнож буй үндэслэл, зорилгууд.....	48
Хүснэгт 7: Солонгосын боловсролын бодлогын хүрээлэнгийн шинэ зууны дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн дэвшүүлсэн зорилтууд	49
Хүснэгт 8: Сурган заах арга зүй ба практик судалгааны төвийн үндсэн дөрвөн зорилт ...	56
Хүснэгт 9: ҮӨХ-ны шинжилгээний үр дүнг тайлж унших	63
Хүснэгт 10: Бодлогын судалгааны тинк танкийн ангилал ба жишээ	75
Хүснэгт 11: Тинк танкийн зохион байгуулалтын хэлбэрүүд	77
Хүснэгт 12: Боловсролын бодлогын шинжилгээ сэдэвт түгээн дэлгэрүүлэх сургалт семинарын мэдээлэл.....	90

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Төслийн календарчилсан төлөвлөгөө	8
Зураг 2: Улс төр, хөгжлийн буруу зам руу чиглэж буйг илтгэх баримтууд	19
Зураг 3: Төрийн байгууллагуудын бодлогын шинжээчийн ажлын байранд гарсан өөрчлөлт	40
Зураг 4: Солонгосын боловсролын хөгжлийн институтийн алсын хараа.....	47
Зураг 5: Бага, дунд боловсролын судалгааны асуудал	50
Зураг 6: Дээд боловсролын бодлогын судалгааны салбар	52
Зураг 7: Ирээдүйн боловсролын судалгааны салбар	52
Зураг 8: Боловсролын бодлогын дэмжлэгийн судалгааны төв.....	53
Зураг 9: Үндэсний боловсролын статистик судалгааны салбар.....	53
Зураг 10: Судалгааны чиглэлүүд	57
Зураг 11: Гурван талын хамтын ажиллагаа ба эвсэл.....	57
Зураг 12: Сүүлийн 13 жилийн байдлаар Гурван талт хамтын ажиллагаа	58
Зураг 13: Өртгийн үр дүнгийн шинжилгээний дөрвөн үе шат	61
Зураг 14: Орцын аргын дөрвөн үе шат	61
Зураг 15: Үр ашиг, өртгийн харьцааны томьёо	63
Зураг 16: Өсөн нэмэгдэх үр ашиг, өртгийн шинжилгээний томьёо.....	64
Зураг 17: Цэвэр одоогийн нэмэгдсэн өртөг	64
Зураг 18: Зардал үр дүн, зардал үр өгөөжийн шинжилгээ	67
Зураг 19: Гарын авлагын нүүр хуудас, агуулгын зураг	69
Зураг 20: Гарын авлагын нүүр хуудас, агуулгын хуудасны зураг	71
Зураг 21: Бодлогын институцийн үүрэг ба үр нөлөө.....	74

Зураг 22: Бодлогын судалгааны хүрээлэн буюу тинк танк хэрэгжүүлэх таван үйл ажиллагаа	75
Зураг 23: Жишиг бүтэц зохион байгуулалтын хувилбар	79
Зураг 24: Гурван гол үйл ажиллагааны чиглэл	80
Зураг 25: Чадавхжуулах сургаалтанд зориулсан гурван гарын авлага.....	81
Зураг 26: Үндэсний бодлогын судалгааны тогтолцоог байгуулах хугацааны зураглалын санал.....	84
Зураг 27: Хэлэлцүүлгийн зураг	89
Зураг 28. Семинарын агуулгын жишээ зураг	91
Зураг 29: Сургалтын зургууд	95

I. ТӨСЛИЙН ТОЙМ

1.1. Төслийн үндэслэл

Монгол улсын боловсролын салбар нь 2021 оны статистик мэдээгээр нийт хүн амын 32% буюу 1,094,892 суралцагч, хамрагдагч нарт хүрч үйлчилдэг манай улсын хамгийн их үнэ цэнтэй бөгөөд үр нөлөөтэй салбар юм.¹ 2021-2022 оны хичээлийн жилийн ерөнхий тойм үзүүлэлтээс харвал сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 190,991 хамрагдагчид, ерөнхий боловсролын сургуульд 712353, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад 42,594, их дээд сургууль, коллежид 148954 суралцагчид сурч байна. Энэ ч үүднээс тус салбарт оруулах хөрөнгө оруулалт тасралтгүй нэмэгдэж ирсэн байдаг. Тухайлбал салбарын хөрөнгө оруулалт 2019 онд 488.9 тэрбум төгрөгөөр батлагдаж, 2015 онтой харьцуулахад 5 дахин нэмэгдсэн байна.² Гэхдээ боловсролын салбарт баримталж ирсэн төрийн бодлогын тэргүүлэх зорилтуудын хэрэгжилт хангалтгүй явж ирсэн байдаг. “Монгол Улсын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг судалсан бодлогын судалгааны дүгнэлтийг тоймлон авч үзэхэд дор бичсэн дүр зураглал харагдаж байна.

- СӨБ-ын түвшинд дэвшүүлсэн зорилтуудын 52 хувь нь бүрэн хэрэгжсэн, 36 хувь нь тоон зорилтдоо хүрч хэрэгжээгүй байна,
- Бага, дунд боловсролын чанартай холбоотой 18 зорилтын 38.9 хувь нь бүрэн биелсэн, 16.7 хувь нь хэрэгжилт хангалтгүй, менежменттэй холбоотой зорилтын 50.0 хувь нь хэрэгжээгүй байна.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын хувьд нийт дэвшүүлсэн зорилтуудаас 23.5 хувь нь хангалтгүй, 5.9 хувь нь хэрэгжээгүй байна.

¹ Боловсрол, шинжлэх ухаан, оюуны өмчийн салбарын танилцуулга, Үндэсний статистикийн хороо, 2021 он

² Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030 он, БШУЯ, 2020 он

- Дээд боловсролын салбарт дэвшүүлсэн зарим зорилт огт хэрэгжээгүй байна. Тухайлбал инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, хөдөө аж ахуйн мэргэжлийн чиглэлээр суралцагчдын эзлэх хувийн жинг 29.1 хувиас 45.0 хувь болгож өсгөх зорилтыг тусгасан ч хэрэгжээгүй байна.

Дээр дурдсан баримтаас дүгнэж үзвэл 1990 оны ардчилсан өөрчлөлтөөс хойш тус салбарт хэрэгжсэн бодлого, хөтөлбөрийн үр дүн, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хэрэгжилтэд үнэлгээ хийх, уг салбарын бодлогын уялдаа, залгамж чанарыг сайжруулах асуудал санхүүгийн хомсдол, сонгуулийн үр дүнгээс хамаарсан төрийн албан дахь улс төрийн томилгоо, бодлогын судалгаа, шинжилгээний мэргэжилтэн бэлтгэх, үндэсний боловсролын бодлогын судалгааны дэд бүтцийг хөгжүүлэх асуудал хоцорсон зэргээс шалтгаалан уг салбарын бодлогын бугшсан асуудлууд нь даамжирч, боловсролын үйлчилгээг орчин үежүүлэх, өнөө цагийн хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх ажил хангалтгүй хийгдэж иржээ. Боловсролын бодлогын залгамж холбоо, тогтвортой хөгжлийг хангах үүднээс боловсролын салбарын хөгжилд хувь нэмэр оруулах өндөр мэдлэг бүхий мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх, төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд тасралтгүй үнэлгээ хийж, үр дүнтэй инновацлаг шийдлүүдийг тогтмол боловсруулан гаргадаг бодлогын судалгааны дэд бүтцийг хөгжүүлэх загварыг боловсруулах нь нэн тэргүүний шаардлагатай зүйл гэж үзэж байна. Дээрх нөхцөл байдлын улмаас БШУЯ-ны захиалгаар манай судалгааны баг энэхүү төслийг хэрэгжүүлсэн.

1.2. Төслийн агуулга, зорилго

Монгол улсын боловсролын салбарын бодлого, хөтөлбөрийн үр дүнг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах бодлогын шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйг боловсруулах, түүнчлэн бодлогын судалгааны үндэсний дэд бүтцийг хөгжүүлэх загварыг боловсруулах зорилгоор 2019 оны төсвийн хүрээнд уг төслийн эхлүүлэн 2021 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж дуусгасан. Төслийн үйл ажиллагааны агуулгыг доор үзүүлэв.

Төслийн тойм

Хэтийн зорилго

- Монгол улсын боловсролын салбарын бодлогын судалгааны чадамжыг сайжруулах

Төслийн зорилт

- Боловсролын бодлого, хөтөлбөрт бодлогын шинжилгээ хийх арга зүйг боловсруулах,
- Үндэсний бодлогын судалгааны дэд бүтцийг хөгжүүлэх бодлогын судалгааны хүрээлэн, тинк танк байгууллагуудыг байгуулах зөвлөмж боловсруулан гаргах

Зорилтот үр дүн 1: Боловсролын салбарын үндэсний бодлого, хөтөлбөртэй холбоотой институцийн болон хууль эрх зүйн орчны шинжилгээ хийх

- **Арга зүй:**
 - Чанарын баримт бичгийн шинжилгээний арга
 - Тематик агуулгын шинжилгээний кодлох арга зүй
 - Агуулгын шинжилгээний матрицын арга
 - Судалгаанд суурилсан эх хэрэглэгдэхүүний мета шинжилгээний арга
 - Чанарын судалгааны найдвартай болон хүчинтэй байдлын шинжилгээний гурвалжингийн арга
- **Үйл ажиллагаа**
 - Боловсролын салбарын бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын Хууль эрх зүйн баримт бичгүүдийн агуулгыг тодорхойлох
 - Бодлогын судалгааны улс төр, засаглал, боловсролын институцийн хөгжлийг судлах

Зорилтот үр дүн 2: Үндэсний боловсролын бодлогын судалгааны олон улсын шилдэг туршлагыг судлах

- **Арга зүй**
 - Чанарын судалгааны тематик агуулгын шинжилгээний кодлох арга зүй
 - Чанарын ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын арга (БНСУ-ын Боловсролын хөгжлийн институци, Чусон их сургууль гэх зэрэг газар ажилласан)
 - Агуулгын шинжилгээний матрицийн арга
 - Эх хэрэглэгдэхүүний мета шинжилгээний арга
 - Чанарын судалгааны найдвартай болон хүчинтэй байдлын шинжилгээний гурвалжингийн арга
- **Үйл ажиллагаа**
 - Бодлогын судалгааны институцийн хөгжлийн судалгааны эх сурвалжууд дээр ажиллах
 - БНСУ-ын боловсролын бодлогын судалгааны тогтолцоо хөгжүүлсэн туршлагыг судлах
 - 2019 оны 10.24-11.01 БНСУ-ын томилолтоор ажиллаж туршлага судалсан.
 - 2019 оны 11.30-12.09 хооронд ХБНГУ-д томилолтоор ажиллаж боловсролын бодлогын судалгааны олон улсын болон европийн туршлагаас судалсан

Зорилтот үр дүн 3: Боловсролын бодлого, төсөл хөтөлбөрийн өртгийн үр дүн, өртгийн үр ашгийн үнэлгээ хийх загвар, аргачлал боловсруулах” судалгаа хийх

• **Арга зүй**

- Судалгаанд суурилсан эх сурвалжууд дээр мета шинжилгээний арга судалгаа хийн арга зүй, аргачлалын сонголт хийх
- Өртөг-үр дүнгийн шинжилгээний өмнөх судлагдсан байдалд шинжилгээ хийн эх хэрэглэгдэхүүний сонголт хийх
- Өртөг-үр ашгийн шинжилгээний эх хэрэглэгдэхүүний сонголт хийх
- Өртөг-үр дүн, өртөг-үр ашгийн шинжилгээ хийх загвар, аргачлал боловсруулах судалгаанд хөндлөгийн судлаачдаар үнэлгээ хийлгэх

• **Үйл ажиллагаа**

- Өртгийн үр дүн, өртгийн үр ашгийн талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгаа явуулж өртгийн үр дүн, өртгийн үр ашгийн бүтээл туурвисан гадаадын эрдэмтдийн англи, солонгос хэл дээрх эх сурвалжуудад тулгуурлан эх хэрэглэгдэхүүний судалгаа хийсэн.
- Манай улсын боловсролын салбарын бодлого, хөтөлбөр, төслүүдийн үр нөлөө үнэн зөв тодорхойлоход хэрэгтэй олон улсын туршлага, загваруудыг сонгож энэхүү товч явцын тайланг бичсэн.
- Уг тайлан дээр тулгуурлан тус төслийн ирэх оны төлөвлөгөөнд заасны дагуу өртгийн үр дүн, үр ашгийн шинжилгээний гарын авлагыг дэлгэрэнгүй тайлбар, тодорхой жишээ дасгалуудаар баяжуулан бодлогын шинжилгээний салбарын хүмүүст зориулсан хялбаршуулсан гарын авлагыг бичиж гаргахаар төлөвлөсөн болно.

Зорилтот үр дүн 4: "Боловсрол ба бодлогын судалгааны институтци: Олон улсын туршлага" анхны явцын хэлэлцүүлгийг зохион байгуулах

• **Зорилго**

- Боловсролын салбарын бодлогын судалгааны институт хөгжүүлсэн олон туршлагыг судласан тус төслийн үр дүнг бодлого боловсруулагч, судлаач, олон нийтэд танилцуулах, санал, шүүмжлэл авах

• **Хамрах хүрээ**

- БШУЯ, ШУТСАН, Боловсролын хүрээлэн, их дээд сургуулийн бодлогыг шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч байгууллагууд, бодлогч судлаач, шинжээч, оюутнууд

Зорилтот үр дүн 5: Боловсролын бодлогын шинжилгээ | семинар – 2021

• **Зорилго:**

- Бодлогын шинжилгээний мэдлэг ур чадварыг сайжруулах

• **Хамрах хүрээ**

- Боловсролын хүрээлэн, их дээд сургуулийн бодлогыг шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч байгууллагууд, бодлогч судлаач, шинжээч, оюутнууд

Зорилтот үр дүн 6: Түгээн дэлгэрүүлэх “демо” арга хэмжээ

- Зорилго
- Боловсролын салбарын бодлогын судалгаа хийх арга зүйг түгээн дэлгэрүүлэх
- Хамрах хүрээ
- Их дээд сургууль, боловсролын байгууллагуудын бодлогын судлаач, шинжээч нар сургалт, семинарт хамруулах

Зорилтот үр дүн 7: Зардал-үр дүн, зардал үр өгөөжийн шинжилгээ хийх арга зүйн гарын авлага хийх

- Зорилго:
- Боловсролын салбарын бодлого, хөтөлбөрийн үр дүн, үр өгөөжд эдийн засгийн үүднээс бодлогын шинжилгээ хийх үр чадварыг сайжруулах
- Агуулга
- Зардал үр дүн, зардал үр өгөөжийн шинжилгээний арга зүй, жишээ танилцуулга

Зорилтот үр дүн 8: Боловсролын салбарын төсөл хөтөлбөрт туршилтын болон туршилтын бус аргаар үнэлгээ хийх чанарын ба тоон аргын гарын авлага бичих

- Зорилго
- Бодлогын судлаач, шинжээчдын чанарын болон тоон судалгааны арга хэрэглэх мэдлэг, үр чадвар, хандлагыг сайжруулах
- Агуулга
- Түүврийн стратеги, натуралист чанарын судалгааны арга, туршилтын болон туршилтын бус судалгааны арга

Зорилтот үр дүн 9: Квази туршилтын судалгааны гарын авлага бичих

- Зорилго
- Бодлогын судлаач, шинжээчдын квази буюу хагас туршилтын судалгааны арга хэрэглэх мэдлэг, үр чадвар, туршлагыг сайжруулах
- Агуулга
- Тасалж авсан хугацааны цуваа цагийн шинжилгээ, Квази туршилтын шинжилгээ

Зорилтот үр дүн 10: Бодлогын шинжилгээний арга зүйн дижитал контент хийх

- Зорилго
- Боловсролын салбарын бодлогын судлаач, шинжээчдын мэдлэг, үр чадварыг дэмжих сургалтын эх сурвалжын хүртээмжийг нэмэгдүүлэх
- Агуулга
- Зардал үр дүн, зардал үр өгөөж, туршилтын болон туршилтын бус арга зүй, квази буюу хагас туршилтын арга зүй

Зорилтот үр дүн 11: Бодлогын зөвлөмж

- Зорилго
- Бодлогын судалгааны үндэсний тогтолцоог хөгжүүлэх зөвлөмж бичих
- Агуулга
- Бодлогын судалгааны хүрээлэн буюу “тинк танк” байгуулсан олон улсын туршлага, Монгол улсад хөгжүүлэх бодлогын санал, зөвлөмж бичих

1.3. Төсөл хэрэгжүүлсэн бүтэц, зохион байгуулалт

Хүний хөгжил судалгаа, сургалтын төвийн удирдлага дор Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Бизнесийн ахисан түвшний сургууль (БАТС), Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль (БуХС) багш нарын мэргэжлийн багтай гэрээ байгуулан төслийг хэрэгжүүлэх манлай баг байгуулагдан ажилласан. Хүний хөгжлийн судалгаа сургалтын төвийн удирдлагын баг дээрх манлай баг(МБ)тай нягт хамтран ажиллаж, тогтсон хугацаанд төслийн байнгын хурлыг хуралдуулж, уулзалдаж төслийн үйл ажиллагааг удирдан явуулсан. Мөн Хүний хөгжил судалгаа, сургалтын төвөөс Монголын үндэсний техникийн их сургууль (МУТИС) болон зарим хувийн хэвшлийн байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллах гэрээ байгуулан бодлогын судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай симуляцын өрөө түрээслэх, судалгааны программ хангамж авах, техникийн болон хүний нөөцийн туслалцаа авах аутсорсингийн үйлчилгээ авч ажилласан. Хүний хөгжил судалгаа, сургалтын төв, ШУТИС-ийн БАТС, БуХС-ийн төлөөллөөс бүрдсэн төслийн хамтарсан удирдлагын баг(УБ)-ийг байгуулж, төслийн ажлын явцыг хянах болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах үйл ажиллагаануудыг зохион байгуулж ажилласан.

Хүснэгт 1: Төслийн хамтарсан удирдлагын баг

№	Овог нэр	Удирдлагын багийн чиг үүрэг	Эрхэлж буй албан тушаал
1.	Ганхуягийн Цэрэнжаргал	Ахлагч	Хүний хөгжил судалгаа, сургалтын төвийн гүйцэтгэх захирал
2.	Гүрбазарын Баттүвшин	Гишүүн	ШУТИС-ийн БАТС-ийн захирал
3.	Юрагийн Энхжаргал	Хяналт шинжилгээ хариуцсан зөвлөх	Хүний хөгжил судалгаа, сургалтын төвийн менежер
4.	Баатарын Болормаа	Үйл ажиллагаа хариуцсан гишүүн	ШУТИС-ийн БуХС-ийн ахлах багш

Хүснэгт 2: Төслийн манлай баг

№	Овог нэр	Чиг үүрэг	Эрхэлж буй албан тушаал	Эрдмийн зэрэг, цол
1.	Гүрбазарын Баттүвшин	Ахлагч	ШУТИС-ийн БАТС-ийн захирал	Доктор, профессор
2.	Чойжилын Баасандаш	Бодлогын судалгааны зөвлөх	ШУТИС-ийн БАТС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга	Доктор, профессор
3.	Мижиддоржийн Банзрагч	Эконометрикийн зөвлөх	ШУТИС-ийн БАТС-ийн дэд захирал	Доктор, дэд профессор
4.	Баатарын Болормаа	Үнэлгээ, хяналт шинжилгээ, нийгмийн бодлогын зөвлөх	ШУТИС-ийн БУХС-ийн ахлах багш	Доктор
5.	Чулуунбатын Должинсүрэн	Боловсрол судлалын зөвлөх	ШУТИС-ийн БУХС-ийн ахлах багш	Доктор

1.4. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө


2019 оны 6 дугаар сараас 2021 оныг дуустал Монгол улсад төслийн үйл ажиллагаа явагдана. Төслийг дараах 4 үе шатад хувааж, үйл ажиллагааны агуулга, зорилгыг тодорхойлсон. Үүнд:

- Төслийг санаачлах
- Төслийн төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлуулах
- Төслийн зорилтуудыг хэрэгжүүлэх
- Төслийн тайлан бичих, хүлээлгэн өгөх

Төслийн үйл ажиллагааны үе шат дуусах бүрд УБ ээлжит хурлыг зохион байгуулж, МБ-ийн хэрэгжүүлсэн төслийн явцыг нягтлан шалгаж, ажлын төлөвлөгөөний талаар хянан хэлэлцэж ирсэн.

Зураг 1: Төслийн календарчилсан төлөвлөгөө

Календарчилсан төлөвлөгөө



II. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ҮНДЭСНИЙ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ ИНСТИТУЦИЙН БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

1.1. Удиртгал

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны зүгээс манай улсын бүх шатны боловсролын дэд салбаруудад хэрэгжүүлж буй төрийн бодлого, төсөл, хөтөлбөрүүдийн өнөөгийн байдал, явц, үр дүн, түүнчлэн цаашид хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий бодлого, хөтөлбөрийн талаар шинжлэх ухааны үндэслэлтэй өгөгдөл, мэдээлэл, нотолгоонд тулгуурлан олон талаас нь үнэн зөв тодорхойлж, бодлогын хувилбаруудыг боловсруулан гаргах үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд анхаарал тавин ажиллах болжээ. Нэн ялангуяа олон улсын жишигт нийцүүлэн Монголын Улсын боловсролын салбарын бодлогын судалгааны чадамжийг сайжруулах, бодлогын судалгааны арга зүй, дэд бүтцийг хөгжүүлэх тал дээр ихээхэн ач холбогдол өгөн ажиллаж байна.

2018 оны 1 дүгээр сарын 18-24-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан БСШУСЯ-ны “Тогтвортой хөгжил - Ерөнхий боловсрол” улсын хоёрдугаар зөвлөгөөн дээр нэр томьёо, үг үсгээр хөөцөлдсөн өөрчлөлт хэрэггүй, боловсролын аливаа ноу-хау, инновац, технологийн туршилтыг шууд сургууль, хүүхдүүд дээр хийгээд байх тийм бодит шаардлага байхгүй, харин боловсролын бодлого, хөтөлбөрүүдийг шинжлэх ухаанчаар, мэргэжлийн түвшинд үнэлэх, хөгжүүлэх арга хэрэгсэл, багаж, тогтолцоог хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага манай улсын боловсролын салбарт гарч ирээд буйг онцлон тэмдэглээд, салбарын яамны зүгээс уг асуудалд онцгой анхаарал тавьж тодорхой зорилтууд тавин ажиллаж байна гэж мэдэгдсэн байдаг. Манай төслийн баг шинжлэх ухаанчаар бодлогын шинжилгээ, үнэлгээ хийх БСШУСЯ-ны дэвшүүлсэн зорилтыг төслийн үндсэн зорилгоор сонгон ажиллаж байна.

Сайн хууль эрх зүй орчин, түүний хэрэгжилтийг дэмжсэн институцийн сайн тогтолцоо нь бодлого, хөтөлбөрийн төлөвлөсөн үр нөлөөний хэрэгжилтийг тодорхой болгох, аюулгүй хэрэгжүүлэх, хэрэгжилтийн уян хатан нөхцөлийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг. Эсрэгээр нь тааруу загвараар хийсэн, хэрэгжилт нь муу хууль, эрх зүйн зохицуулалт нь бодлогын үр нөлөөг хязгаарлах, идэвх санаачилгыг дарагдуулах, засгийн газрын бодлогын

оролцоо, шийдлийг үр дүнгүй болоход хүргэдэг. Тийм ч учраас үндэсний бодлого, хөтөлбөрийг тодорхойлох, хэрэгжилтэд шинжилгээ хийх хууль эрх зүй орчин, институцийн хөгжлийн өнөөгийн байдалд шинжилгээ хийх даалгавраас манай төслийн багийн судалгааны ажлын үйл ажиллагаа эхэлж байгаа болно.

1.2. Судалгааны арга зүй

Монгол Улсын үндэсний бодлогын бичиг баримтууд, хууль, эрх зүйн зохицуулалтууд, бодлогын судалгааны институцийн хөгжил боловсролын салбарын бодлогын судалгааны хөгжилд үзүүлж буй үүрэг, үр нөлөөнд шинжилгээ хийхдээ чанарын баримт бичгийн шинжилгээний арга, судалгаанд суурилсан эх хэрэглэгдэхүүний судалгааны арга, свот үнэлгээний арга, чанарын судалгааны найдвартай болон хүчинтэй байдлын шинжилгээний гурвалжны аргуудыг хэрэглэсэн.

Тус судалгааны асуудалтай хамааралтай хууль эрх зүй, институцийн өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийхтэй доорх үе шатуудаар ажилласан.

1. Боловсролын салбарын бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэхдээ холбоотой Монгол Улсын Хууль эрх зүйн баримт бичгүүдийн агуулгыг тодорхойлох.

Энэ зорилтыг хэрэгжүүлэхдээ “Төрийн бодлого, хөтөлбөрийг тодорхойлох, боловсруулах, сонгохтой холбоотой харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн тогтолцоо юу вэ?” гэсэн асуулт тавин ажилласан. Мөн “Засгийн газрын бүтэц дотор боловсролын салбарын бодлого, хөтөлбөрийг тодорхойлох, боловсруулах, сонгох, хэрэгжилтэд үнэлгээ, шинжилгээ хийх үйл ажиллагаа, үүрэг хариуцлага хэрхэн хуваарилагдсан байдаг вэ” гэсэн асуулт дэвшүүлэн ажилласан болно.

2. Бодлогын судалгааны улс төр, засаглал, боловсролын институцийн хөгжил

Хууль, эрх зүйн зохицуулалтуудын агуулгын үр нөлөө нь бодлогын судалгааны хөгжил, түүний төрийн бодлогод нөлөө үзүүлэх хүч, чадамжид нөлөөлөх хүчин зүйлсийн зөвхөн нэг тал юм. Мөн тухайн улс орны улс төрийн нөхцөл, төрийн засаглалын хэлбэр, боловсролын тогтолцооны одоогийн бодит орчинд бодлогын судалгааны хууль, эрх зүйн орчны үр нөлөө нь хэр үр дүнтэй гарч байна вэ гэдэгт бодлогын дүн шинжилгээ хийх нь чухал байдаг. Нэн ялангуяа тухайн үеийн улс төрийн хөгжлийн төрх, засаглалын зан үйл, боловсролын тогтолцооны үр ашигтай

байдлаас хамаараад боловсролын бодлогын судалгааны хөгжлийг дэмжихэд чиглэсэн хууль, эрх зүйн орчин төрийн бодлогын үр дүн, оновчтой байдалд хэр хэмжээнд үр нөлөө үзүүлж байгааг тодорхойлох, илрүүлэх үнэлгээг хийх хэрэгтэй байдаг. Хэд хэдэн улс төр, засаглал, боловсролын институцийн хүчин зүйлсийн нөлөөгөөр хууль, эрх зүйн гадаад институцийн тогтолцоо бүрэн үр нөлөөгөө үзүүлэхгүй байх эсхүл хүсээгүй үр нөлөөнүүд гарч болно. Тиймээс хууль, эрх зүйн орчны шинэчлэлийн үр нөлөө гарахад сөргөөр нөлөөлж буй улс төр, засаглал, боловсролын институцийн хүчин зүйлс байгаа эсэхэд дараах шалгууруудыг хэрэглэн шинжилгээ хийсэн.

- **Улс төрийн хүсэл зориг дутах хүчин зүйл байгаа эсэх:** Бодлогын өөрчлөлт, шинэчлэлт хийх үйл хэрэгт засгийн газар тууштай, хараат бус байр сууриа хамгаалж чадаагүйгээс үүдэн хууль эрх зүйн орчны үр нөлөө суларч болно. Ийм нөхцөл байдал төрийн эрх мэдэл, манлайлал сулрах үед санхүүгийн элитүүд, сонирхлын бүлгүүд төрийн бодлого, хөтөлбөрт үзүүлэх нөлөө нэмэгдсэнтэй холбоотой байж болно.
- **Бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх өртгийг урьдчилан тогтоож чадахгүй байх хүчин зүйл үүсэх эсэх.** Хэрэгжилтийн өртгийг урьдчилан сайтар төлөвлөөгүй эсхүл тодорхойгүй нөхцөлд дотоод уялдаа холбоо сайтай, техникийн хувьд сайн бичигдсэн, том зорилт тавьсан хуулиуд батлагдах тохиолдол байдаг. Тухайлбал өргөн тархацтай байгалийн баялгийн нөөцийг ашиглан гарсан эдийн засгийн өсөлтөөс орж ирсэн орлогыг боловсролын салбарыг хөгжүүлэх санхүүгийн нөөцийг бүрдүүлэх, удирдан хянах засгийн газрын чадамжийн талаар бодит бус хүлээлтийг үүсгэж болох хууль батлагдаж болно. Хууль эрх зүйн орчин нь үр нөлөө үзүүлэхийн тулд засгийн газрын одоогийн бүтэц дотор байхгүй институцийн тогтолцоог байгуулахад шаардлагатай санхүү, хүний нөөцийг бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байдаг. Ийм нөхцөл байдлаас үүдэн хууль эрх зүйн орчин гол үр нөлөөгөө өгч чадахгүй байдалд хүрэх эсхүл хэлбэр төдий хэрэгжилтийг хангаж ажиллах тохиолдол байдаг.
- **Олон талын оролцогч талуудын хуулийн ойлголтыг сайжруулах ажил орхигдсон эсэх.** Хуулийн агуулга, үйл явцын талаар засгийн газрын гишүүд, төрийн албан хаагч нарт боловсрол олгох ажилд алдаа гаргасан байж болдог. Үүний үр дүнд хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн албан тушаалтнууд хуулийн шаардлагыг буруу хэрэгжүүлэх тохиолдол үүсдэг. Мөн засгийн газар чухал хуулиудын загварыг гаргахад иргэний нийгмийн оролцоог хангаж

ажиллахгүй байх эсхүл шинээр гарсан хуулийн агуулгын талаар хүмүүст боловсрол олгохгүй байх тохиолдол багагүй гардаг. Үүний үр дүнд хууль, эрх зүйн орчны шинэчлэлийн шууд нөлөөллийн хүрээнд хамаарах бүлэг эсхүл хувь хүмүүсийн хуулийн үр нөлөөний хэрэгжилтэд үзүүлэх дэмжлэг алдагдах, мөн хэрхэн шинэ хуулийг дагаж мөрдөх эсхүл шинэ хуулийн давуу тал боломжийг ашиглахгүй байх тохиолдол байна.

1.3. Хууль, эрх зүйн агуулгын шинжилгээ

1.3.1. Боловсролын бодлогын судалгааны хууль эрх зүйн баримт бичгүүдийн агуулгын шинжилгээ

Боловсролын салбарын бодлогын судалгааны хөгжлийг дэмжих, хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйгээр салбарын асуудлуудад шинжилгээ хийж, салбарын төрийн бодлогыг шинжлэх ухаанчаар тодорхойлох, сонгох соёл, зан үйл, тогтолцоог бүрдүүлэхэд төрийн анхаарал, үйл ажиллагааг чиглүүлж өгсөн хамгийн чухал хууль бол “Хөгжлийн бодлого,

Төрийн бодлогыг шинжлэх ухаанчаар оновчтой тодорхойлох, сонгох шаардлагыг тавьсан хамгийн чухал суурь хууль нь “ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХУУЛЬ” болно.

төлөвлөлтийн хууль” болно. Уг хуулиас гадна салбарын төрийн бодлого, хөтөлбөрийн чанарыг шинжлэх ухааны хүлээн зөвшөөрөгдсөн судалгаа шинжилгээний үр дүн, бодлогын

шийдлийн хувилбаруудыг боловсруулах чадамжийг дээшлүүлэхэд хууль, бодлогын үр нөлөө нь шаардсан хэд хэдэн хууль, журмуудын зохицуулалтууд гарсан байна. Тухайлбал “Хууль тогтоомжийн тухай” хууль (2016), “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал” (2016), “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014 – 2024” (2015), “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”(2016 он), “Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө 2016-2020”.

1.3.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн агуулга

2015 онд Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шатыг сайжруулах, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын дагуу төрийн бодлогын

чанарын асуудлыг шийдвэрлэхээр Монгол Улсын Их Хурал “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай” хуулийг батлан гаргасан. Уг хууль дотор боловсролын салбарт чиглэсэн төрийн бодлого, хөтөлбөр, төслүүдийг үр дүнтэй төлөвлөн хэрэгжүүлэх, бодлогын шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаатай холбоотой буюу хамаарах хэд хэдэн чухал заалтууд орсон байна.

Уг хуулийн зарим гол онцлог зүйл заалтуудыг хүснэгт 3-т хураангуйлан бичсэн болно. Мөн тухайн онцлог зүйл, заалтуудын зорилгын хүрээнд Монголын Улсын төрийн бодлогын судалгаа, шинжилгээний орчинд гарах ёстой үр нөлөөнүүдийг хүснэгтийн хоёр дахь баганад оруулж бичсэн. Сүүлийн баганад тухайн онцлогуудын үр нөлөө боловсролын салбарын нийтийн бодлогын асуудлыг сонгох, боловсруулах үйл явцад хэр үр дүнтэй хэрэгжиж буй талаар дүн шинжилгээг бичсэн.

Хүснэгт 3: Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн онцлог зүйл, заалт

Онцлог зүйл, заалт	Зорилго, гарах үр нөлөө	Үр нөлөө
5.1.4.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх	Бодлогын шинжилгээний үр дүнд нийтийн бодлогын асуудал, шийдлийг цогц байдлаар тодорхойлох	Боловсролын бодлогын бугшсан асуудлуудын гүнд орохгүй шинж тэмдэг дээр оношилгоо хийсээр байна.
13.4.Бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулахдаа судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх ба бүс нутгийн хөгжлийг хангах зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх үе шатыг тодорхойлсон байна.	Бодлогын шинжилгээний үр дүнд тулгуурлан бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлдог болох	Орон нутаг, хязгаар нутаг дахь боловсролын чанар, хүртээмжийн ялгаатай тэгш бус байдлыг бууруулах, нийгэм, зах зээлийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг сайжруулахын зорилгоор шинжлэх ухаанчаар бодлогын судалгаа явуулах бүс нутгийн бодлогын судалгааны төвүүд хөгжөөгүй байна.
17.1.1.хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлох, холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх;	Нийгэм, эдийн засгийн амьдралд буй асуудлуудад шинжлэх ухаанчаар шинжилгээ хийж, жинхэнэ нийтийн бодлогын асуудлыг тодорхойлдог болох соёлыг төлөвшүүлэх	Боловсролын салбарын нийтийн боловсролын асуудлуудыг тодорхойлох өнгөрсөн, одоо, ирээдүйг хамарсан бодлогын шинжилгээний цуваа болон хам цагийн тасралтгүй хийгдсэн нэг эх үүсвэртэй судалгааны өгөгдлийн сан, мэдээлэл, түүнийг зохион байгуулах институц байхгүй хэвээр байна.
17.1.2.асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах	Нийгэм, эдийн засгийн харилцаанд салбарын	Боловсролын салбарын бодлогын асуудлууд, тэдгээрийн

<p>үр дүн, үр нөлөөг эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөлд үндэслэн бодлогын хувилбарыг боловсруулах;</p>	<p>нийтийн бодлогын асуудлыг тодорхойлж, тухайн асуудлуудыг шийдвэрлэх бодлогын шийдлүүдийг нийгэм, зах зээлийн баримжаатай сонгодог болох соёл, тогтолцоотой болох</p>	<p>шийдлүүдийг тодорхойлох бодлогын шинжилгээний үйл явцад нийгмийн хэрэгцээ, зах зээлийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан хийх үр дүнтэй бодлогын судалгааны тогтолцоо эсхүл зохион байгуулалт хангалттай бүрдээгүй байна. Тухайлбал дээд боловсролын салбар нийгэм, эдийн засгийн үр нөлөөтэй болж амжаагүй байна. Дунд боловсролыг дүүргэсэн залуус хөдөлмөрийн зах зээлд нийцсэн ажил, мэргэжлийн сонголт хийх хэвшил, зан үйл тогтоогүй байна.</p>
<p>17.1.4.хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөж боловсруулна.</p>	<p>Нийтийн бодлогын оновчтой хувилбарт тулгуурлан салбарын зорилго, зорилт, хүрэх үр дүн, хэмжүүрүүд, цаг хугацаа, нөөцийг зөв тодорхойлдог соёл, хэм хэмжээг төрд тогтоох</p>	<p>Боловсролын салбарт энэ зорилго хоёр хүчин зүйлийн нөлөөнөөс үүдэн хэрэгжилт нь хангалтгүй байна. 1. Улс төрийн оноо авахын тулд асуудлыг шийдэх бус, шинж тэмдэг дарах зорилго, зорилт тавьж байна. 2. Шалгуур үзүүлэлт, хэмжүүр учир дутагдалтай, улс төрийн шийдэлд зориулан хийгдэж байна.</p>
<p>22.2.Төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын бодлогын залгамж чанарыг хадгалах зорилгоор өмнө хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг нэгтгэсэн эмхэтгэлийг жил бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэвлэн нийтэлнэ.</p>	<p>Төрийн бодлого хэрэгжиж эхэлсэн үеэс эхлээд түүний үр нөлөө нийгэм, эдийн засгийн орчинд гарч эхэлж буйд шинжлэх ухаанчаар дүн шинжилгээ, үнэлгээ хийж засаж сайжруулах бодлогын хувилбаруудын сонголтыг боловсруулдаг тогтолцоо, зохион байгуулалтыг бүрдүүлэх</p>	<p>Боловсролын салбарт БСШУСЯ-ны сонгож, батлуулан хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөрийн үр дүн нөлөөнд аудитын үнэлгээ хийх ажил хийгдэж байгаа боловч шинжлэх ухаанч төрийн бодлогын шинжилгээ, үнэлгээ хийж, засаж сайжруулах хувилбар боловсруулах, судалгааны үр дүн, өгөгдлийг олон нийтэд тогтвортой, нээлттэй мэдээлэх үүрэг, зохион байгуулалт, тогтолцоо үр дүнтэй хөгжөөгүй байна.</p>

1.3.3. “Хууль тогтоомжийн тухай” хууль ба бусад хууль тогтоомжуудын агуулгад хийсэн шинжилгээ

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиас гадна Монголын Улсын төрийн бодлогыг шинжлэх ухаанчаар боловсруулж хийх соёл, тогтолцоо, хүний нөөц, туршлага, ур чадвар

ёс зүй манай улсын дотоод улс төр, төрийн албаны тогтолцоонд төлөвшин хөгжих зохион байгуулалт, тогтолцоо бүрэлдэн хөгжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хэд хэдэн хууль, журам, төрөөс баримтлах эрх зүйн баримт бичгүүд гарсан байдаг. Харин энэ хуулиуд, журмууд, төрөөс баримтлах эрх зүйн бусад бичиг баримтууд тавьсан зорилго, зорилтуудаа хэрэгжүүлж чадаж байгаа эсэх асуудал нь бодлогын шинжилгээний хувьд ач холбогдол өндөртэй асуулт юм.

Боловсролын салбарын бодлогын судалгааны хөгжлийг дэмжихэд чиглэсэн төрийн хууль, журам, бодлогын баримт бичгүүдийн онцлох заалтуудад хийсэн бодлогын шинжилгээний дүн шинжилгээнүүдийг хүснэгт 4-т харуулсан болно. Уг хүснэгт гурван баганатай бөгөөд нэгдүгээр багана ямар хууль, журам, бодлогын баримт бичиг болохыг харуулсан. Хоёр дахь багана тухайн хуулийн ямар зүйл, ямар хэсэг, ямар зорилго, зорилтууд дэвшүүлсэн тухай харуулсан. Гурав дахь багана тухайн, хууль, журмын зорилтууд боловсролын салбарт хэр үр дүнтэй хэрэгжиж, үр нөлөө нь хэр гарсан бэ гэдэгт дүн шинжилгээ хийсэн бодлогын шинжилгээний үр дүнг харуулахыг зорьсон.

Хүснэгт 4: Бусад хууль, журам төрийн бодлогын зорилго, үр нөлөө

Хууль эрх зүй	Зорилго, гарах үр нөлөө	Үр нөлөө
“Хууль тогтоомжийн тухай” хууль	4.1.4.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх.	Боловсролын салбарын нийтийн бодлогын асуудал, шийдлүүдийн хувилбарыг сонгоход цуваа цагийн судалгааны өгөгдөл байхгүй тул хам цагийн захиалгат богино хугацааны судалгааны үр дүнд тулгуурлан бодлогын сонголтыг хийж байгаа нь учир дутагдалтай байна.
“Хууль тогтоомжийн тухай” хууль	13 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах 14.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна.	Боловсролын салбарт гарч ирсэн асуудал үнэхээр төрийн бодлогын асуудал эсэхийг тодорхойлоход шаардлагатай бодлогын судалгаа, шинжилгээний үр дүнд бий болсон өгөгдөл болон бэлэн бодлогын хувилбаруудыг хомс хэвээр байна.

<p>“Хууль тогтоомжийн тухай” хууль</p>	<p>14.2.3.хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал;</p>	<p>Боловсролын салбарт боловсролын нийтийн бодлого, хөтөлбөр батлагдан хэрэгжиж эхэлсний дараа тухайн бодлого, хөтөлбөрийн хүлээсэн үр нөлөөг нийгэм, эдийн засагт үзүүлж эхэлсэн эсхүл буруу үр дүн гарч байгаа эсэхэд дагаж мөшгөсөн судалгааг бодлогын судалгааны арга зүй, шалгуурт нийцүүлэн тасралтгүй бодлогын шинжилгээ, судалгаа хийх тогтолцоо манай улсын боловсролын салбарт байхгүй байна.</p>
<p>Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014 – 2024</p>	<p>1.3.1.боловсролыг хөгжүүлэх бодлого, стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, мэргэжлийн холбоо, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, иргэний оролцоог хангах;</p>	<p>Боловсролын салбарын нийтийн бодлогыг боловсруулахад засгийн газрын бус бодлогын судалгааны байгууллагууд, бодлогын судлаачид, бодлогын шинжилгээ хийдэг иргэдийн оролцоог төдий хангаж ажиллах тал дээр хэлэлцүүлэгт оролцуулах, ажлын хэсэгт оролцуулах гэх мэт хэлбэр төдий оролцоог хангаж ажиллаж байна.</p>
<p>Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014 – 2024</p>	<p>1.3.2.боловсролын талаар шийдвэр гаргах үйл явц нь нээлттэй, ил тод, судалгаа, нотолгоонд суурилсан, сайн засаглалын зарчимд нийцсэн байх;</p>	<p>Боловсролын салбарын нийтийн бодлогын судалгааны үр дүнг нээлттэй, ил тод болгох, нотолгоонд суурилсан бодлогын шинжилгээний ажлын үр дүнг хүрэлцээтэй болгох, шинжлэх ухаанчаар төрийн бодлогын асуудлыг тодорхойлох, төрийн бодлогын хувилбаруудыг сонгодог байх зарчим бүрэн төлөвшиж хөгжихгүй байна.</p>
<p>Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014 – 2024</p>	<p>1.3.5.боловсролын салбарын удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг өргөтгөх.</p>	<p>Монгол Улсын боловсролын салбарын салбарын удирдлагын нэгдсэн тогтолцоог хөгжүүлэхэд бодлогын судалгааны институцийн өгөгдөл, мэдээлэл, зөвлөмж, менежментийг төсөөлөх аргагүй байхад ийм тогтолцоо үүсэж хөгжөөгүй байна.</p>
<p>Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014 – 2024</p>	<p>2.1.8.иргэдийн насан туршид суралцах хэрэгцээ, суралцагчийн сонирхол, авьяас, чадвар, хөгжлийн онцлогт нийцсэн, тэдэнд тэгш</p>	<p>Боловсролын салбарын төрийн бодлогын асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлогын шийдлүүдийн хувилбаруудыг бэлдэх төрийн</p>

	боломж олгосон, олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байх;	болон төрийн бус бодлогын судалгааны институцүүдыг үүсгэх, хөгжүүлэх, оролцоог хангах асуудал бүрэн орхигдсон байна.
Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014 – 2024	Боловсролын хөгжлийн стратегийг тодорхойлох, нийтлэг зохицуулалт хийхэд зөвлөх эрх бүхий мэргэжлийн гишүүдээс бүрдсэн боловсролын зөвлөлийг байгуулж, тогтвортой ажиллуулна.	Боловсролын хөгжлийн стратегийг тодорхойлох, зохицуулалт хийхэд хамгийн их үр нөлөөтэй оролцох мэргэжлийн гишүүдээс бүрдсэн боловсролын зөвлөлийг оновчтой зөвлөгөө өгөхөд бодлогын судалгааны мэдээлэл, өгөгдөл, бодлогын хувилбараар хангах институт бүрэн төлөвшиж хөгжөөгүй байна.
Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014 – 2024	7.5.Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хоёр жил тутам Монгол Улсын Засгийн газар Улсын Их Хуралд тайлагнаж, боловсролын чанарын үр дүнд тогтмол үнэлэлт, дүгнэлт өгч байна.	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хоёр жил тутам Монгол Улсын Засгийн газар Улсын Их Хуралд тайлагнаж байгаа боловч төрийн байгууллагын ажлын гүйцэтгэлийн захиргааны шинжтэй үнэлгээ хийхийн зэрэгцээ нийгэм, эдийн засагт үзүүлж үр нөлөөний тухай бодлогын шинжилгээ хийгдэхгүй байна.
“Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”(2016 он)	9.1.4. гадаадын тусламжийн гэрээ, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан холбогдох судалгаа, баримтын хамт гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;	Гадаадын тусламж, гэрээ хэлэлцээрийн хүрээнд боловсролын салбарын нийтийн бодлогын асуудлуудыг тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэхэд шаардлагатай бодлогын шийдлийг олох, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох бодлогын шинжилгээний тогтвортой тогтолцоо хөгжөөгүйн улмаас түр зуур гал унтраах хэлбэрээр гадаад, дотоодын экспертүүдийг хөлсөлж ажиллах эсхүл бодлогын судалгааны институтийн олон талын эх сурвалж бүхийн хүчинтэй, найдвартай бодлогын шинжилгээний өгөгдөл, мэдээлэл, зөвлөмжгүйгээр

		гадаадын тусламжийг зарцуулах боловсролын салбарын бодлого, хөтөлбөр учир дутагдалтай гарах, бодлогын асуудлыг дорвитой шийдвэрлэж чадахгүй болох тохиолдол их байна.
“Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө 2016-2020”	3.3.4.Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн хөдөлмөрийн эрэлт, ур чадвар, мэргэшлийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх тогтолцоог хөгжүүлнэ.	Боловсролын салбарт дэлхийн хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хөдөлмөр эрхлэх ур чадварыг олгох асуудлыг зөв тодорхойлоход шаардлагатай дотоодын болон дэлхийн хөдөлмөрийн зах зээлийн тулгамдсан асуудлуудыг судалж нийтийн боловсролын анхаарлын төвд орох ёстой асуудлуудыг тодорхойлох, сургалтын хөтөлбөрүүдийг хөдөлмөрийн зах зээлийн баримжаатай хөгжүүлэх бодлогын дэмжлэгийн шийдлүүдийг илрүүлэх үйл ажиллагааг тогтвортой явуулдаг бодлогын судалгааны тогтолцоо хөгжих шаардлагатай байна.

1.4. Бодлогын судалгааны улс төр, засаглал, боловсролын институцийн хөгжил

1.4.1. Өнөөгийн улс төрийн тогтолцооны төрх ба бодлогын судалгааны институцийн хөгжил

1990 оны үед Ардчилсан хөдөлгөөн өрнөж Монгол оронд ардчилсан хувьсгал гарч жинхэнэ утгаараа төрийн бодлогын асуудлуудыг тодорхойлох, бодлогын шийдлүүдийг сонгох эрх мэдэл ард түмний гарт очих сайхан нөхцөл бүрдлээ гэж ярьж байсан байдаг. Гэтэл ардчилсан хувьсгал ялж нийгмийн өөрчлөлт гарч, чөлөөт зах зээлийн эдийн засгийн шинэ хэлбэрт шилжсэн тэр үеэс хойш бараг 30 жил өнгөрсөн боловч Монгол Улсад “ардын засаг” хөгжиж, бүрэлдэн бий болоогүй байна. Харин нийгмийн сайн, сайхны төлөө үйлчлэх нийтийн бодлогыг хамгаалдаг ардын засгийн оронд улс төр, санхүүгийн эрх мэдэл ихтэй элитүүдийн ашиг сонирхолд үйлчилдэг төрийн засаглал бий болжээ. Сүүлийн үеийн судалгааны үр дүнгүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд Монгол Улсын иргэдийн дийлэнх хэсэг нь манай орон улс төр, эдийн засгийн буруу замаар хөгжиж байна гэсэн дүгнэлт

хийсэн байдаг. Тухайлбал 2017 оны ОУ-ын бүгд найрамдахчуудын институтийн судалгаанаас харахад дийлэнх хүмүүс буюу судалгаанд оролцсон хүмүүсийн 61% нь буруу хөгжлийн замаар хөгжиж байна гэсэн дүгнэлт хийсэн байдаг.

Зураг 2. Улс төр, хөгжлийн буруу зам руу чиглэж буйг илтгэх баримтууд



Эх сурвалж: Олон улсын бүгд найрамдахчуудын судалгаа 2017 он

Монголын улс төрийн намын тогтолцооны бодлогын буруу сонголт, түүнээс улбаалан бүрэлдэн тогтсон улс төрийн намуудын буруу төлөвшил нь улс төр, төрийн албан дахь сонирхлын бүлгийн ноёрхол, эдийн засгийн тогтворгүй хөгжил, тэгш бус байдлын өнөөгийн таагүй нөхцөл байдал үүсэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл гэж үзэх явдал Монголын



2010 он



2017 он

Улс төрийн намууд - хамгийн их авлигад автсан байгууллага

иргэдийн дунд хамгийн их хувийг эзэлж байна. Трансперенси Интернешнл байгууллагын 2016 оны судалгаагаар хамгийн их авлигад автсан төрийн байгууллага дотор улс төрийн намууд 2010 онд тавдугаар байранд орж байсан бол 2017 онд хоёрдугаар байранд орсон байна. 2017 онд парламент 4 дүгээр байр,

үндэсний засгийн газар 5 дугаар байранд орж байсан байна(Азийн хөгжлийн сан 2017а). 2006 хойш одоог хүртэл судалгаанд оролцсон хүн амын 90 хувь авлигал энгийн үзэгдэл болсон гэж хариулж байна. Дэлхийн авлигын барометр үнэлгээнд оролцсон хүмүүсийн 46% нь хууль тогтоох байгууллага дахь ард түмний төлөөлсөн парламентын гишүүдийн ихэнх

эсхүл бүгд авлига авдаг гэж хариулсан байна(Трансперенси Интернешнел 2017). Энэ бүх баримтууд нь Монгол Улсын төрийн бодлогын сонголт хийх үйл явцад хамгийн үр нөлөө үзүүлэх боломжтой тоглогч болох улс төрийн намуудын тогтолцооны гажуудал нь үндэсний хэмжээнд бодлогын судалгааны институц хөгжихөд ямар үүрэг, үр нөлөө үзүүлж ирсэн бол гэдэгт дүн шинжилгээ хийх ёстойг харуулж байна.

2005 онд шинэчлэгдсэн найруулгаар батлагдсан “Улс төрийн намын тухай хууль” өнөөгийн Монгол Улсын улс төрийн намын хөгжлийн төрх, хандлагыг тодорхойлж буй хамгийн том гадаад институт болно. Өнөөдөр улс төрийн намуудад төрийн зүгээс үзүүлэх санхүүгийн дэмжлэг нь хангалтгүй, хуваарилалт нь хувь гишүүдийн сонгуулийн тойргийн явцуу эрх ашиг, сонирхол, асуудлуудыг тодорхойлох, шийдвэрлэх хувилбаруудыг тогтоон хэрэгжүүлэх хувь гишүүн, түүний дэмжигчдийн сонирхлыг бодлогын хувьд дэмжихэд чиглэсэн байна. Харин үндэсний эрх ашигт нийцсэн төрийн бодлогын асуудлыг тодорхойлох, бодлогын хувилбаруудыг тогтоох бодлогын судалгаа явуулах улс төрийн намуудын чадамжийг сайжруулах санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудал манай улсын Улс төрийн намын тухай хуульд бүрэн орхигдсон байна. Тухайлбал одоо хүчинтэй байгаа хуульд Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналыг нийт хүчинтэй саналын тоотой харьцуулах зарчмаар нэг саналыг мянган төгрөгөөр тооцож нэг удаа мөнгөн дэмжлэг үзүүлэх, мөн Улсын Их Хуралд суудал бүхий

БНСУ

“Төрийн санхүүжилтийн 30% -аас доошгүй хувийг улс төрийн намууд бодлогын судалгааны институцийн хөгжилд зарцуулна гэсэн байдаг”

ХБНГУ

“Улс төрийн намуудын дэргэд төрийн санхүүжилттэй “Фредрик Эбертийн Сан”, Конрад Аденауэр Сан гэх мэт бодлогын судалгаа, сургалтын сангууд үүссэн хөгжиж, төрийн бодлогын чанарт олон олон эерэг үр нөлөөг үзүүлж ирсэн байна.”

Монгол Улс

“Манай улсад улс төрийн намуудын бодлогын судалгааны институцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төрийн санхүүжилт байхгүй”

намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгож, санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна гэсэн байна. Харин олон улсын түгээмэл жишгийн дагуу төрийн зүгээс улс төрийн намуудад өгөх санхүүжилтийн тодорхой хувийг улс төрийн нам дотор нийтийн бодлогын судалгааны институцийг хөгжүүлэхэд зарцуулна гэсэн хэсэг байхгүй байна. Тухайлбал БНСУ-ын Улс төрийн намын тухайн хуульд төрийн санхүүжилтийн 30%-аас доошгүй хувийг бодлогын судалгааны институцийн хөгжилд зарцуулна гэсэн байдаг. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын улс төрийн намын тухай хуулийн төрийн санхүүжилтийн дэмжлэгийн хүрээнд тус улсын улс төрийн намуудын дэргэд “Фредрик Эбертийн Сан”, Конрад Аденауэр Сан гэх мэт бодлогын судалгаа, сургалтын сангууд үүссэн хөгжиж, төрийн бодлогын судалгааны институцийн хөгжил, чанарт олон олон эерэг үр нөлөөг үзүүлж ирсэн байна. Харин манай орны “Улс төрийн намын тухай” хуульд ижил төстэй хэсэг ороогүй нь улс төрийн намуудын бодлогын шинжилгээ, судалгаа, үнэлгээний чадамжийг хөгжихөд үзүүлэх төрийн бодлогын дэмжлэгийн хоосон орон зай үүсэхэд хүргэж, улмаар парламент, засгийн газар дахь өөрийн намын гишүүдээр дамжуулан улс төрийн намууд чанаргүй бодлогын судалгаан дээр түшиглэсэн өөрсдийн учир дутагдалтай оновчгүй олон олон бодлогуудыг нийтийн бодлого хэмээн хэрэгжүүлж байна. Өөрөөр хэлбэл шинжлэх ухаанч нотолгоо, өгөгдөл, мэдээлэл дулимаг нөхцөлд улс төрийн намууд сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулан сонгуульд оролцож парламентын сонгуульд олонх суудлыг саналыг авч, эрх баригч нам болбол бодлогын судалгааны чанартай үр дүнд үндэслээгүй, намын доторх хүч нөлөө ихтэй улс төр, бизнесийн сонирхлын бүлгүүдийн лобби нөлөөн доор төрийн бодлогыг харж хийсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр дээр тулгуурлан засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх зохисгүй зан үйл тогтсон байна. Ийм гажуудсан зан үйл нь үндэсний бодлогын судалгааны институц дотор шинжлэх ухаанчаар төрийн бодлогыг тодорхойлох, бодлогын шийдлүүдийг сонгох үйл явцын үр дүн, үр өгөөж, чанарыг сайжруулах хөгжлийн зөв баримжаа, соёл улс төрийн нам тогтолцоонд тогтож, хөгжих нөхцөлд саад болоод зогсохгүй нийтийн буюу ард түмний нийтлэг эрх ашгийн төлөө бодлогын судалгаа явуулдаг үндэсний бодлогын судалгааны институц улс орны тэргүүлэх ач холбогдолтой салбар бүрд үүсэн хөгжихөд

саад болж байна. Тухайлбал Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд олон талаар үр нөлөөтэй боловсролын салбарт боловсролын бодлогын судалгааны төрийн институц байхгүй байгаа нь боловсролын салбарын төрийн бодлого, хөтөлбөрүүдийн чанарт сөрөг нөлөөлж байгаа нь тодорхой. Нэн ялангуяа 2016 оны Улсын Их Хурлын сонгуулиас хойш дөрвөн сайдын нүүр үзэж байгаа БСШУСЯ-ын бодлогын тогтвортой, үр дүнтэй, үр өгөөжтэй байдалд цагийн хугацааны төдийгүй хөрөнгө мөнгөний хувьд ямар их хохирол учруулж буй нь ойлгомжтой юм.

“Шинжлэх ухаанч бодлогын сонголт хийх ёстой гэсэн “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн” зарчим, шаардлагыг манай төрд хэрэгжүүлэхэд хэрэгтэй “улс төрийн хүсэл, зоригийг” сайжруулахад улс төрийн намууд бодлогын намууд болох хэрэгтэй байна.”

Дээр дурдсан бүх баримтууд дээр тулгуурлан дүгнэж үзэхэд манай улсад боловсролын салбарын бодлогын судалгааны зөв тогтолцоо, зөв соёл, үр дүнтэй бодлогын институцүүд бүрэлдэн хөгжихөд таатай нөлөө үзүүлэх улс төрийн хүсэл, зориг бүрэн хангагдаагүй буюу

хувьсгалын тохироо үүсээгүй байна гэж дүгнэж үзэж болохоор байна. Цаашид улс төрийн намуудын дотор бодлогын судалгааны институт бүрэлдэн хөгжих таатай суурь хөрсийг бий болгоход нөлөөлөх хууль эрх зүйн орчны шинэчлэлийг “Улс төрийн намын тухай” хуульд оруулж, намуудын дотор бодлогын судалгааны тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төрийн санхүүжилтийн асуудлыг тодорхой болгох шаардлагатай байна. Улмаар намуудын дотор өөрчлөлт гарч чадвал Монголын Улсын Хууль тогтоох дээд байгууллага Улсын Их Хурал, Засгийн газар дотор улс орны тэргүүлэх салбар тус бүрд тухайлбал боловсролын салбарын хөгжлийн бодлогын судалгааны институцийг хөгжүүлэхэд ач холбогдол өгөн анхаарал хандуулах улс төрийн хүсэл, зоригийн уур амьсгал нэмэгдэх боломжтой юм.

1.4.2. Хууль эрх зүйн орчны үр нөлөөг бодитоор хэрэгжүүлэх өртөг, боловсролын бодлогын судалгааны институцийн хөгжил

Манай судалгааны ажлын үр дүнд цугларсан өгөгдөл, мэдээлэл, дүн шинжилгээний үр дүнгээс үзэхэд “Хууль тогтоомжийн тухай” хууль, “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль” гэх мэт эрх зүйн баримт бичгүүд 2016 он гэхэд хүчин төгөлдөр болж, хэрэгжиж

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль болон бусад холбогдох хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлогын судалгааны тогтолцоо, тохирсон үр чадвартай хүний нөөц Монгол Улсад бэлэн байна уу?

эхэлснээр боловсролын салбарын бодлогын судалгааны дэд бүтэц, тогтолцоо, хүний нөөцийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бий болгосон хууль эрх зүйн суурь орчин бодитоор бүрэлдэн тогтсон байна. Бодлогын судалгааны агуулгын шинжилгээний үр дүн, дүн шинжилгээний тайлбарыг олон улсын шаардлагад нийцүүлэн шинжлэх ухааны ул суурьтай судалгааны үр дүн болсон найдвартай

өгөгдөл, мэдээлэл дээр түшиглэн төрийн бодлогын асуудлыг тодорхойлж, бодлогын шийдлүүдийн хувилбаруудыг санал болгох, сонгох нийтийн бодлого боловсруулах үйл явцын чанарыг сайжруулах шинэ соёл, шинэ ёс суртахуун, шинэ арга барилыг Монгол Улсын засгийн газрын тогтолцоонд бүрэлдүүлэн, хөгжүүлэх хууль эрх зүйн шаардлага, зарчим бүрэн бий болжээ. Харин нэгэнт хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн хууль эрх зүйн орчны зарчим, шаардлагуудыг бодлого боловсруулах үйл явцад бодитоор хэрэгжүүлэх бүрэн нөхцөлийг хангах бодлогын судалгааны институцууд, дэд бүтцийг үүсгэн байгуулж, түүнд ажиллах хүний нөөцийг бүрдүүлж, үйл ажиллагааг нь тогтвортой болгох нь чухал ач холбогдолтой зорилт байдаг. Манай улсын төрийн бодлогын судалгааны орчинд энэ зорилт хэр үр дүнтэй, хэр бүрэн дүүрэн хэрэгжиж байна вэ гэдэгт шинжилгээ хийх нь энэ хэсгийн хамгийн гол зорилго болно. Манай судалгааны ажил боловсролын салбарын бодлогын судалгааны хөгжилд чиглэсэн учраас уг зорилт тус салбарт хэр амжилттай хэрэгжиж байгаад дүн шинжилгээний ажлыг чиглүүлэн ажилласан.

Засгийн газрын одоогийн бүтэц дотор БСШУСЯ-ны харьяа Боловсролын хүрээлэн багтаж байна. Тийм учраас хамгийн түрүүнд Боловсролын хүрээлэн боловсролын судлалын ухааны мэдлэг үйлдвэрлэх зорилготой суурь судалгаа, хэрэглээний судалгаа түлхүү явуулдаг, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа давамгайлсан шинжлэх ухааны хүрээлэнгийн төрхтэй байгууллага байна уу эсхүл үндэсний хэмжээний хам болон цуваа цагийн үйл ажиллагааны судалгаа, үнэлгээний судалгаан дээр тулгуурлан боловсролын

салбарын төрийн бодлогын асуудлуудыг тодорхойлж, тухайн төрийн бодлогын асуудлуудыг өртгийн хувьд хамгийн үр ашигтай байдлаар шийдвэрлэх бодлогын шийдлүүдийг хайсан бодлогын судалгааны хүрээлэнгийн төрх рүү чиглэж хөгжиж байна уу гэдэгт дүн шинжилгээ хийх зорилго тавин ажилласан. Энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хүснэгт 5-т харуулсан байдлаар Боловсролын хүрээлэнгийн өнөөгийн зорилго, бүтэц, судалгааны төрөл, дэд бүтцэд олон улсын жишигтэй харьцуулсан дүн шинжилгээг хийсэн.

Хүснэгт 5: Бодлогын судалгааны институтийн олон улсын жишигтэй Боловсролын хүрээлэнгийн одоогийн байдалтай харьцуулсан шинжилгээ

Үзүүлэлт	Олон улсын жишиг	Боловсролын хүрээлэн	Ялгаа
Алсын хараа	Хувь хүн, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах боловсролын салбарын төрийн бодлогын судалгааны институт	Монгол улсын боловсролын хөгжлийн шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлж, Монгол хүний хөгжилд хувь нэмэр оруулна.	<ul style="list-style-type: none"> • Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын алсын хараа шинжлэх ухааны хөгжилд чиглэдэг • Бодлогын судалгааны хүрээлэн төр улсын боловсролын бодлогод зориулсан бодлогын шинжилгээ хийдэг
Эрхэм зорилго	<ul style="list-style-type: none"> • Боловсролын тогтолцоог уламжлал, одоогийн бодит байдалтай хослуулан бодлогын хувьд шинэчлэх • Боловсролын нийтийн бодлогын асуудлуудыг судлах • Оновчтой бодлогын шийдлүүдийг судлах 	Боловсролын судалгаагаар олон улсын түвшинд хүрсэн эрдэм шинжилгээ, арга зүйн тэргүүлэгч байгууллага байна.	<ul style="list-style-type: none"> • Эрдэм шинжилгээний ажлын анхдагч зорилго мэдлэг бүтээх ажил болно. • Бодлогын хүрээлэн төрийн тогтолцооны бодлогын тодорхой түнш байгууллагуудад үйлчилдэг.
Судалгааны хэлбэр	<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны судалгаа • Үнэлгээний судалгаа • Үндэсний панель судалгаа 	<ul style="list-style-type: none"> • Хэрэглээний судалгаа • Судалгаа, хөгжүүлэлт • Үнэлгээний судалгаа 	<ul style="list-style-type: none"> • Үндэсний хэмжээний панель судалгаа нь төрийн бодлогын шинжилгээ, үнэлгээний үндэс нь болдог.
Статистикийн үйлчилгээ	Боловсролын салбарын статистик мэдээллийн төв эсхүл ямар нэг дэд бүтэцтэй байх	Боловсролын мэдээллийн систем Боловсролын хүрээлэнд харьяалагдахгүй	Статистик мэдээлэл, үйлчилгээний материаллаг бааз байхгүй бол бодлогын судалгааны институт хөгжих нөхцөл үүсэхгүй

Харьцуулсан мэдээлэл дээр шинжилгээ хийж үзэхэд БСШУСЯ-ны харьяа Боловсролын хүрээлэн цэвэр төрийн боловсролын бодлогын хүрээлэн болж хөгжихийн тулд алсын хараа, зорилго зорилт, судалгааны төрөл, статистик мэдээллийн дэд бүтцээ сайжруулах шаардлагатай байна.

Нэгдүгээрт Боловсролын хүрээлэн төрийн боловсролын салбарын бодлогын судалгааны хүрээлэн болох ёстой гэж үзэж байгаа бол эрдэм шинжилгээний тэргүүлэх байгууллага

“Боловсролын хүрээлэн төрийн бодлогын судалгааны институт болох хэрэгтэй бол эрдэм шинжилгээний тэргүүлэх арга зүйн байгууллага болох зорилтоо орхих ёстой.”

болох зорилтоо орхих шаардлагатай байна. Харин түүний оронд төрийн бодлого боловсруулах тогтолцоонд үйлчилдэг бодлогын шинжилгээ, үнэлгээний судалгаа явуулдаг

институт болж, өөрчлөгдөн хөгжих шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл шинэ зууны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Монгол Улсын өнөөгийн хөгжлийн онцлогт тохируулан боловсролын тогтолцоог шинэчлэн, өөрчлөхөд төрийн бодлогын оролцоо, дэмжлэгтэйгээр зайлшгүй шийдвэрлэх ёстой боловсролын салбарын төрийн бодлогын асуудлуудыг тодорхойлж, өртгийн хувьд хамгийн үр ашигтайгаар шийдэж болох бодлогын хувилбаруудыг шинжлэх ухаанчаар сонгож санал болгох бодлогын судалгаа явуулж төрийн бодлого боловсруулах засгийн газрын тогтолцоонд үйлчилдэг төрийн бодлогын судалгааны байгууллага болж хувьсан хөгжих асуудлыг гол зорилгоо болгон ажиллах хэрэгтэй гэсэн үг юм.

Урт хугацаанд илрэх төрийн бодлогын үр нөлөөнд шинжилгээ хийхэд зайлшгүй хэрэгтэй панель судалгааны соёл манай улсад хөгжөөгүй байна.

Хоёрдугаарт боловсролын төрийн бодлого ихэнх тохиолдолд нийт хүн ам (эх олонлог) дээр шууд хэрэгжих тохиолдол түгээмэл байдаг. Ийм үед дэлхий улс орнуудын бодлогын судалгааны хүрээлэнгүүд панель судалгаа авч хэвшсэн байдаг. Мөн эх олонлогийг төлөөлж чадах түүвэр дээр туршиж байгаад эх олонлог буюу нийт нутаг дэвсгэрт

боловсролын салбарын шинэ төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үед үр нөлөө нь түүвэрт гарсан үр нөлөөнөөс өөр үр дүн гарч болох тул дэлхийн улс орнууд шинэ бодлого эсхүл хөтөлбөр нийт улсын хэмжээнд хэрэгжиж эхэлсэн үед нийгэмд ямар үр нөлөө үзүүлж байгааг судлахын тулд тодорхой үечлэлтэйгээр, тогтсон нэг загвараар тасралтгүй давтан авах урт хугацааны панель судалгаануудыг авдаг. Панель судалгааны явцад уг шинэ бодлого, хөтөлбөртэй холбоотой төрийн бодлого, оролцоотойгоор шийдвэрлэх ёстой асуудал үүссэн бол тухайн асуудлыг шийдвэрлэх бодлогын шийдлийг олох судалгааг эхлүүлдэг. Тийм ч учраас дан ганц боловсролын салбарын бодлогын судалгааны институт дээр төдийгүй бусад бүх салбарын бодлогын судалгааны институт дээр панель судалгаа заавал явуулж байдаг. Гэтэл манай улсад боловсролын салбарт хэрэгжүүлж буй төрийн бодлогын алдаа, дутагдлыг илрүүлэх панель судалгааны соёл Боловсролын хүрээлэнд

хөгжиж төлөвшөөгүй байна. Үүнээс гадна БСШУСЯ-ны хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтийн үр дүн, үр өгөөж, үр нөлөөнд хөндлөнгийн үнэлгээний судалгааг яамнаас хараат бусаар Боловсролын хүрээлэн хийж судалгааны тайлан, зөвлөмжийг боловсруулан гаргах хууль эрх зүй, тогтолцооны орчныг бүрдүүлж өгвөл тус хүрээлэн жинхэнэ утгаараа боловсролын салбарын бодлогын хүрээлэн

Боловсролын салбарын мэдээллийн системийн үр дүнд бий болох өгөгдөл, мэдээллийг ашиглан бодлогын шинжилгээ, судалгаа хийх хүний нөөц бэлтгэгдээгүй байна.

ОДООГИЙН ТӨРХ

болж төлөвшин хөгжих сайхан нөхцөл болж өгөхөөр харагдаж байна.

Сүүлийн 5 жилд БСШУСЯ-ны зүгээс боловсролын салбарын бодлогын дүн шинжилгээг хийхдээ бодит цагийн бэлэн өгөгдөл, мэдээлэл дээр тулгуурлан хийх боломжтой болохын тулд боловсролын салбарын мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх зорилтыг тавин ажиллаж байна. Энэ төрийн бодлоготой уялдан “Боловсролын салбарын мэдээллийн систем” төсөл

нь 2014 оноос Азийн хөгжлийн банк болон БСШУСЯ-ны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн. Энэ хугацаанд суурь бүртгэл, статистик тайлан мэдээ солилцох системийн үүрэг голлон гүйцэтгэж ирсэн байна. Харин 2018-2019 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, багш сурагч, эцэг эх рүү чиглэсэн систем болон өргөжиж байгаа юм байна. 2019-2020 оны хичээлийн жилд орон даяар боловсролын удирдлага, бүртгэл, менежментийн цахим системд шилжинэ. Энэхүү систем өргөжин орон даяар цахим системд шилжиж эхэлснээр боловсролын салбарын оролцогч талууд бодлогын санал, хүсэлтээ салбарын бодлогыг боловсруулагч БСШУСЯ руу шууд хүргүүлэх боломжтой болох давуу тал үүсэж байгаа юм байна. Энэ дэвшлийн ач тусаар Боловсролын салбарын бодлогын байгууллагуудын хувьд мэдээллийн сан дээр тулгуурлан дүн шинжилгээ хийх, бодлого боловсруулах, зөв төлөвлөлт хийх боломжоор хангагдаж байна. Харин боловсролын удирдлага, бүртгэл, менежментийн цахим системд бүрэн шилжсэн үед тухайн системийг сайжруулах, цугларсан өгөгдөл, мэдээлэлд мэргэжлийн түвшинд бодлогын шинжилгээ, үнэлгээ, судалгаа хийж бодлогын асуудлуудыг тодорхойлж, бодлогын шийдлүүдийн сонголтыг хийх хүний нөөц хангалттай бэлтгэгдээгүй байна. Тухайлбал БСШУСЯ-нд статистикийн мэдээлэл хариуцсан мэргэжлийн ганцхан боловсон хүчин байх жишээтэй. Мөн бодлогын шинжээчийн ажлын байрууд, бодлогын шинжилгээний бие даасан хэлтэс байхгүй байна. Нэгэнт бэлэн болсон боловсролын салбарын мэдээллийн системийн өгөгдлийг ашиглан бодлогын шинжилгээ, үнэлгээ, судалгаа, хийх боловсролын бодлогын албан тушаал хашиж буй ажилчдын статистик шинжилгээ, статистикийн программуудыг хэрэглэж сурах ур чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүнээс гадна Боловсролын салбарын мэдээллийн систем нь БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, нийслэл, аймгуудын боловсролын газрууд гэх мэт төрийн бодлогын байгууллагуудад үйлчлэхээс гадна боловсролын салбарын нийтийн бодлогын судалгаа, шинжилгээ хийхийг хүссэн төрийн

Одоо байгаа боловсролын салбарын төрийн бодлогын ажлын байранд ажиллаж буй хүний нөөцийн бодлогын судалгаа, тоон шинжилгээ, статистик программын ур чадварыг сайжруулах шаардлагатай байна.

Одоогийн төрх

бус бодлогын судалгааны тинк танкууд, бодлогын шинжилгээний экспертүүд, судлаачид, хувь хүмүүс, сэтгүүл зүйн салбар, олон улсын донор байгууллагууд бодлогын шинжилгээнд оролцох боломжийг хангах үүднээс статистикийн мэдээлэл, өгөгдлийг нээлттэй, хүртээмжтэй болох бодлогын баримт бичгийг гаргах хэрэгтэй байна.

Дээр гарсан баримтууд дээр чанарын ажиглалтын шинжилгээ хийж үзэхэд үндэсний бодлогын судалгааны тогтолцоог хөгжүүлэхэд зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай гурван асуудал байна. Нэгдүгээрт Монгол Улсын төрийн бодлого боловсруулах тогтолцоонд шинжлэх ухаанч бодлогын шинжилгээний чанартай үйл явц, соёлыг хөгжүүлэх, төлөвшүүлэх зорилго, зарчим, шаардлагыг тавьсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль болон бусад хууль эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг дэмжих бодлогын судалгааны биет тогтолцоог байгуулах зорилтын хүрээнд нэн тэргүүнд Боловсролын хүрээлэнд бүтцийн өөрчлөлт хийж, бодлогын судалгааны хүрээлэн хэлбэрээр хөгжүүлэх шаардлагатай байна. Энэ зорилгыг биелүүлэхийн тулд тус хүрээлэнгийн алсын хараа, эрхэм зорилго, судалгааны хэлбэр, бүтэц зохион байгуулалт, статистикийн мэдээлэл, өгөгдөл цуглуулах дэд бүтцэд өөрчлөлт, шинэчлэлт хийх хэрэгтэй байна. Хоёрдугаарт боловсролын салбарын бодлогын судалгааны институт, боловсролын салбарын мэдээллийн систем байгуулагдахад тэнд ажиллахад шаардлагатай тохирсон ур чадваруудыг эзэмшсэн хүний нөөц бэлтгэгдээгүй байна. Ирээдүйд байгуулагдах бодлогын судалгааны институцид ажиллах хүнийг нөөцийг бэлтгэх мэргэжлийн магистр, докторын зэргийн болон зэргийн бус хөтөлбөрүүдийг боловсруулан нээж, сургалт явуулах тусгай ахисан түвшний сургуулиудыг байгуулагдахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах шаардлагатай байна. Гуравдугаарт одоо боловсролын салбарын бодлогын байгууллага, газар, хэлтэст бодлого боловсруулах түвшинд ажиллаж байгаа хүний нөөцийн бодлогын шинжилгээ, тоон шинжилгээ, статистикийн шинжилгээний ур чадварыг сайжруулах зэргийн бус сургалтын хөтөлбөрүүдийг хөгжүүлэх, сургалт зохион байгуулах газруудыг олшруулах төрийн бодлого, хөтөлбөрийг боловсруулан гаргах шаардлагатай байна. Энэ гурван зорилгыг амжилттай хэрэгжүүлж чадвал Монгол Улсын төрийн бодлогыг шинжлэх ухаанчаар өгөгдөл, нотолгоонд тулгуурлан хийдэг соёл, тогтолцоог хөгжүүлэх зорилт тавьсан эрх зүйн орчны үр нөлөө бодитоор , үр дүнтэй хэрэгжиж эхлэх нөхцөл бүрдэнэ.

1.5. Дүгнэлт

Боловсролын салбарын бодлого, хөтөлбөрийн зорилго, үйл ажиллагаа чиглэх ёстой төрийн бодлогын асуудлуудыг шинжлэх ухаанчаар бусад энгийн нийгэм, эдийн засгийн асуудлуудаас ялгаж, тогтоон илрүүлж, тэдгээр асуудлуудыг шийдвэрлэх бодлогын хувилбаруудыг шинжлэх ухаанч судалгаан дээр тулгуурлан сонгож, бодлого боловсруулагч нарт хамгийн тохиромжтой бодлогын хувилбаруудыг санал болгох төрийн бодлого боловсруулах тогтолцоо, үйл явц, чанарыг сайжруулахад хамгийн их үр нөлөө үзүүлдэг хүчин зүйл нь хууль эрх зүйн орчин, түүний институцийн хөгжлийн түвшин байдаг. Тийм ч учраас шинжлэх ухааны баталгаатай, хүлээн зөвшөөрөгдсөн аргаар боловсролын бодлогын шинжилгээ хийж боловсролын салбарын төрийн бодлого, хөтөлбөрийн сонголт хийх соёл, үр дүнтэй тогтолцоо бүрдүүлэх хэрэгцээ, шаардлагыг үүсгэсэн хууль эрх зүйн орчин бүрэлдэн тогтсон эсэхэд дүн шинжилгээ хийх ажлыг манай төслийн хамгийн анхны зорилгоор сонгож, энэ шатанд ажилласан.

Мөн хоёрдугаарт Монголын Улсын боловсролын салбарын төрийн бодлого, хөтөлбөрийн асуудлуудыг тогтоох, асуудлуудын шийдлүүдийг сонгох үндэсний тогтолцоонд хууль эрх зүйн орчны шинэчлэл, өөрчлөлтийн үр нөлөө гарах нөхцөлийг хангахад зайлшгүй хэрэгтэй улс төрийн хүсэл зориг манай улсын улс төрийн орчин, төрийн албаны тогтолцоонд бүрэн байгаа эсэх, бодлогын судалгааны бие даасан институтийг шинээр байгуулах хэрэгцээ байгаа эсэх, статистик өгөгдлийн дэд бүтэц, хүний нөөцийн бэлтгэл байдал хангагдсан байгаа эсэхэд шинжилгээ хийх зорилт тавин ажилласан. Манай хууль эрх зүйн орчин, бодлогын институтийн хөгжлийн байдалд шинжилгээ хийж үзэхэд дараах дүгнэлтүүд гарлаа.

- а) Боловсролын салбарын бодлогын судалгааны хөгжлийг дэмжих, хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйгээр салбарын асуудлуудад шинжилгээ хийж, салбарын төрийн бодлого, хөтөлбөрийг шинжлэх ухаанчаар тодорхойлох, бодлогын шийдлүүдийг сонгох соёл, зан үйл, тогтолцоог бүрдүүлэхэд төрийн анхаарал, үйл ажиллагааг чиглүүлэхэд дорвитой үр нөлөө үзүүлэх “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль”, “Хууль тогтоомжийн тухай хууль”, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” гэх мэт хууль эрх зүйн баримт бичгүүд гарсан байна. Одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй эдгээр хууль, эрх зүйн баримт бичгүүдэд зааж

өгсөн бодлогын судалгаа хийх үйл явц, шаардлагыг төрийн байгууллагууд хэлбэрийн хувьд хэрэгжүүлж заншсан нь сайшаалтай байна. Гэхдээ чанартай, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг хангагдахад дэмжлэг үзүүлэх улс төрийн хүсэл зориг, бодлогын судалгааны институт, найдвартай статистик мэдээллийн сан, хүний нөөц бүрэн хангагдсан эсэх нь тодорхойгүй байна.

- b) Манай улсад боловсролын салбарын бодлогын судалгааны зөв тогтолцоо, зөв соёл, үр дүнтэй бодлогын институцууд бүрэлдэн хөгжихөд таатай нөлөө үзүүлэх улс төрийн хүсэл, зориг бүрэн хангагдаагүй буюу хувьсгалын тохироо үүсээгүй байна. Монгол Улсад үндэсний хэмжээний бодлогын судалгааны тогтолцоог байгуулан, хөгжүүлэх улс төрийн болон төрийн шийдвэр гарахад хууль тогтоох дээд байгууллага буюу Улсын Их Хурал, засгийн газарт хамгийн хүчтэй үр нөлөө үзүүлэх улс төрийн намууд бодлогын намууд болж төлөвшөөгүй байна. Улс төрийн намуудын бодлогын намууд болон төлөвшихөд дэмжлэг үзүүлэх төрийн санхүүжилтийн дэмжлэг байхгүй байна. Бодлогын судалгааны үнэ цэнтэй үр нөлөөг улс төрийн намууд маань ойлгож мэдрээгүй учраас Улсын Их Хурал дээр өөрийн намын гишүүдээр дамжуулан бодлогын судалгааны үндэсний тогтолцоо, хүний нөөцийг бэлтгэх, бойжуулахад хэрэгтэй оновчтой бодлого, хөтөлбөрийг санаачлан боловсруулж, батлуулахаар дэвшүүлэх улс төрийн хүсэл, зориг, манлайлал, лобби үүсэхгүй байна.
- c) Монгол Улсын боловсролын салбарт Боловсролын салбарын мэдээллийн систем бүрэлдэн хөгжиж ирж байгаа нь цагаа олсон, зөв эхлэл мөн. Гэхдээ мэдээллийн систем байгуулах зорилт амжилттай хэрэгжиж түүний үр дүнд боловсролын салбарын бодлогын судалгаанд хэрэглэх анхдагч өгөгдөл, мэдээллийн сангийн хүрэлцээ нэмэгдсэн үед өгөгдөл, мэдээллийг ашиглан бодлогын шинжилгээ, судалгаа хийх хүний нөөц бэлтгэгдээгүй байна.
- d) Өнөөдрийн боловсролын салбарын бодлого боловсруулах тогтолцооны байгууллагуудад байгаа хүний нөөцийн ур чадварыг сайжруулах, давтан сургах сургалтын байгууллага, хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх шаардлагатай болсон байна. Бодлогын шинжилгээний газар, хэлтсүүдийг шинээр байгуулж, тэдгээрт ажиллах хүний нөөцийг дорвитой бэлтгэх ажил орхигдсон байна.

III. Үндэсний боловсролын бодлогын судалгааны олон улсын шилдэг туршлага: БНСУ болон Сингапур улс

1.1. Яагаад бодлогын судалгаа чухал вэ?

Улс, үндэсний үнэт зүйл, соёл, зан заншил ард түмний дэлхий ертөнцийг харах үзэл санаа, нийгэм, түүхийг ойлгох зөв сэтгэлгээ, сэтгэхүйг түгээх, нийгэм, эдийн засгийн амьдралд зөв сонголт хийх, шинжлэх ухааны үнэн мэдлэг, тухайн үеийн хөдөлмөрийн зах зээлийн

“Олон улсын нийтлэг жишгээр Бодлогын судалгаа, шинжилгээ нь уг салбарын бодлогын үр нөлөөнд зөв онош тавьж, ноцтой асуудлуудыг мухардалд оруулахгүй эмчлэх бодлогыг тасралтгүй хөгжүүлэх арга зам болно”

хэрэгцээ, шаардлагад нийцсэн үр ашигтай ур чадвар, ухамсар, оюун санааг иргэн бүрд төлөвшүүлэх төр улсын үндэсний соёлын дархлаа, аюулгүй байдал, нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх дэд бүтэц бол боловсролын салбар юм. Энэ үүднээсээ дэлхийн улс орон бүрд боловсролын салбарын бодлогын судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажил нь тус улсын боловсролын салбарт хэрэгжиж буй бодлого, төсөл, хөтөлбөрүүдэд дэвшүүлсэн төрийн бодлогын зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлж, зорьсон нийгэм эдийн засгийн үр өгөөж, үр нөлөө гарч буй эсэхэд шинжилгээ хийж, шаардлагатай үед засаж залруулах, тус салбарт шинээр үүссэн эсхүл олон жилийн турш шийдвэрлэгдэхгүй бугшиж үлдсэн зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай нийтийн бодлогын асуудлуудыг илрүүлэх, тохирсон бодлогын хувилбаруудыг боловсруулах, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хортой үр нөлөө үзүүлж байгаа боловсролын салбарын ноцтой асуудлуудад цаг алдахгүй зөв онош тавьж, эмчлэх оновчтой бодлогын оролцооны шийдлийг тодорхойлох, эмчилгээний үр дүнд үнэлгээ хийх, нийгмийн мухардсан асуудал болгон хүндрэхээс урьдчилан сэргийлэх анагаах ухааны салбарын чиг, үүрэгтэй адил амин чухал юм.

ЯАГААД ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Бодлогын зөвлөх үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор улс орон бүрийн төрийн байгууллагууд бодлогын судалгааны үр дүнтэй, үр ашигтай тогтолцоо хөгжүүлж чадсан олон улсын шилдэг туршлагауудыг судлах, нутагшуулах ажил түгээмэл болсон байна.

ЭНЭ УДААГИЙН ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО

Олон улсын түгээмэл стандарт, шилдэг туршлагауудын судалгаа явуулж бодлогын шинжилгээг **ХЭН, ЯАХ ГЭЖ, ХЭРХЭН ЯВУУЛДАГ** дүн шинжилгээ хийх

Эмчтэй адил бодлогын судалгаа нь боловсролын салбарын нийтийн бодлогын асуудлуудыг шинж тэмдэгт нь түшиглэн онош тавин илрүүлж, тэдгээр асуудлууд нийгэм, эдийн засагт хортой нөлөө үзүүлэх хор уршигтай асуудал болоход нөлөө үзүүлсэн гинжин холбоотой суурь хүчин зүйлс юу болохыг илрүүлэх, эмчилгээ хийх бодлогыг сонгохын өмнө тухайн асуудлуудыг шийдэх алтернатив бодлогын хувилбаруудыг харьцуулан судалж, бодлогын шийдлийн судалгаа хийдэг. Хэрэв оношийг буруу тогтоох эсхүл асуудлуудыг буруу илрүүлэх, хэрэв сонгосон эмчилгээний бодлогын шийдэл тохирохгүй бол боловсролын салбарын асуудлууд улам хүндэрч, мухардсан нийгмийн асуудал болон гарч ирдэг. Тийм ч учраас 20 дугаар зууны төгсгөл үе, 21 дүгээр зууны эхний 10 жилээс эхлэн улс орон бүр боловсролын төрийн бодлогын асуудлуудыг шийдвэрлэх боломжит бодлогын шийдлүүдийг илрүүлж, тогтоох, харьцуулсан үнэлгээ хийх, илүү үр дүнтэй, ирээдүйтэй бодлогын хувилбаруудыг сонгодог өөрийн орны улс төр, нийгэм, эдийн засаг, соёл, газар зүйн онцлог байдалд тохирсон бодлогын судалгааны тогтолцоо хөгжүүлэхийг оролдох болсон байна.

Бодлогын судалгааны институт, бодлогын шинжээчид зохистой бодлогын саналуудыг гаргахын тулд үнэн зөв, тухайн цаг үедээ нийцсэн мэдээлэл цуглуулж, олж авах шаардлагатайн зэрэгцээ тухайн үеийн дэлхийн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн хүчин зүйлсийг харгалзан үзэж бодлогын шийдлүүдийн сонголтыг хийх хэрэгтэй байдаг. Өнөөдөр манай дэлхий дээр улс төр, эдийн засаг, соёл, боловсролын хамтын ажиллагаа даяаршиж байна. Дэлхий хэмжээний өрсөлдөөн дотоодын

хөдөлмөрийн зах зээл дээр ирсэн байна. Хүний хөгжил, амьдралын чанарыг дэлхийн нийтийн хэмжүүрээр хэмждэг болсон байна. Тэгэхээр боловсролын салбарын нийтийн бодлогын асуудлуудыг илрүүлэх, бодлогын шийдлүүдийг сонгох, хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хэмжүүрээр шинжилгээ хийх, тодорхойлох, үнэлгээ хийх шаардлагатай болсон байна. Энэ ч утгаараа боловсролын талаар баримтлах нийтийн бодлогын шинжилгээ, судалгааны дэлхий улс орнуудын шилдэг, туршлагыг харьцуулан судлах шаардлага гарч иржээ.

Эмч хүнтэй төстэй боловч эмч хүн хувь хүнд үйлчилдэг байхад бодлогын судалгаа, шинжилгээний хүний нөөц нь хамт олноороо бүхэл, бүтэн үндэстний ашиг сонирхлын төлөө төрийн тодорхой бодлогын байгууллагуудад үйлчилдэг байх ёстой гэсэн шалгуур үзүүлэлт улс орнуудад түгээмэл байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн байна. Тийм ч учраас дэлхийн янз бүрийн улс орны боловсролын бодлогын шинжилгээ, судалгаа, үнэлгээний байгууллагууд нийтийн боловсролын асуудлыг оношлон тогтоож, тохиромжтой бодлогын санал, зөвлөмжүүдийг боловсруулж боловсролын бодлогын судалгааны төрийн байгууллагуудыг бодлогын мэдээлэл, бодлогын шийдлүүдийн саналуудыг хангах үйлчилгээ үзүүлэх үүрэг гүйцэтгэдэг.³ Өөрөөр хэлбэл бодлогын судалгааны институт нь улс төрчид, улс төрийн намууд, өндөр албан тушаалын төрийн албаны хүмүүс, төрийн байгууллагуудад хамгийн зөв бодлогын шийдлийг сонгоход зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд оршдог. Бодлогын зөвлөх үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор улс орон бүрийн төрийн байгууллагууд бодлогын судалгааны үр дүнтэй, үр ашигтай тогтолцоо хөгжүүлж чадсан олон улсын шилдэг туршлагуудыг судлах, нутагшуулах ажил түгээмэл болсон байна. Тийм ч учраас энэ удаагийн ажлаар манай төслийн баг боловсролын салбарын бодлогын судалгаа, шинжилгээний олон улсын түгээмэл стандарт, шилдэг туршлагуудын

³ David L. Weimer and Aidan R. Vining, Policy Analysis: Concepts and Practice (3rd Edition), Upper Saddle River, NJ: Prentice-Hall, 1999, 36-37.

судалгаа явуулж бодлогын шинжилгээг хэн, яах гэж, хэрхэн явуулдаг талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх зорилт тавин ажилласан.

3.1. Олон улсын нийтлэг ойлголтууд

“Хүн амын ихэнх хэсэгт, нийтийн сонирхолд, эсхүл нийгмийн үнэт зүйлд хохирол учруулахгүй байхад чиглэгдсэн асуудлыг нийтийн бодлогын асуудал гэнэ”

3.2.1. Боловсролын салбарын бодлогын асуудал гэж юу вэ?

Ямар асуудлыг нийтийн боловсролын салбарын бодлогын асуудал гэж үзэх вэ гэдэг нь чухал юм. Асуудал бүхэн нийтийн салбарын бодлогын асуудал болж чадахгүй.⁴ Өнөө цаг үеийн олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн стандартаар гурван нөхцөлийг хангасан боловсролын салбарын асуудлууд засгийн газар, төрийн албаны бодлогын төвд орох ёстой боловсролын салбарын нийтийн бодлого буюу боловсролын талаарх төрийн бодлогын асуудал болно.

■ Нийтийн сонирхолд нөлөөлөх томоохон асуудал

○ Жишээ нь: Олон улсын гэрээнд нэгдэх

■ Хүн амын ихэнх хэсэгт нөлөө, хохирол үзүүлэх асуудал

○ Жишээ нь: Нийгмийн аюултай өвчний тархалт ерөнхий боловсролын эрүүл, ахуйн нөхцөлд ноцтой хохирол үзүүлж эхлэх

■ Нийгмийн үнэт зүйлд нөлөө үзүүлэх асуудал

○ Жишээ нь: Баян, ядуугийн ялгаа их болж боловсролын тэгш бус байдал нийгмийг бүхэлд нь хамарч газар авах

Иргэн эсхүл хувийн бүлэг шийдвэрлэж чадах асуудал дээрх гурван нөхцөлийг хангаагүй бол нийтийн бодлогын салбарын асуудалд орохгүй.

⁴ Eugene Bardach, A Practical Guide for Policy Analysis: The Eightfold Path to More Effective Problem Solving, New York, Chatham House Publishers, 2000, хуудас 1-10

3.2.2. Бодлогын шинжилгээ

Бодлогын шинжилгээ нь бодлогын асуудлыг судлахдаа нийтлэг талууд байх боловч бодлогын төлөвлөлт, шинжлэх ухааны судалгаа, сэтгүүл зүйтэй адил биш юм.⁵ Тухайлбал ихэнх социалист орнууд коммунист улс төрийн үзэл баримтлалын линзээр харж хийсэн төвлөрсөн төлөвлөгөө дээр тулгуурлан боловсролын салбарын бодлогын үйл ажиллагаа явуулж байсан. Ийм төлөвлөлтийн үр дүнд улс төрийн бодит байдал, зах зээлийн эдийн засгийн хэрэгцээ, шаардлагыг судалж үзэхгүйгээр урт хугацааны зорилго, зорилтуудыг тодорхойлсон, бодит зах зээл дээр өрсөлдөх чадвар муутай, өртгийн үр дүн муутай, нийгэм, зах зээлийн үр нөлөө муутай бодлого, хөтөлбөр гарах явдал элбэг байсан. Харин эсрэгээрээ бодлогын шинжилгээ нь улс төр, зах зээл, нийгэм, соёлын хам хүрээнүүдэд дүн шинжилгээ хийж, тэдгээр хүрээнүүдийн дотор гарч ирээд байгаа сорилтууд, боломжуудыг харгалзан үзэж бодлогын асуудал, шийдлүүдийг тодорхойлдог.

Олон оронд үндсэн зорилго нь нийцэл багатай байдаг болохоор бодлогын судалгаа, шинжлэх ухааны судалгааны хүрээлэнгүүдийг ялгаж, тус тусад нь бие биеэс нь хараат бус байдлаар байгуулдаг. Шинжлэх ухааны судалгаа нь бодлогын шинжилгээ, үнэлгээнд хэрэгтэй мэдээлэл, мэдлэгийн нөөцийг бий болгож өгдөг боловч анхдагч зорилго нь шинэ мэдлэгийг бүтээхэд чиглэсэн байдаг. Харин эсрэгээр нь бодлогын шинжилгээний судалгаа нь тодорхой нэг төрийн бодлого боловсруулдаг харилцагч байгууллага эсхүл бодлого боловсруулахад оролцдог төрийн алба хашдаг хэрэглэгчдийн(байгууллага эсхүл шийдвэр гаргагч) захиалгаар бодит бодлогын асуудал эсхүл бодлогын шийдлүүдийг боловсруулах судалгааны ажил хийдэг.

Сэтгүүл зүй нь бодлогын асуудал, боломжууд, шийдлүүдийн талаар асуудал дэвшүүлж, мэдээлэл өгдөг. Хамгийн гол нь сэтгүүл зүйн салбарын зорилго нь бодлогын асуудлыг олон нийтэд мэдээлэх зорилготой болохоор дэлгэрэнгүй шалгуурууд хэрэглэн бодлогын асуудал, шийдлүүдийн талаар нарийвчилсан түвшинд, тэнцвэртэй шинжилгээ хийхэд үйл ажиллагаа нь чиглэдэггүй.

Бодлогын судалгааны олон улс орнуудын шалгуур үзүүлэлтүүдийг харьцуулан судалж үзэхэд нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн бодлогын судалгааны чанарыг тодорхойлох хэд хэдэн шалгуур үзүүлэлтүүд байна. Үүнд:

⁵ David L. Weimer and Aidan R. Vining, Policy Analysis: Concepts and Practice (3rd Edition) (Upper Saddle River, NJ: Prentice-Hall, 1999), хуудас 30.

- **Бодиттой байдал, практик ач холбогдол:** Бодлогын шинжилгээний ажил бодлогын судалгааны тавьсан үзэгдэл, гол асуудлыг зөв тодорхойлж чадсан эсэхэд үнэлгээ өгөхөд энэ шалгуур үзүүлэлтийг ашигладаг. Ач холбогдол багатай энгийн асуудал, буруу асуудал, эсхүл үндсэн асуудлын гүнд нэвтрэхгүйгээр түүний шинж тэмдэгтэй зууралдаж, гол асуудлыг орхигдуулсан эсэхэд үнэлгээ өгдөг. Бодлого боловсруулагч, бодлогын шийдвэр гаргагч байгууллагууд бодлогын зөв шийдлийг сонгоход тухайн бодлогын судалгааны ажил үнэн зөв мэдээлэл, зөвлөмжөөр хангаж өгсөн эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр хэмждэг.
- **Оновчтой, найдвартай байдал:** Бодлогын шинжилгээний ажил олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны хүчинтэй, найдвартай аргаар цуглуулж, шинжилгээ хийж, тайлбарласан мэдээлэл, өгөгдөл, нотолгоо дээр тулгуурлан бодлогын асуудлуудыг тодорхойлж, бодлогын шийдлүүдийн хувилбаруудыг тодорхойлсон эсэхэд үнэлгээ өгөхөд энэ шалгуурыг хэрэглэдэг. Тухайн бодлогын шинжилгээний ажлын үр дүнд гарсан дүн шинжилгээ, санал, дүгнэлт үнэн зөв нотолгоо, баримт дээр тулгуурлаж хийгдсэн эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр хэмждэг.
- **Бүрэн нарийвчлал:** Бодлогын шинжилгээний ажил тухайн бодлогын асуудлуудыг илрүүлэх, бодлогын шийдлийг тодорхойлоход хэрэглэсэн шалгуур үзүүлэлт, хэмжүүрүүд, хам хүрээнүүдийг тодорхойлсон байдал олон улсын жишигт нийцсэн байдлаар үнэн, зөв хийгдсэн эсэхэд үнэлгээ хийхэд энэ шалгуур үзүүлэлтийг ашигладаг.
- **Тодорхой, цэгцтэй байдал:** Бодлогын шинжилгээний ажил хэт дэлгэрэнгүй, нарийвчилсан, жижиг мэдээллийг цуглуулж, гол бодлогын асуудал, бодлогын шийдлийн хувилбаруудыг бүрхэгдүүлж, ойлгомжгүй болгосон эсэхэд энэ шалгуур үзүүлэлтийг ашиглан үнэлгээ хийдэг. Ямар бодлогын шийдэл хамгийн хүсүүштэй, оновчтой, үр дүнтэй болохыг тодорхой, цэгцтэй харуулж чадсан эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр хэмжинэ.
- **Цаг хугацааны тохиромж:** Тухайн цаг үед нийгэм, эдийн засагт хэрэгцээ, шаардлагатай байгаа төрийн бодлогын асуудал, түүний бодлогын шийдлийг

тодорхойлох бодлогын шинжилгээний ажил хамгийн тохиромжтой цаг үед хийгдсэн эсэхэд энэ шалгуур үзүүлэлтийг ашиглан хийдэг.⁶

Улс орны онцлог

Тодорхой
бодлогын
зорилтыг
хэрэгжүүлэх
бодлогын
шийдлийн
боломжит
хувилбаруудыг
тодорхойлоход
тухайн орны
онцлогт нийцсэн
шалгуур
үзүүлэлтүүд байх
ёстой

3.2. Дэлхий улс орнууд бодлогын судалгаа, шинжилгээний ажлын чанарыг хэрхэн хэмждэг вэ?

Боловсролын салбарт үр дүнтэй бодлого боловсруулах, хэрэгжүүлэх хамгийн чухал урьдчилсан нөхцөл бол сайн бодлогын судалгааны институтийг хөгжүүлэх явдал байдаг. Боловсролын салбарын бодлогын судалгаа чанартай хийгдсэн үед тухайн улсын нийгэм, эдийн засагт хэрэгцээтэй өөрчлөлтүүдийг авчрах үр өгөөж, үр нөлөө ихтэй олон олон бодлого, хөтөлбөр гарч, улс орны хөгжилд бодитоор хувь нэмэр оруулж эхэлдэг. Бодлогын судалгааны ажлын чанарыг сайжруулахад олон улсад өргөн хэрэглэдэг сайн туршлага, арга зүйг өргөн хэрэглэх, нэвтрүүлэх шаардлагатай байна. Бодлогын судалгаа, шинжилгээний ажлын чанарыг хэмждэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэд хэдэн түгээмэл шалгуурууд байна. Үүнд:

- Нийтийн боловсролын тодорхой асуудлуудыг шийдэх зорилтуудын хүрээнд боломжит бодлогын шийдлүүдийг **тодорхой шалгуур үзүүлэлтүүдээр**

⁶ Juliet Musso, Bob Biller and Bob Myrtle, The Tradecraft of Writing for Policy Analysis and Management, School of Policy, Planning, and Development (University of Southern California, February, 1999). <http://priceschool.usc.edu/files/documents/students/resources/tradecraft.pdf>

Хамгийн бага өртөгтэй шийдэл

Бодлогын асуудлыг шийдвэрлэх хамгийн бага өртөгтэй бодлогын шийдлийг сонгох ёстой.

Татвар төлөгчдийн мөнгийг хэмнэлттэй үр бүтээлтэй зарцуулах ёстой

системтэй харьцуулан судалж **хамгийн үр дүнтэй бодлого, хөтөлбөрүүдийг сонгож, хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх олон улсын сайн туршлага байна.** Олон улсын туршлагаас харахад **улс орон бүр өөрийн онцлог байдалд тохируулан шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж** гарган хэрэглэж байна. Харин манай улсын хувьд гадаадын байгууллагын зөвлөмж, зөвлөгөөг авахдаа боловсролын салбарын асуудлуудын олон улсын шилдэг шийдлүүдийг харьцуулан судалж, өөрийн орны нөхцөл байдалд тохируулан сайжруулж, нутагшуулах асуудал ихээхэн орхигдож байна. Харин үүний оронд бусад орны болон донор байгууллагуудын урьдчилан боловсруулан сонгосон бодлогын шийдлүүдийг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлогт нийцүүлэн засаж сайжруулан нутагшуулахын оронд шууд өөрийн орны боловсролын салбарт шууд нэвтрүүлэх, түүхий судалгаатай, учир дутагдал ихтэй бодлогын шийдвэр гарах тохиолдол их байна.

- **Төрийн бодлогын асуудлыг хамгийн бага өртгөөр шийдвэрлэх бодлогын шийдлүүдийг сонгож,** татвар төлөгчдийн мөнгийг хэмнэх нөхцөлийг бүрдүүлэхэд төрийн санхүүжилтээр үүсгэн байгуулсан төрөөс санхүүждэг бодлогын судалгааны тогтолцоо хамгийн их үүрэг, үр нөлөөтэй байж чадаж байгаа, олон улсын сайн туршлагын жишээ их байна. Манай орны хувьд боловсролын салбарын бодлогын судалгааны хүрээлэн буюу тинк танк олон улсын жишгээр хөгжиж ирээгүй болохоор богино хугацааны захиалгат бодлогын судалгаан дээр тулгуурлан бодлогын шийдлүүдийн сонголт хийгдэж байна. Энэ нөхцөл байдлын улмаас хамгийн бага өртөгтэй бодлогын шийдлийг сонгож чадахгүй байх тохиолдол их болсон байна.

- **Нийтийн ашиг сонирхлыг тэргүүн зэрэгт тавих ёстой.** Хувийн ашиг сонирхлын нөлөөллийг оруулахгүйгээр нийтийн ашиг сонирхлыг тодорхойлж тэргүүн зэрэгт тавихын тулд бодлогын асуудал, бодлогын шийдлүүдэд шинжилгээ хийж, тодорхой шалгуур үзүүлэлтүүд дээр тулгуурлан бодлогын шийдлүүдийн үндэслэлүүдийг гарган ирж, бодлогын сонголт хийх нөхцөлийг бүрдүүлэх ёстой. Ийм нөхцөл бүрдэж байж бодлогын шийдвэр гаргах үйл явц авлигад бага өртөх, нийтийн ашиг сонирхлыг тэргүүн зэрэгт тавих ажил саад, бэрхшээл багатай бүтэх бүрэн нөхцөл бүрддэг болохыг олон орны шилдэг туршлагаас харж болно.

“Бодлогын судалгаа, шинжилгээний хэрэглээ илүү олон талт болсон байна.”

3.3. Бодлогын судалгаа, шинжилгээг хэн хийдэг вэ? – Олон улсын туршлага

Сайн чанартай бодлогын судалгаа, шинжилгээний ажлууд нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитоор, жинтэй үр нөлөө үзүүлэх болж, засгийн газрын шийдвэрлэх ёстой асуудлууд илүү нарийн төвөгтэй олон хүчин зүйлсээс хамаардаг болох тусам дэлхийн улс орнуудын засгийн газруудад бодлогын судалгаа, шинжилгээний мэргэжлийн үйлчилгээ, хэрэглээний

ач холбогдол хурдтай өсөн нэмэгдэж, өргөн цар хүрээнд хэрэглээнд нэвтэрсэн байдаг. Сүүлийн 30 гаруй жилд төрийн бодлогын асуудлууд олон салбараас хамаарсан нарийн төвөгтэй үзэгдлүүд болж, тэдгээр асуудлуудтай ашиг сонирхлын хамаарал бүхий оролцогч талуудын тоо ихэд нэмэгдсэн өнөө үед засгийн газрууд гаднаас зөвлөх үйлчилгээ авах явдал түгээмэл болж, бодлогын судалгааны судалгаа, шинжилгээний ажил, хэрэглээ илүү олон талт болсон байна. Тийм ч учраас энэ хэсэг засгийн газрын тогтолцоонд, түүний гадна талд хэн бодлогын шинжилгээ, судалгаа явуулдаг болох тухай олон улсын туршлагауудын судалгаа явуулж, судалгааны үр дүнг тойм байдлаар бичиж танилцуулахыг зорьсон.


3.3.1. Засгийн газрын тогтолцоонд бодлогын судалгаа, шинжилгээ

Өнгөрсөн зуунд төрийн бодлогын шинжилгээний ажил ихэнхдээ гүйцэтгэх засаглалд буюу ерөнхий сайдын албанд төвлөрдөг байсан. 1980-аад оноос хойш бодлогын шинжилгээний мэргэжлийн хүмүүсийг бэлтгэх ажил эхэлсэн байдаг. Засгийн газрын бодлогын түвшний байгууллагууд, агентлагууд дээр бодлогын албан тушаалд ажиллах бодлогын шинжээч

нарыг ахисан түвшний сургуулиудад бэлтгэж эхэлсэн байдаг. Засгийн газрын шатлан захирах босоо удирдлагын дээд түвшнээс салбарын яамд, орон нутгийн засгийн газруудад бодлого боловсруулах эрх мэдлийг даатган хариуцуулах, төвлөрлийг бууруулах, шинэчлэл өөрчлөлтийг дэлхийн олон орны засгийн газрууд хүлээн зөвшөөрөх болон өнөө үед бодлогын шинжилгээ, судалгааны хэрэглээ салбарын яам, орон нутгийн засгийн газрын түвшинд түгээмэл болсон байна.

Өнөө цагт бодлогын шинжилгээ эсхүл төлөвлөлтийг хариуцан хийдэг засгийн газрын бодлогын судалгаа, шинжилгээний тусгай нэгжүүдэд албан ёсны бодлогын шинжээчдийн албан тушаалууд бий болсон байна. Ерөнхийлөгч эсхүл ерөнхий сайдын алба, эсхүл сангийн яам гэх мэт тэргүүлэх бодлогын яамдад мэргэжлийн бодлогын шинжээчдийн албан тушаалуудыг үүсгэн, мэргэжлийн хүмүүсийг авч ажиллуулах болжээ. Бодлогын шинжилгээний нэгжүүд нь шатлан захирах босоо удирдлагатай төрийн байгууллагуудын дотор эрэмбэ нь өндөр байх бөгөөд тухайн байгууллагын хамгийн өндөр эрэмбэтэй бодлогын шийдвэр гаргагч удирдлагаас тус бодлогын шинжилгээний нэгжийн албан хаагчид томилогдож, ажлаа тайлагнах үүрэг хүлээдэг тогтолцоо түгээмэл болсон байна. Хуучин цагт одоогийнхоос нь ялгаатай нь тусгай бодлогын шинжилгээний нэгж байгаагүй түүний оронд бодлогын шинжээчийн ажлын байрны орон тоо төрийн байгууллагуудад байжээ.

Зураг 3: Төрийн байгууллагуудын бодлогын шинжээчийн ажлын байранд гарсан өөрчлөлт



Бодлогын шинжилгээний нэгжүүд дараах үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг хүлээж ажилладаг.⁷ Үүнд:

- Төрийн бодлогын асуудлуудад чиглэсэн бодлогын саналыг боловсруулах
- Засгийн газрын хэрэгжүүлж буй тодорхой хөтөлбөрүүдийн бодлогын шинжилгээний ажлыг зохион байгуулах үүрэг хүлээдэг.
- Төрийн хөтөлбөр, бодлогын хяналт, үнэлгээний ажилд шаардлагатай бодлогын судалгааны ажил хийх
- Шуурхай болон тухайн цаг үед хэрэгцээ, шаардлагатай байгаа бодлогын болон үнэлгээний мэдээллээр шийдвэр гаргах түвшний удирдах ажилтнуудыг хангах

Бодлогын шинжилгээний нэгжийн үүрэг үйл ажиллагаагаа зөв, амжилттай явагдаж байгаа үед тухайн төрийн байгууллага өөрийн байгууллагын мэргэжлийн бодлогын нэгжийн санал, зөвлөмж дээр тулгуурлан үйл ажиллагаагаа явуулж зорилтод төрийн бодлогын асуудлуудыг амжилттай шийдвэрлэх нөхцөл бүрддэг байна.

Гүйцэтгэх засаглалын өндөр түвшний бодлогын нэгжүүдээс гадна засгийн газрын тогтолцооны бусад түвшин хэсгүүдэд бодлогын шинжилгээний хэрэглээ улам бүр нийтлэг болж байна. Ихэнх төрийн агентлагууд, орон нутгийн засгийн газрын гүйцэтгэх засаглалд жижиг бодлогын шинжилгээний албад эсхүл тэдэнд ажлаа шууд тайлагнадаг бодлогын зөвлөхүүд ажилладаг болсон байна. Мөн гүйцэтгэх засаглалын салбарт ажиллаж буй төсвийн шинжээчид, эдийн засагчид, хөтөлбөрийн үнэлгээчид, төлөвлөгөөний мэргэжилтнүүд, засгийн газрын судалгааны дэд бүтцэд ажиллаж буй судлаачид, статистикийн мэргэжилтнүүд янз бүрийн чадамжаар бодлогын шинжилгээнд оролцдог. Хууль тогтоох салбарт парламентын хороонууд, болон хууль тогтоогчийн хувийн ажилчид өргөн цар хүрээтэй бодлогын шинжилгээ хийдэг. Зарим улс орнуудад хууль тогтоогч байгууллагад үйлчилж чанартай бодлогын шинжилгээ хийдэг тинк танк байгууллагууд байдаг. Тухайлбал АНУ-ын Конгрессын Төсвийн Алба, АНУ-ын Засгийн газрын хариуцлагын алба

⁷ David L. Weimer and Aidan R. Vining, Policy Analysis: Concepts and Practice (3rd Edition), Upper Saddle River, NJ: Prentice-Hall, 1999, 36-37.

3.3.2. Засгийн газрын тогтолцооны гадна талд байх бодлогын судалгаа, шинжилгээ

Засгийн газрын гадна талд бие даан ажилладаг зөвлөхүүд эсхүл зөвлөх үйлчилгээний пүүсүүд, тинк танкууд, тодорхой бодлогын сонирхлыг дэмждэг сонирхлын бүлгүүд болон байгууллагууд, лобби бүлгүүд, экспертүүд, олон нийтийн хэрэгслийн мэргэжлийн хүмүүс, хувь хүмүүс бодлогын шинжилгээ хийдэг болсон байна. Буурай хөгжилтэй орнуудад донор байгууллагууд бодлогын шинжилгээ хийж, бодлогын зөвлөмж хүргүүлдэг түгээмэл туршлага байдаг. Засгийн газрын бодлогын мэргэжилтнүүд өөрсдийн мэдээлэл, зөвлөмжөө сайжруулахын тулд засгийн газрын тогтолцооны гадна талаас ирүүлсэн бодлогын зөвлөмжүүдэд стратегийн хувьд үнэлгээ хийж байх хэрэгтэй байдаг.

○ Тинк Танк байгууллагууд

- Бодлогын судалгаанд мэргэшиж үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг бид тинк танк байгууллага гэж нэрлэдэг. Ийм төрлийн байгууллагууд ашгийн бус статусаар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд бие даан үйл ажиллагаагаа явуулах юм уу эсвэл судалгааны эсхүл боловсролын малгай байгууллагын доор байгуулагдан бодлогын шинжилгээний үйл ажиллагаа явуулдаг. Тинк танк байгууллагуудад ажиллаж буй бодлогын экспертүүд бодлогын шинжилгээ хийж төрийн албанд ажиллаж буй бодлогын шинжээчид, шийдвэр гаргагч удирдлагуудад бодлогын зөвлөмжөө хүргүүлэх замаар, засгийн газрын шийдвэрт шууд нөлөөлдөг туршлага олон оронд түгээмэл болсон байна. Мөн хэвлэлийн бага хуралд оролцож, ард иргэдэд мэдээлэл өгөх арга замаар засгийн газрын шийдвэрт шууд бус байдлаар нөлөө үзүүлэх тинк танк байгууллагуудын арга, барил дэлхий даяар ихэд түгээн дэлгэрч байна. Зарим оронд засгийн газар тинк танк байгууллагуудтай засгийн газрын бодлогын судалгаа явуулах гэрээ байгуулан төлбөртэй бодлогын шинжилгээний үйлчилгээ авч ажилладаг төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны шинэ хэлбэр гарч ирсэн байна. Хувийн сангууд, корпорацууд, бүлгүүд эсхүл хувь хүмүүсийн санхүүгийн дэмжлэг, санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулдаг санхүүжилтийн хэлбэр тинк танк байгууллагуудын дунд хамгийн их түгэн дэлгэрсэн байна. Хөрөнгө оруулалтын сан, гишүүдийн төлбөр, зөвлөх үйлчилгээний төлбөрөөр үндсэн орлогоо бүрдүүлж үйл ажиллагаагаа явуулдаг тинк танк байгууллагын санхүүжилтийн хэлбэр бас байдаг. Тинк танк байгууллагууд төвийг сахисан, төрийн бодлогын судалгаа явуулдаг боловч тодорхой улс төрийн зорилго бүхий лобби бүлэг, сонирхлын бусад бүлгүүд тинк танк байгууллагуудыг санхүүжүүлэх явдал өсөн нэмэгдэж байгаа нь тинк танк байгууллагуудын бодлогын зөвлөмжийн чанар, чиглэлд шууд нөлөө үзүүлэх тохиолдол их болжээ. Тийм учраас тинк танк байгууллагуудаас мэдээлэл, зөвлөмж авч байгаа хэрэглэгч нэг талыг барьсан зөвлөмж, мэдээллээс урьдчилан сэргийлэх, ажлын чанарт нь үнэлгээ хийхийн

тулд тинк танк байгууллагын зорилго, санхүүжилтийн эх сурвалж, нэр хүндэд анхаарал хандуулан ажиллах ёстой.

○ **Тодорхой бодлогыг дэмждэг сонирхлын бүлэг, байгууллагууд**

○ Тодорхой тойргийн сонгогчид эсхүл хүн амын тодорхой хэсгийн сонирхлыг тэргүүн зэрэгт тавин, ил тод дэмжин ажилладаг сонирхлын бүлэг, байгууллагууд тодорхой үзэл баримтлалыг дэмжих, хатуу улс төрийн зорилго, хүсэлд тулгуурлан төрийн бодлогын судалгаа, шинжилгээний ажлыг эрхлэн явуулдаг. Ийм сонирхлын бүлгүүдийн зарим нь өөрсдийгөө “тинк танк” байгууллага гэж нэрлэх тохиолдол байна. Эдгээр сонирхлын бүлгүүд бодлогын шинжээчид, шийдвэр гаргагч нарт үнэ цэнэтэй бодлогын судалгааны мэдээлэл өгч болох боловч сонирхлын бүлгүүдээс мэдээлэл авсан хэрэглэгчид улс төрийн тодорхой сонирхлыг дэмжсэн туйлширсан мэдээлэл байж болох эрсдэлийг тооцох хэрэгтэй.

○ **Лобби бүлэг**

○ Лобби бүлгүүд нь засгийн газрын бүх түвшний зохицуулагч агентлагуудын хууль тогтоогчид, албаны хүмүүсийн гаргах бодлогын шийдвэрүүдэд нөлөөлөхийг эрмэлзэж буй хувь хүмүүс, байгууллагууд болно. Лобби зорилготой бодлогын судалгаа, шинжилгээг хүссэн хувь хүмүүс, бүх төрийн байгууллагууд хийх болно. Үүнд:

- хувь хүмүүс, хувийн хэвшил (бүх салбарын аж үйлдвэрийн корпорац, бизнесийн хүмүүс),
- ашгийн бус байгууллагууд (холбоо, эвсэл, сонирхлын бүлгүүд, буяны байгууллагууд гэх мэт),
- тэр байтугай нийтийн салбарын байгууллагууд (орон нутгийн засгийн

○ **Экспертүүд**

○ Бие даан ажилладаг эсхүл байгууллагад ажилладаг экспертүүд засгийн газар, бизнесийн байгууллага, ашгийн бус байгууллагад тодорхой төлбөртэй бодлогын судалгаа, шинжилгээний зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын туршлага байна. Хувь экспертүүд бодлогын шинжилгээ хийх бол хамтран ажиллах байгууллага тухайн



Сонирхлын бүлгүүдийн бодлогын судалгааны мэдээллийг хэрэглэхдээ улс төрийн тодорхой сонирхолыг дэмжсэн туйлширсан мэдээлэл байж болох эрсдлийг тооцох хэрэгтэй

экспертүүдийн өмнөх ажлуудын найдвартай байдал, чанар, нэр хүндэд үнэлгээ хийх хэрэгтэй.

- **Олон нийтийн хэрэгсэл**

- Сэтгүүлчид, редакторууд гэх мэт олон нийтийн хэрэгслийн мэргэжлийн хүмүүс стратегийн үүднээс бодлогын судалгаа хийж бодлогын асуудлуудыг тодорхойлж, бодлогын шийдлүүдийг санал болгох замаар төрийн бодлогод хүчтэй нөлөө үзүүлэх бүрэн чадвартай байдаг төдийгүй төрийн бодлого, бодлого гаргагч нарын бодлогын сонирхолд шууд ба шууд бусаар нөлөөлж байдаг

- **Иргэд**

- Төрийн бодлогын асуудлуудаар иргэд бодлогын шинжилгээ хийж, харилцан судалгааны үр дүнгээ солилцон бодлогын шийдвэр гаргагч нар оролцсон уулзалтууд оролцох эсхүл бодлогын шийдвэр гаргагч нарт албан захидал хүргүүлэх гэх мэтийн шууд хэлбэрээр эсхүл сонинд нийтлэл бичих, блок хөтлөх зэргээр шууд бусаар бодлогын шинжилгээний үр дүнгээ түгээн дэлгэрүүлж төрийн бодлогод нөлөөлөх оролдлого, туршлагаа нэвтрүүлэх зэрэг нь олон улс оронд энгийн зүйл болсон байна. Харин засгийн газар, олон нийтийн хооронд харилцаа холбоо үүсэх боломжгүй улс орнуудад иргэд эвлэлдэн нэгдэж жагсаал, цуглаан зохион байгуулж өөрсдийн бодлогын судалгааны үр дүнгээ төрийн бодлого боловсруулах эрх бүхий байгууллагуудад ойлгуулж, төрийн бодлогод нөлөөлөхийг оролддог.

- **Донор байгууллагууд**

- Олон улсын хөгжлийн агентлагууд гэх мэт донор байгууллагууд хөгжиж байгаа орнуудын эсхүл буурай хөгжилтэй орнуудын нийтийн бодлогын асуудлуудаар судалгаа явуулж, хөгжлийн бодлогыг боловсруулах үйл явцад ихээхэн нөлөө үзүүлж ажилладаг. Донор байгууллагууд өөрөө бодлогын шинжилгээ хийх юм уу эсвэл бие даасан эсхүл хувийн хэвшлийн зөвлөхүүдтэй гэрээ хийн хамтран ажилладаг. Ихэнх донор байгууллагууд янз бүрийн хөгжиж буй орнуудад бодлогын шинжилгээ явуулж ирсэн баялаг туршлагатай байдаг боловч донор байгууллагуудын хийсэн судалгаа тухайн орны эсхүл орон нутгийн нийтийн бодлогын асуудалд тохирч байгаа эсэхэд үнэлгээ хэрэгтэй байдаг.

Төрийн бодлогын судалгаа, шинжилгээний үр дүнг зөвхөн засгийн газар хэрэглэдэг үе түүхэн цаг хугацаанд хуучирч үлдэх үзэгдэл аль хэдийн эхэлсэн байна. Засгийн газрын гадна талд байх оролцогч талууд засгийн газрын одоогийн болон шинээр дэвшүүлж буй бодлого, асуудлууд тэдний зорилгод хэрхэн нөлөөлөх вэ гэдэгт үнэлгээ хийхийн тулд

бодлогын шинжээч нартай хамтран ажиллах болсон байна. Зарим тохиолдолд хувийн хэвшлийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд бодлогын шинжээчдийг ажилд авч, бодлогын шинжилгээ хийж, өөрсдийн ажилтай холбоотой бодлогын шийдлүүдийг боловсруулж засгийн газрын бодлогын шийдвэрт нөлөөлөх үйл ажиллагаа явуулдаг болсон байна.

3.4. БНСУ-ын боловсролын бодлогын судалгааны туршлага

3.4.1. Яагаад Солонгос улс?

БНСУ-д 1960-аад оны эхэнд Пак Жонг Хи генерал төрийн эргэлт хийж хөгжлийн төлөө цэргийн дэглэмтэй улсыг байгуулсан. Цэргийн эргэлтийн дараа Кеннедигийн засгийн газрын шахалтаар Пак Генерал иргэний эрх зүйг сэргээх тохиролцоонд хүрсэн билээ. Ингээд улмаар Пак Генерал 1963 онд БНСУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсон. Түүний засаглалын үед БНСУ-ын засгийн газар ядуурлыг эцэс болгох, захын бүсийн ядуу дорой улсаас үндсэн бүсийн хөгжингүй улс орныг бүтээхэд эдийн засгийн хөгжлийг нэн тэргүүнд тавьж эхэлсэн юм. Энэ зорилгоо хэрэгжүүлэхдээ экспортод чиглэсэн аж үйлдвэрийг төрийн хүчтэй оролцоотой нэмэгдүүлэхийг зорьсон. Япон улсын хөгжлийн загварыг сонгон авч хөгжлийн гараа нь эхэлсэн түүхтэй. 24 цагийн цахилгаан хангамжтай болох зорилтоос эхлэн төрийн өмчид Пуханы гангын үйлдвэр, Хьюндай, Эл Жи, Самсунг гэх мэт том бизнесүүдийг тал бүрээр хөхүүлэн дэмжиж, Сөүл-Пусаны хурдны зам гэх мэт дэд бүтцийн хөгжлийг бий болгох зэргээр үлэмж хурдтай бүтээн байгуулалт, эдийн засгийн шинэчлэл, хөгжил, цэцэглэлтийг өрнүүлсэн байна.

Эдийн засгийн хурдтай хөгжилтэй зэрэгцээд 1970-1990 онд тус улсад үндэсний сэргэн мандалтыг бий болгохын тулд нийгмийн нэгдэл, боловсролын хөгжил, хүний хөгжилд ихээхэн анхаарч эхэлсэн байдаг. Яг энэ түүхэн үеийн эхэнд буюу 1972 онд өнөөгийн боловсролын хөгжлийн хувьд хөгжингүй үндэстэн болж Солонгосын боловсролын салбарын амжилтыг бий болгоход гол үүрэг гүйцэтгэсэн Солонгосын боловсролын хөгжлийн институтийг байгуулсан. Өнөөдөр БНСУ ПИСА Олон улсын сурагчдын

үнэлгээгээр дэлхийн топ 21 улсын дотор эхний 9-д жагсах болсон.⁸ БНСУ-ын дээд боловсролын байгууллагууд хурдан хугацаанд хөгжиж Европ, Америкийн оюутнууд суралцдаг олон улсын түвшинд хүрсэн их сургуулиудтай болсон ба зарим судалгааны чиглэлээр дэлхийн шилдгүүдийн тоонд орж, хурдтай хөгжлөөр тэргүүлэх болсон.

Манай улсын хувьд ч гэсэн тэртээ 1970 оны БНСУ-ын Засгийн газрын өмнө тулгарч байсан ядуурлыг бууруулах, эдийн засгийн хөгжил цэцэглэлтийг бий болгох, үндэсний аж үйлдвэрийг далайцтай хөгжүүлэх, боловсролын хөгжлөөр дамжуулан нийгмийн өөрчлөлтийг байгуулах зэрэг хэрэгцээ шаардлага сүүлийн үед тулгараад байна. Бид ч мөн адил Монголын боловсролын хөгжлийн зорилт, аргууд, бодлогын шийдлүүдийг шинжлэх ухаанчаар тодорхойлох, бодлогын судалгаа явуулдаг үндэсний боловсролын бодлогын судалгааны институтийг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага гарч иржээ. Тиймээс манай орны өнөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн ойролцоо гараа, нөхцөлөөс эхэлсэн БНСУ-ын боловсролын хөгжлийн бодлогын судалгааны туршлагаас суралцах нь өндөр ач холбогдолтой тул энэ хэсэгт БНСУ-ын боловсролын судалгааны институцийн хөгжил, онцлогийг танилцуулахаар болсон.

3.4.2. Солонгосын боловсролын хөгжлийн институт

БНСУ-ын боловсролын салбарын бодлогын хөгжил, түүний хэрэгжилтийг хангах тэргүүлэх үүрэгтэй оролцдог байгууллага бол Солонгосын боловсролын хөгжлийн институт юм. Тус хүрээлэн БНСУ-ын боловсролын салбарын бодлогын асуудлуудыг шинжлэх ухааны үндэстэйгээр, системтэйгээр судалж, үндэсний боловсролын хөтөлбөрийг тодорхойлох үндэсний боловсролын тинк, танкийг байгуулах хэрэгцээ шаардлагаас үүдэн 1972 онд байгуулагдсан байна.

⁸ ПИСА 2018 үр дүн, <https://www.oecd.org/pisa/publications/pisa-2018-results.htm>

Тус хүрээлэн байгуулагдсан цагаасаа хойш үндэсний боловсролын чанарыг сайжруулах зорилгоор Солонгосын боловсролын салбарт гарч ирсэн асуудал, сорилтуудад бодлогын шинжилгээ, судалгаа явуулж боловсролын тогтолцоог шинэчлэн, сайжруулж хөгжүүлэх инновацлаг бодлогын шийдлүүд, зөвлөмжийг тасралтгүй боловсруулан гаргаж иржээ.

Өнөөдөр тус хүрээлэн Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага, ЮНЕСКО, Дэлхийн банк гэх мэт олон улсын байгууллагуудтай өргөн цар хүрээтэй хамтран ажилладаг дэлхийн түвшний боловсролын бодлогын судалгааны шилдэг институт болж чадсан байна. Солонгосын боловсролын хөгжлийн хүрээлэн авьяас, чадвараа бүрэн нээн илрүүлэх, ирээдүйн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хувь хүний чадамж, мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх боломжийг суралцагч нарт олгох боловсролын шинэ парадигмыг цогцлуулан хөгжүүлэхэд бодлогын судалгааны ажлаа чиглүүлэн ажиллаж байна.

3.4.3. Дэлхийн хөгжил, Солонгосын нийгэм – эдийн засгийн хөгжлийн онцлогт нийцсэн алсын хараа зорилтууд

Шинэ зууны эхний гучин жилд “Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030” олон улсын бодлогын бичиг баримт дэлхийн улс орнуудын үндэсний хөгжлийн бодлогын зорилго, төрх, хандлагад хамгийн ихээр үр нөлөө үзүүлэх нь тодорхой болсон байна. Солонгосын боловсролын хөгжлийн бодлогын институт байгууллагынхаа алсын харааг тодорхойлоходоо хувь хүн ба нийгмийн тогтвортой хөгжлийг онцолсон нь шинэ зууны дэлхийн нийтийн хөгжлийн хандлагыг зөв ойлгож хийсэн оновчтой сонголт болсон байна.

Зураг 4: Солонгосын боловсролын хөгжлийн институтийн алсын хараа

Хувь хүн, нийгмийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах боловсролын бодлогын судалгааны дэлхийн тэргүүлэх институт

Эх сурвалж: <http://eng.kedi.re.kr/khome/eng/about/vision.do>

Улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлоход дэлхийн тогтолцоо, түүнд өрнөж буй шинэ хандлага, хөгжлийн шинэ төрх, загвар улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөөлж буйд дүн шинжилгээ хийж улс орныхоо боловсролын хөгжлийн урт хугацааны

бодлогыг тодорхойлох зөв боловч өөрийн орны хөгжлийн бодит байдалд нийцүүлэн дэлхийн хөгжлийн хандлагатай хослуулан бодлогын хүрээлэнгийн зорилго, зорилтоо өөрийн орны онцлогт тохируулан гаргах нь оновчтой байдаг. БНСУ өөрийн орны боловсролын бодлогын хүрээлэнг байгуулахдаа энэ тал дээр маш зөв сонголт хийж бодлогын хүрээлэнг байгуулах үндэслэл, зорилгоо тодорхойлжээ.

Хүснэгт 6: Солонгосын боловсролын хүрээлэнг байгуулсан, оршин тогтнож буй үндэслэл, зорилгууд

Солонгос Улсын нийгэм, эдийн засгийн асуудлууд	Боловсролын бодлогын хүрээлэнг байгуулах үндэслэл
Күнзийн соёлын уламжлал, төрийн эргэлтийн дараа гарсан хурдтай аж үйлдвэржилт, нийгмийн өөрчлөлт	Солонгос Улсын уламжлал, бодит байдлыг тусгасан шинэ боловсролын тогтолцоог байгуулах
Боловсролын салбарын амжилт, шинэ сорилтуудыг тодорхойлох	Солонгосын боловсролын бодит асуудлуудын талаар өргөн цар хүрээтэй шинжлэх ухаанч судалгаа явуулах
Шийдвэрлэгдээгүй боловсролын асуудлууд	Солонгосын боловсролын шийдвэрлэгдээгүй удсан асуудлуудыг шийдвэрлэх оновчтой шийдлүүдийг ирээдүйд бий болгохын тулд боловсролын тогтолцоог шинэчлэн сайжруулах

Олон улсын шилдэг туршлагаадаас харахад бодлогын судалгааны хүрээлэнгийн стратеги, түүний зорилтууд нийгэм эдийн засгийн цаг хугацааны хөгжлийн хандлагыг даган тодорхой хугацааны дараа өөрчлөгдөн, хувьсаж, хөгжиж байх ёстой. Хүн төрөлхтөн шинэ зуун дөнгөж гараад хорин гаран жил болох гэж байгаа боловч бидний төсөөлж байгаагүй их өөрчлөлт гарсан байна. Мэдлэгийн аж үйлдвэр, боловсролын капитализм, инновацын хөгжил, судалгааны сургууль, уян боловсрол, хөдөлмөрийн зах зээлийн даяаршил, хэрэглэгч төвтэй боловсрол, дижитал технологийн хувьсгал манай шинэ эрин үед боловсролын хэрэгцээ, шаардлага, зорилгыг шинээр тодорхойлоход хүргэж байна. Шинэ зууны хөгжлийн хурднаас хамааран огцом хурдаар өөрчлөгдөн хөгжиж буй дэлхийн боловсролын шинэ хандлагад нийцүүлэн Солонгосын боловсролын бодлогын хүрээлэн өөрийн байгууллагын зорилтуудаа шинээр тодорхойлсон байна. Ингэхдээ даяаршсан дэлхийн зах зээлийн эдийн засагт мэдлэгийн аж үйлдвэр, мэдлэгийн капитализмын үзүүлж буй үр нөлөө улам бүр өргөн цар хүрээтэй болж буйг харгалзан үзэж даяаршсан дэлхийн мэдлэгийн капитализмын зах зээл дээрх Солонгос улсын өрсөлдөх чадварыг сайжруулах,

тус улсын мэдлэгийн эдийн засгийн нөөцийг нэмэгдүүлэх зорилтуудын хэрэгжилтийг дэмжиж ажиллахын тулд боловсролын бодлогын инновац, өөрчлөлт, шинэчлэлийг дэмжих тус институтийн судалгаа, хөгжүүлэлтийн чадамжийг бэхжүүлэх дэлхий дээр өрнөж буй шинэ өөрчлөлт, хандлагыг соргог мэдэрч хийсэн хэд хэдэн томоохон зорилтуудыг дэвшүүлсэн байна. Манай дэлхийн нийгэм, эдийн засаг, технологийн өөрчлөлт, хөгжил нь манай улсад ч гэсэн нөлөөлж эхэлсэн нь тодорхой болж байгаа тул Солонгосын боловсролын хөгжлийн институтийн дэвшүүлэн ажиллаж буй зорилтуудыг анхааралтай судалж, манай улсын онцлогт тохирох зорилтуудыг нутагшуулж нэвтрүүлэх хэрэгтэй юм.

Хүснэгт 7: Солонгосын боловсролын бодлогын хүрээлэнгийн шинэ зууны дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн дэвшүүлсэн зорилтууд

Шинэ зууны боловсролын шинэ хэрэгцээ, шаардлага	Боловсролын бодлогын хүрээлэн дэвшүүлсэн зорилтууд
Академик капитализмыг дэмжих шинэ боловсролын парадигмыг хөгжүүлэх	Боловсролын бодлогын манлайлагч байгууллагын хувьд бодлогын судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих Ирээдүйн боловсролын бодлого, байгууллагын инновацыг дэмжих судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих Олон улсын хамтарсан судалгааны хөгжлийг бэхжүүлэх Шинжлэх ухаанч, нотолгоо дээр суурилсан боловсролын бодлогын судалгаа, хөгжүүлэлтийг бэхжүүлэх
Судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнг боловсролын салбарт цаг алдалгүй түгээн дэлгэрүүлэх хэрэгцээ	Судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнгийн хэрэглээг дэмжих Хэрэглэгч төвтэй судалгаа хөгжүүлэлтийг үр дүнг нэмэгдүүлэх Өргөн цар хүрээтэй хүчирхэг сүлжээгээр судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнг түгээх

3.4.4. Боловсрол, хүний нөөцийн хөгжил – Солонгосын боловсролын хөгжлийн институтийн бүтэц, зохион байгуулалтын онцлог

Солонгосын боловсролын хөгжлийн институт Өмнөд Солонгосын боловсрол, хүний нөөцийн хөгжлийн яаманд үйлчилдэг боловсролын бодлогын судалгааны институт болно. Тус бодлогын хүрээлэн өөрийн үйлчилдэг түнш байгууллага болох Боловсрол, хүний нөөцийн хөгжлийн яамны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрийн дотоод бүтэц, зохион байгуулалт хийсэн нь оновчтой шийдэл болсон байна.

Дэлхийн улс орнуудын нийтлэг жишгийн дагуу бага, дунд боловсрол төрийн бодлого, үйлчилгээний үндсэн тусгагдахуун байдаг. Бага, боловсролын үйлчилгээ, дэмжлэг тулгуурлан төр өөрийн үндэсний хамтын үнэт зүйл, хамтын хүсүүштэй төрх, хамтын ёс

суртахуун, улс орны баялгийг бүтээхэд гар бие оролцох сайн иргэнийг бэлтгэж авдаг. Энэ дэлхийн жишгийн дагуу Өмнөд Солонгосын Боловсрол, хүний нөөцийн хөгжлийн яам бага, дунд боловсролын чанарт анхаарал хандуулж ажиллах нь зүйтэй юм. Солонгосын боловсролын хөгжлийн институт бүтэц, зохион байгуулалтын тэргүүн эгнээнд бага, дунд боловсролын тасаг байна. Бага, дунд боловсролын судалгааны тасаг Сургуулийн боловсролын судалгааны алба, Багшийн боловсролын судалгааны алба, Ардчилсан иргэний боловсролын судалгааны алба, Орон нутгийн боловсролын санхүүгийн судалгааны төв, Ахлах сургуулийн кредит системийн судалгааны төв гэсэн гурван алба, хоёр төвтэй байна.

Зураг 5: Бага, дунд боловсролын судалгааны асуудал



Бага, дунд боловсролын судалгааны тасгийн дотоод бүтэц, зохион байгуулалт нь төрийн нийгмийн бодлогын асуудлуудын төрлүүдээр хуваагдан хийгдсэн нь ерөнхий, суурь боловсролын талаарх төрийн бодлогын асуудлууд, зорилгуудтай уялдаа холбоо сайн үр дүнтэй бүтэц болж өгсөн байна. Хүний хөгжлийн гол хэмжүүр бол боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх нөхцөл байдаг. Сургуулийн боловсролын судалгааны алба энэ хэмжүүртэй бүрэн нийцэж байна. Ур чадвар сайн, багшийн хүний нөөц бол сургуулийн


боловсролын чанарт шууд нөлөөлөх хүчин зүйл байдаг. Чанартай тэгш боловсролын орчныг бүрдүүлэх явдал төрийн боловсролын бодлогын гол зорилгуудын нэг байдаг. Энэ зорилгын үүднээс Багшийн судалгааны албыг байгуулсан нь тодорхой байна. БНСУ нь Монгол Улстай адил 1990 оноос хойш ардчилсан улсыг байгуулах зорилтыг тавьж амжилттай хэрэгжүүлж яваа үлгэр жишээ улсын нэг мөн. Ардчиллыг бэхжүүлэхийн тулд ардчилсан нийгмийн чанартай боловсролыг иргэн хүнд олгож байж нийгэм дотор ардчиллын үнэт зүйл, дэмжлэг бодитоор бүрэлдэн бий болох нь тодорхой юм. Ардчилсан иргэний боловсролын судалгааны албыг байгуулж, ардчиллын боловсролыг түгээх тал дээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа нь манай улс суралцах ёстой сайн туршлага байна.

Манай улсын Боловсролын хүрээлэнгийн хувьд Боловсролын хөтөлбөрийн судалгааны сектор, Сурах бичиг, сургалтын орчны судалгааны сектор гэх мэтээр төрийн бодлогын төрлүүдээр бус илүү боловсрол судлалын хүрээлэнгийн сургалтын судалгааны асуудлаар секторуудыг зохион байгуулж академик судалгаа давамгайлсан үйл ажиллагаа явуулж ирсэн байдаг. Харин уг хүрээлэнг бодлогын судалгааны институт хэлбэрээр хөгжүүлэх зорилго тавих юм бол төрийн бодлогын асуудлуудаар бүтэц, зохион байгуулалтыг нь өөрчлөн зохион байгуулах шаардлагатай байна.

Мэдлэгийн эдийн засгийн даяаршил, дэлхийн их сургуулиудын, бүс нутгийн болон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагуудын үр нөлөөгөөр дэлхийн улс орнууд үндэсний дээд боловсролын байгууллагуудын өрсөлдөх чадварт ихээхэн хандуулан ажиллах болсон байна. Дэлхийн мэдлэгийн аж үйлдвэрийн зах зээл дээр үндэсний аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд дэлхийн түвшний судалгааны их сургуулиудыг хөгжүүлэх зорилт тавин ажиллах болсон байна. Энэ зорилгоор дэлхийн улс орнууд дээд боловсролын бодлого, тогтолцоондоо өөрчлөлт шинэчлэлт хийх өргөн далайцтай ажлыг эхлүүлж байна. Эдийн засгийн хөгжил үндэсний экспортын бүтээгдэхүүн, технологийн хөгжлөөс үлэмж ихээр хамаардаг Солонгос улсад шинэ зууны боловсролын салбарын өрсөлдөөний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн дээд боловсролын салбарын шинэчлэлт, өөрчлөлтийн бодлогод өндөр ач холбогдол өгөн ажилладаг байна. Солонгосын боловсролын хөгжлийн институтийн хоёр дахь гол салбар нь Дээд боловсролын бодлогын судалгааны салбар бөгөөд энэ нь Дээд боловсролын бодлогын судалгааны алба, Дээд

боловсролын тогтолцооны судалгааны алба, Их сургуулийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээний төвөөс бүрддэг.

Зураг 6: Дээд боловсролын бодлогын судалгааны салбар



Бага, дунд боловсрол, дээд боловсролын бодлогын судалгааны салбар, алба, төвүүдээс гадна орчин үеийн дэлхийн боловсролын хөгжил, дэлхийн хөдөлмөрийн зах зээлийн даяаршлын хурдтай, хөгжилтэй, холбоотой ирээдүйн буюу шинэ зууны боловсролын бодлогын судалгааны нэгжүүдийг Солонгосын боловсролын хөгжлийн институт дотор байгуулсан нь цаг үеэ олсон оновчтой бүтэц, зохион байгуулалтын шийдэл болсон байна.

Зураг 7: Ирээдүйн боловсролын судалгааны салбар



Боловсролын хөгжлийн талаарх төрийн бодлогын нэг чухал хэсэг нь нийгмийн халамж хамгааллын бодлого байдаг. Мөн боловсролын бүтээгдэхүүн, сургалтын технологийн олон талт байдлыг дэмжих, иргэд авьяас чадвараа нээн хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх, дэмжиж ажиллах зэрэг байдаг. Солонгосын боловсролын хөгжлийн институтийн Боловсролын бодлогын дэмжлэгийн судалгааны салбар нь боловсролын нийгмийн


халамж, боловсролын дэмжлэгийн төрийн бодлого, шийдлүүдийн судалгааны ажлыг эрхлэн явуулдаг байна.

Зураг 8: Боловсролын бодлогын дэмжлэгийн судалгааны төв



Боловсролын бодлогын судалгааны хүрээлэнгийн нийтлэг хүлээдэг үүргийн хамгийн чухал хэсэг нь урт хугацааны панель судалгааны болон хам цагийн статистик өгөгдөл цуглуулж боловсролын салбарын төрийн бодлого, хөтөлбөрийн нийгэм, эдийн засгийн үр нөлөөнд дүн шинжилгээ хийх үүрэг хүлээдэг. Энэ үүргийг Солонгосын боловсролын хөгжлийн институт дотор Үндэсний боловсролын статистикийн судалгааны салбар гүйцэтгэдэг.

Зураг 9: Үндэсний боловсролын статистик судалгааны салбар



3.5. Сингапур улсын туршлага

3.5.1. Яагаад Сингапур улс?

1965 онд тусгаар тогтносон улс болсон үеэсээ эхлэн Сингапур улс нь хүчтэй төрийн манлайлал бүхий зохицуулалттай капитализм, эдийн засгийн национализмыг дэмждэг “Хөгжлийн төр улс”-ын загвараар хөгжиж ирсэн. “Хөгжлийн төр улсын” загвараар хөгжиж ирсэн Япон, БНСУ, БНХАУ гэх мэт улс орнууд улс төрийн хувьд олон улсад хүлээн

зөвшөөрөгдөх, дэд бүтцийг хөгжүүлэхэд шаардлагатай нөөцийг бий болгох суурь хэрэгсэл нь эдийн засгийн хөгжил гэж үздэг.

Ийм улс орнууд эдийн засгийн хөгжил, нийгмийн нэгдэл, ирээдүйд чиглэсэн алсын хараа байхгүйгээр үндэстэн болон нийгэм удаан оршин тогтнож чадахгүй гэсэн суурь итгэл үнэмшилтэй байдаг. Энэ итгэл үнэмшилтэй холбоотойгоор Сингапур улсын боловсролын бодлого эдийн засгийн хөгжлийг дэмжих хүний капиталыг бий болгоход чиглэж ирсэн байдаг бөгөөд энэ зорилтоо амжилттай хэрэгжүүлээд зогсохгүй дэлхийн улс орнууд суралцах ёстой үлгэр жишээ туршлага, загварыг бий болгосон байна. Сингапур улсын үндэсний эдийн засгийн хөгжилд жинтэй үр нөлөө үзүүлсэн дөрвөн боловсролын бодлогын алсын хараа, зорилт, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байдаг.

1. Колоничлолын дараах үеийн амьдрах чадвартай үндэстнийг бий болгох боловсрол тогтолцоог бүрдүүлэх боловсролын бодлого (1965-1978)
 - Амьдрахуйд чиглэсэн боловсрол – нийгмийн нэгдлийг бүтээх, хөдөлмөрийн зах зээлд хэрэгтэй ур чадвартай иргэн бэлдэх
2. Аж үйлдвэржсэн эдийн засгийн тогтолцоог дэмжих боловсролын бодлого (1965-1978)
 - Үр ашигт чиглэсэн боловсрол
3. Мэдлэгийн эдийн засгийн тогтолцоог бүтээн байгуулах боловсролын бодлого (1997-2011)
 - Чадварт чиглэсэн боловсрол
4. Нийгмийн нэгдлийг бүтээх боловсролын тогтолцоо (2012-Одоо хүртэл)
 - Оюутан төвтэй, нэмэгдсэн өртөгт чиглэсэн боловсрол

Сингапур улсын төрийн боловсролын бодлого эхний гурван зорилтоо амжилттай хэрэгжүүлж чадсан. Одоо дөрөв дэх том зорилтоо амжилттай хэрэгжүүлж эхэлсэн байна. Өнөөдөр Сингапур улс хамтдаа хөгжлийн гайхамшгийг үзүүлсэн Хонг Конг, Өмнөд Солонгос, Тайванийг нэг хүнд ноогдох үндэсний нийт бүтээгдэхүүний тоогоор хол даван гарсан байна.

Сүүлийн хэдэн жил манай Монгол Улсын засгийн газар боловсролын эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг дорвитойгоор нэмэгдүүлэх тал дээр ихээхэн ач холбогдол өгөх

болсон билээ. Тийм ч учраас боловсролын бодлого бүр нь эдийн засаг, нийгмийн хөгжилд жинтэй үр нөлөө үзүүлж ирсэн. Сингапур улсын боловсролын нийтийн бодлогыг тодорхойлох, бодлогын шийдлийг сонгох шинжлэх ухаанч судалгаа үйл ажиллагаа тус улсад хэрхэн, яаж, ямар зохион байгуулалтаар хийгддэг талаар сонирхон судлах, суралцах нь манай улсад үр өгөөжтэй тул энэ хэсэгт Сингапур улсын боловсролын бодлогын судалгааны институцийн хөгжлийн онцлогийг танилцуулахыг зорьсон.

3.5.2. Боловсролын судалгаа, практик, бодлогын нэгдэл

Сингапур улс Боловсролын яамны алсын хараагаа “Эргэцүүлэн боддог сургуулиуд, Суралцдаг Үндэстэн” гэж тодорхойлсон байдаг.⁹ Энэ алсын хараа нь ирээдүйн сорилтуудыг даван туулах чадвартай эргэцүүлэн бодох ухаантай, бэлтгэгдсэн иргэд бүхий үндэстэн, 21 дүгээр зууны хэрэгцээ, шаардлагад нийцсэн боловсролын тогтолцоог илэрхийлдэг. Тус яамны эрхэм зорилго нь үндэстний ирээдүйг тодорхойлох хүмүүсийг бэлтгэн хөгжүүлэх замаар улс орныхоо ирээдүйг бүтээн байгуулах явдал юм гэжээ. Уг яамны алсын хараа, эрхэм зорилгын тавьсан зорилтуудтай нийцсэн прагматик хэлбэрээр Сингапурын боловсролын салбарын бодлогын судалгааны тогтолцоо зохион байгуулагдаж хөгжсөн байдаг.

Сингапур улсын төр нь дэлхийн зах зээл дээр гарч байгаа өөрчлөлт, сорилтууд дээр дүн шинжилгээ хийгээд ямар ур чадвар, мэдлэг эзэмшсэн хүн, үндэстэн, даяаршсан зах зээлийн орчинд эдийн засгийн хөгжлийг бий болгож чадах вэ гэдгийг тодорхойлоод сургуулийн ямар орчин, багшийн ямар арга зүй, сургалтын ямар хөтөлбөр дээр тулгуурлан улс орныхоо иргэдийг хэрхэн бэлтгэх вэ гэсэн бодлогыг хэрэгжүүлж ажилладаг. Тус улсын боловсролын төрийн бодлогын онцлог нь ирээдүйд тулгарах сорилт, төрийн бодлогын асуудлуудыг тодорхойлоод, боловсролын бодлогын асуудлуудын шийдлийг, сонгон

⁹ Сингапурын боловсролын яамны цахим хуудас, <https://www.moe.gov.sg/about>

хэрэгжүүлж эхэлсэн үеэсээ мэргэжлийн бодлогын судалгааны хүрээлэнг түшиглэн Боловсролын яамны бодлогын сонголтоор хэрэгжиж буй сургуулийн шинэ зан үйл, сургалтын шинэ хөтөлбөр, багшийн сурган заах арга зүйн шинэ технологи, ирээдүйн нийгэм, эдийн засгийн амьдралд үр өгөөжтэй оролцох, сайн иргэн ба хүний амьдрах чадварыг суралцагч бүрд сургалтын үр нөлөөгөөр бий болгох төрийн бодлогын хүлээсэн үр дүн гарч буй эсэхэд тасралтгүй үнэлгээ хийж, боловсролын салбарын бодлогоо зогсолтгүй засан сайжруулж байдаг. Ийм маягаар боловсролын салбарын төрийн бодлогыг шинжлэх ухаанч шинжилгээ, үнэлгээ, нотолгоонд тулгуурлан Боловсролын яамны чадамжийг бий болгох зорилгоор Нанянгийн технологийн их сургуулийн дэргэд Сингапурын Үндэсний Боловсролын Институтийг байгуулж, тус институтийн бүтэц зохион байгуулалтын дотор Боловсролын судалгааны албаны дэргэд “Сурган заах арга зүй ба практик судалгааны төвийг” 2003 онд байгуулсан байна. Тус институт нь дөрвөн гол зорилтын хэрэгжилтийг ханган ажилладаг.

Хүснэгт 8: Сурган заах арга зүй ба практик судалгааны төвийн үндсэн дөрвөн зорилт

Зорилт

Сингапурын сургуулийн заах арга зүйн төрхийг тодорхойлох, хэмжих

Суралцагчдад гарч буй үр дүнд үзүүлэх сурган заах арга зүйн нийгмийн үр нөлөөг хэмжих

Шинжлэх ухааны нотолгоон дээр суурилсан оролцооны стратеги дээр тулгуурлан сурган заах арга зүйн нийгэм, эдийн засгийн үр нөлөөг сайжруулах


21 дүгээр зууны шинэ нөхцөл, орчны сорилтуудад нийцсэн шинжлэх ухаанч нотолгоон дээр тулгуурлан төрийн бодлогыг гаргах нөхцлийг дэмжиж ажиллах

3.5.3. Үндэсний боловсролын институтийн судалгааны төвүүд

Боловсролын судалгааны алба нь тус хүрээлэнгийн боловсролын судалгааны засаглал, төлөвлөлт, хяналт, чанарын баталгаажуулалт, түгээн дэлгэрүүлэлтийг хариуцан ажилладаг. Боловсролын судалгааны албаны өөр нэг гол үүрэг нь Сингапурын Боловсролын яамны судалгааны сангийн санхүүжилтээр хэрэгждэг Боловсролын Судалгааны Санхүүжилтийн Хөтөлбөрийг удирдлагаар ханган ажиллах явдал байдаг. Боловсролын судалгааны алба нь “Сурган заах арга зүй, практикийн судалгааны төв”, “Боловсрол танин мэдэхүйн хөгжлийн лаб”, “Суралцахуйн шинжлэх ухааны лаб” гэсэн гурван төвтэй болно. Үүнээс Сингапурын сурган заах арга зүй төв нь сурган, заах арга зүй, практикийн шилдэг боловсролын судалгааны төв болохын төлөө Боловсролын яамны

санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг. Тус төв нь үндсэн зургаан чиглэлээр боловсролын судалгаа явуулдаг.

Зураг 10: Судалгааны чиглэлүүд



Олон улсын боловсролын шилдэг туршлагууд дотор Сингапур улс боловсролын хөгжил, гүйцэтгэлийн өндөр үзүүлэлтийг тогтмол гаргаж буй гол амжилтын түлхүүр нь Үндэсний боловсролын институт, Боловсролын яам, Сингапурын сургуулиудын нягт түншлэл, эвсэл болно.

Зураг 11: Гурван талын хамтын ажиллагаа ба эвсэл



Үндэсний боловсролын институт нь Боловсролын яам, боловсролын шинэ бодлого, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй сургуулийн шинэ менежмент, сургалтын шинэ технологи, сургалтын шинэ хөтөлбөр, сургалтын шинэ заах арга зүйн хэрэгжиж буй сургуулиудтай нягт хамтран ажиллаж судалгаа явуулсны үр дүнд боловсролын шинэ бодлого, шинэ хөтөлбөрүүдийн үр нөлөөний тухай шинжлэх ухаанч бодлогын судалгааны

үнэ цэнэтэй мэдээлэл, нотолгоо цуглуулж, эргээд Боловсролын яамыг бодлого судалгааны мэдээлэл, өгөгдөл, зөвлөмжөөр хангах боломжтой болдог. Энэ гурван талт хамтын ажиллагаанд тулгуурлан Сингапурын Боловсролын яам боловсролын салбарын бодлогоо шинжлэх ухаанч нотолгоо, туршлага дээр тулгуурлан бодлогын дүн шинжилгээ хийдэг. Энэ гуравласан хамтын ажиллагааны туйлын зорилго нь суралцагчдын суралцахуйн үр дүнг нэмэгдүүлэх замаар боловсролын тогтолцооны суралцахуйн нийгэм, эдийн засгийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршдог байна. Тийм ч учраас Сингапурын боловсролын яам, Үндэсний боловсролын институтийн судалгааны хамтын ажиллагаа сүүлийн 13 жилд ихээхэн нэмэгдсэн байна.

Зураг 12: Сүүлийн 13 жилийн байдлаар Гурван талт хамтын ажиллагаа



3.6. Дүгнэлт

Төрийн бодлогын асуудлуудыг илрүүлэх, хамгийн оновчтой шийдлүүдийг тодорхойлох засгийн газрын шийдвэр зөв гарах урьдчилсан нөхцөл нь чанартай бодлогын шинжилгээ, судалгааны ажил байдаг. Өнөө үед төрийн бодлогын асуудлууд нь олон салбарыг хамарсан, салбар дундын өнцгөөс харж, бодлогын шийдлүүдийг боловсруулах шаардлагатай болсон нарийн төвөгтэй нийгэм эдийн засгийн үзэгдлүүд болсон байна. Ийм нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхийн улс орнууд нийгэм, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын төрийн бодлогын хөгжилд зориулан төрийн бодлогын судалгааны хүрээлэнгүүдийг олноор байгуулан, шинжлэх ухаанчаар төрийн бодлогын асуудлуудыг тодорхойлж, бодлогын шийдлүүдийн сонголтыг хийдэг болжээ. Нэн ялангуяа үндэстний төлөвшил хөгжил, даяаршсан дэлхийн зах зээл дээр улс орнуудын өрсөлдөх чадварыг

нэмэгдүүлэхэд хамгийн их үр нөлөөтэй боловсролын салбарын бодлогын судалгааны хүрээлэн олноор байгуулагдан үйл ажиллагаагаа явуулдаг болсон байна. Гэтэл манай улсад боловсролын бодлогын судалгааны хүрээлэнг хөгжүүлэх ажил төрийн бодлогын гадна талд орхигдсон хэвээр байна. Тийм учраас бид боловсролын бодлогын судалгаа, шинжилгээний олон улсын туршлагыг тоймлон судлах зорилт тавьж ажилласан.

Бидний хийсэн судалгаанаас харахад нэгдүгээрт 1980-аад оноос эхлэн нийгэм, эдийн засгийн асуудлуудад бодлогын шинжилгээ хийж төрийн бодлогын асуудлуудыг тодорхойлох, тэдгээр асуудлуудыг хамгийн оновчтой байдлаар, хамгийн бага зардлаар шийдвэрлэх шийдлүүдийг бэлтгэх бодлогын шинжээчдийн хүний нөөцийг бэлтгэх ахисан түвшний сургуулиудыг олноор байгуулж эхэлсэн байна.

Хоёрдугаарт түүхэн хөгжлийн эхэн үед гүйцэтгэх засаглал буюу ерөнхийлөгч, ерөнхий сайдын албанд бодлогын шинжээчдийн ажлын байрууд байсан боловч өнгөрсөн зууны төгсгөл үеэс эхлэн бодлогын судалгааны бие даасан нэгжүүд байгуулагдан бодлогын судалгааг өргөн цар хүрээнд хийх болсон байна. Шинэ зуун гарсан үеэс эхлээд бодлогын судалгаа, шинжилгээний нэгжүүдийн үүрэг улам бүр өргөн дэлгэр болж засгийн газрын шаталсан засаглалын бүх түвшинд бодлогын шинжилгээний бие даасан нэгжүүд эсхүл салбарын бодлогын судалгааны хүрээлэнгүүд олноор байгуулагдан ажиллах болжээ. Салбарын яамд, орон нутгийн засгийн газрууд өөрсдийн бодлогын шинжилгээ, судалгааны нэгж, хүрээлэнгүүдийг байгуулж өөрсдийн бодлогын асуудлуудаа тодорхойлж, шийдлүүдээ шинжлэх ухаанч нотолгоонд тулгуурлан сонгох үзэгдэл түгээмэл байна.

Гуравдугаарт зөвхөн засгийн газрын мэргэжлийн байгууллагууд төрийн бодлогын шинжилгээний ажил явуулдаг байсан өнгөрсөн зууны соёл, шинэ зуунд аль хэдийн хоцрогдсон байна. Өнөөдөр засгийн газрын гадна талд төрийн бус бодлогын шинжилгээний тинк танкууд, тодорхой бодлого, үзэл баримтлалыг дэмжиж ажилладаг сонирхлын бүлгүүд, лобби бүлгүүд, хувь экспертүүд, иргэд, олон нийтийн мэдээллийн мэргэжилтнүүд, донор байгууллагууд бодлогын шинжилгээ, судалгаа явуулж шууд ба шууд бус байдлаар төрийн бодлогын шийдвэрт нөлөөлөхийг эрмэлздэг болсон байна.

IV. БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ӨРТГИЙН ҮР ДҮН, ӨРТГИЙН ҮР АШГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗАГВАР, АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА

4.1. Өртгийн үр дүнгийн шинжилгээ

4.1.1. Судалгааны зорилт

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өртгийн үр дүнгийн шинжилгээний шилдэг туршлага, загваруудыг сонгох

Төрийн бодлогын хүрээнд хэрэгжсэн оролцооны өртгийн үр дүнтэй байдалд шинжилгээ хийх олон янзын арга зүй дэлхий нийтэд хөгжиж бий болсон байна. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өртгийн үр дүнгийн шинжилгээний арга зүйн загваруудыг боловсруулж, хөгжүүлсэн эрдэмтдийн бүтээлүүдтэй танилцаж, судалгаа хийсэн. Уг судалгааны ажлын явцад Монгол Улсын боловсролын салбарт бодлогын судалгааны институт байгуулах хэрэгцээ, шаардлага бодитоор тавигдаж байгаа энэ үед төрийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд манай улсын боловсролын салбарт хэрэгжиж буй оролцооны хөтөлбөрүүдийн үр өгөөжтэй байдлыг үнэн зөв тодорхойлоход хэрэгтэй өртгийн үр ашгийн шинжилгээний ажлын чанарыг сайжруулахад, манай улсад нутагшуулахад ач холбогдолтой өртгийн үр дүнд үнэлгээ хийх олон улсын шилдэг туршлагуудыг тогтоох, сонголт хийх зорилт тавин ажилласан. Энэ зорилгоо биелүүлэхдээ өөрийн орны зохиолчдын бүтээл болон англи, солонгос хэлээр гарсан ном зохиолоос эх хэрэглэгдэхүүн цуглуулж судалгаа хийхийн зэрэгцээ судалгааны ажлын загварын хувьд дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн ач холбогдолтой, үр өгөөжтэй өргийн үр дүнгийн шинжилгээний арга зүйн загварыг монголын одоо үеийн нөхцөлд тохируулан шинэчлэн хэрэглэхээр сонгож авсан.


4.1.2. Өртгийн үр дүнгийн шинжилгээ гэж юу вэ?

Өртгийн үр ашгийн шинжилгээ гэж нэг эсхүл хэд хэдэн боловсролын нийтийн бодлогын оролцооны өртөг, үр дүнг харьцуулж дүгнэх арга зүйг хэлдэг. Нийтийн бодлого эсхүл хөтөлбөрийн оролцооны үр дүнг өөр нэг бодлогын оролцооны үр дүнтэй харьцуулж нэг нэгж үр дүнд хүрэхэд хэр их өртөг зарцуулж байна вэ гэдэгт шинжилгээ хийдэг.

4.1.3. Өртгийн үр дүнгийн шинжилгээ хийх үе шат

Өртгийн үр дүнгийн шинжилгээ нь нөхцөлийг тодорхойлох, өртгийн үнэлгээ хийх, үр нөлөөг тодорхойлох, өртөг ба үр дүнгийн харьцааг тогтоох гэсэн дөрвөн үе шат бүхий дэс дарааллын дагуу хийгдэнэ.


Зураг 13: Өртгийн үр дүнгийн шинжилгээний дөрвөн үе шат



4.1.4. Орцын арга ба өртгийн үр ашгийн шинжилгээ

Генри Левин боловсрол болон нийтийн салбарт өртгийн үр дүнгийн шинжилгээ хийх шууд хэрэглэж болох аргыг бий болгохын тулд “орцын арга”-ыг хөгжүүлсэн (Левин 1975; Левин, 2001; Левин, 2013). Орцын арга нь нийтийн бодлого эсхүл нийтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрэглэсэн бүх орцын жагсаалтыг гаргаж, тодорхойлдог. Уг шинжилгээний аргаар хөтөлбөрийн хэрэгжилтийг харуулах бүх орцын нарийвчилсан мэдээллийг гаргадаг. Орцын арга нь боломжийн өртөг, өртгийн бүртгэлийн стандарт арга зүйтэй тохирдог. Үүнээс гадна нэг сурагч эсхүл нэг окуутанд ноогдох өртөг, орц бүрийн өртгийг үнэлэх арга зүйтэй нийцдэг. Үүний үр дүнд харьцуулж болох боловсролын үр дүнд хүрэхэд янз бүрийн оролцоонуудын гаргаж буй харьцангуй үр ашгийг харьцуулах боломжийг олгож өгдөг. Орцын аргыг ашиглан өртгийн үр дүнгийн шинжилгээг дөрвөн үе шатаар хийдэг.

Зураг 14: Орцын аргын дөрвөн үе шат



4.2. Өртгийн үр ашгийн шинжилгээ

4.2.1. Зорилт

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өртгийн үр ашгийн шинжилгээний шилдэг туршлага, загваруудыг сонгох

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өртгийн үр ашгийн шинжилгээний арга зүйн загваруудыг боловсруулж, хөгжүүлсэн эрдэмтдийн бүтээлүүдтэй танилцаж, судалгаа хийсэн. Уг судалгааны ажлын явцад манай улсын боловсролын салбарын өртгийн үр ашгийн шинжилгээний ажлын чанарыг сайжруулахад хэрэгтэй олон улсын шилдэг туршлагауд, шинжилгээний загваруудыг тогтоох зорилт тавин ажилласан.

4.2.2. Өртгийн үр ашгийн шинжилгээ гэж юу вэ?

Өртгийн үр ашгийн шинжилгээ нь өртөг, гарах үр дүнг мөнгөний нэгжээр хэмждэг. Өртгийн үр ашгийн шинжилгээ нь хөтөлбөрүүдийн хоорондох өртөг үр ашгийг харьцуулдаг. Өртгийн үр ашгийн шинжилгээ нь хөтөлбөрийн зардал нь хөтөлбөрийн үр ашгаас бага, ойролцоо, эсхүл даван гарч байгаа эсэхийг тодорхойлдог. Өөрөөр хэлбэл өртгийн үр ашгийн шинжилгээ нь тодорхой бодлогын шийдлийн өртгийг, нийт үр ашигтай нь харьцуулж үнэлгээ хийдэг. Зарчмын хувьд бодлогын зохицуулалтын үр ашигтай байдал эсхүл нөөцийн хуваарилалтын үр нөлөөг хэмждэг гэсэн үг юм. Уг шинжилгээгээр бодлогын үр нөлөөнд өртөж буй бүх хүмүүсийн үр ашиг, алдагдлыг мөнгөн утгаар тооцоолно гэсэн үг юм. Хэрэв нийлбэр нь эерэг бол үр ашиг нь өртгийг даван гарч, бодлогын зохицуулалтын шийдлийн үр ашиг нэмэгдэнэ гэсэн үг юм.

4.2.3. Өртгийн үр ашгийн шинжилгээний төрөл

- Өртөг, үр ашгийн харьцаа
- Нэмэгдэх өртөг, үр ашгийн харьцаа
- Цэвэр одоогийн нэмэгдсэн өртөг
- Буцааж олох ашиг

4.2.4. Үр ашиг, өртгийн харьцаа (ҮӨХ)

Энэ нь төслийн үр ашиг төслийн өртөгтэй эсрэгцэх харьцааг хэлнэ. Төслийн нийт хугацаанд нийт хөнгөлөгдсөн үр ашгийг төслийн нийт хөнгөлөгдсөн өртөгт хуваасан нийлбэрийг хэлнэ.

Зураг 15: Үр ашиг, өртгийн харьцааны томьёо

$$BCR = \frac{[\sum B_i / (1+d)^i]}{[\sum C_i / (1+d)^i]} \text{ summed over } i = 0 \text{ to } n \text{ years}$$

B_i = i жилийн төслийн үр ашиг, $i = 0$ нь n жил хүртэл байхад

C_i = the project's costs in year i жилийн төслийн өртөг, $i = 0$ нь n жил байхад

n = Төслийн хугацаанд үргэлжилсэн нийт жилийн тоо

d = хөнгөлөлтийн хэмжээ

Үр ашиг, өртгийг тооцоолох үе шат. аргыг хэрэглэх:

1. Төслийн жил бүрийн хөнгөлөгдсөн үр ашгийг тодорхойлох
2. Төслийн жил бүрийн хөнгөлөгдсөн өртгийг тооцох
3. Нийт төслийн үргэлжлэх хугацааны нийт хөнгөлөгдсөн үр ашгийн нийлбэрийг олох
4. Нийт төслийн үргэлжлэх хугацааны нийт хөнгөлөгдсөн өртгийн нийлбэрийг олох
5. Нийт хөнгөлөгдсөн үр ашгийг нийт хөнгөлөгдсөн үр ашигт хуваах

Хүснэгт 9: ҮӨХ-ны шинжилгээний үр дүнг тайлж унших

ҮӨХ < 1.0	ҮӨХ = 1.0	ҮӨХ > 1.0
Эдийн засгийн үүднээс өртөг нь үр ашгаас даван гарчээ. Энэ шалгуураар бол төсөл үр өгөөжгүй тул зогсоох ёстой.	Өртөг үр ашигтай тэнцүү байна. Төслийг үргэлжлүүлж болох боловч амьдрах чадвар тааруу байна.	Үр ашиг өртгөөс даван гарсан байна. Төслийг үргэлжлүүлэх ёстой.

4.2.5. Өсөн нэмэгдэх үр ашиг, өртгийн харьцаа

Энэ арга нь төсөл илүү үр ашигтай юу эсхүл бусад төслөөс илүү өртөгтэй гэдгийг тогтооход чиглэдэг. Уг аргыг ашиглан олон хувилбарууд дотроос аль бодлогын шийдэл илүү боломжит хувилбар болохыг тодорхойлоход оршино.

- Өсөн нэмэгдэх үр ашиг, өртгийн харьцааны аргыг дараах үе шатаар хийнэ.
- Хамгийн бага өртгөөс нь хамгийн их өртөгтэй рүү нь жагсаан бичнэ.

Хамгийн бага өртөгтэй төслийг сонгож аваад хоёр дахь хамгийн хямд хувилбарыг төсөл бүрийн нийт хөнгөлөгдсөн үр ашгаас хасаж, мөн төсөл бүрийн нийт хөнгөлөгдсөн өртгийн ялгаагаар гарсан үр дүнг хуваасантай харьцуулна.

Зураг 16: Өсөн нэмэгдэх үр ашиг, өртгийн шинжилгээний томьёо

$$\text{Incremental BCR} = (\sum B_1 - \sum B_2) / (\sum C_1 - \sum C_2)$$

- $\sum B_1$ = төслийн нийт үр ашиг '1'
- $\sum C_1$ = төслийн нийт өртөг '1'

Хэрэв нэмэгдсэн ҮӨХ зорилтод нэмэгдсэн ҮӨХ-өөс их бол, бага өртөгтэй хувилбарыг хаяж (энэ тохиолдолд төсөл 1), их өртөгтэй хувилбарыг үлдээж (төсөл 2) өсөх эрэмбийн жагсаалтын дараагийн төсөлтэй харьцуулна.

Хэрэв нэмэгдэх ҮӨХ зорилтод нэмэгдэх ҮӨХ-өөс бага бол хамгийн их өртөгтэй хувилбарыг хаяж(энэ тохиолдолд төсөл 2), бага өртөгтэй хувилбарыг(төсөл 1) үлдээж өсөх эрэмбийн жагсаалтын дараагийн төсөлтэй харьцуулна.

Бүх төслийн хувилбарт шинжилгээ хийж дуустал энэ үе шатыг(2-4)ийг давтаж хийнэ.

4.2.6. Цэвэр өнөөгийн нэмэгдсэн өртөг (ЦӨНӨ)

Энэ арга нь нийт хөнгөлөгдсөн үр ашгуудын ялгааг нийт хөнгөлөгдсөн өртгөөс хасаж, төслийн Цэвэр Өнөөгийн Нэмэгдсэн Өртгийг олох явдал болно. Эерэг цэвэр үр ашиг амьдрах чадварыг илтгэх ба бага ЦӨНӨ-тэй төсөлтэй харьцуулахад өндөр ЦӨНӨ-тэй төсөл нь зардал багатай байдаг. Өөрөөр хэлбэл ЦӨНӨ нь өндөр байх тусам, төслийн үр ашиг их байна гэж үздэг.

Зураг 17: Цэвэр одоогийн нэмэгдсэн өртөг

$$\text{BCR} = [\sum B_i / (1+d)^i] - [\sum C_i / (1+d)^i] \text{ summed over } i = 0 \text{ to } n \text{ years}$$

- B_i = i жил дэх төслийн үр ашиг, $i = 0$ байхад n жилүүд хүртэл
- C_i = i жилийн төслийн өртөг, $i = 0$ байхад n жилүүд хүртэл

- n = төслийн үргэлжлэх хугацааны нийт жилүүд
- d = хөнгөлөгдсөн хэмжээ

4.2.7. Буцааж олох ашиг

Нийтийн төслийн хөнгөлөгдсөн үр ашиг төслийн нийт хөнгөлөгдсөн өртгийг даван гарахад шаардлагатай хугацааг БУЦААЖ ОЛОХ АШИГ гэнэ. Төслийн дараалсан жил бүрийн төслийн хуримтлагдсан хөнгөлөлттэй үр ашиг, хуримтлагдсан хөнгөлөлттэй өртгийг ашиглан БУЦААЖ ОЛОХ АШГИЙГ эксел дээр хялбархан олж болно. Тухайн жил хуримтлагдсан үр ашиг хуримтлагдсан үр ашгийг давж гарсан тохиолдолд төслийн буцааж ашиг олох хугацаа буюу жил болно. Өөрөөр хэлбэл төслийн буцааж олох ашиг орж ирсэн тухайн жил нь төслийн цэвэр ашиг эсхүл үр өгөөж болно.

Өртгийн үр дүн, өртгийн үр ашгийн талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгаа явуулж өртгийн үр дүн, өртгийн үр ашгийн бүтээл туурвисан гадаадын эрдэмтдийн англи, солонгос хэл дээрх эх сурвалжуудад тулгуурлан эх хэрэглэгдэхүүний судалгаа хийсэн. Манай улсын боловсролын салбарын бодлого, хөтөлбөр, төслүүдийн үр нөлөө үнэн зөв тодорхойлоход хэрэгтэй олон улсын туршлага, загваруудыг сонгож энэхүү товч явцын тайланг бичсэн. Уг тайлан дээр тулгуурлан тус төслийн ирэх оны төлөвлөгөөнд заасны дагуу өртгийн үр дүн, үр ашгийн шинжилгээний гарын авлагыг дэлгэрэнгүй тайлбар, тодорхой жишээ дасгалуудаар баяжуулан бодлогын шинжилгээний салбарын хүмүүст зориулсан хялбаршуулсан гарын авлагыг бичиж гаргахаар төлөвлөсөн болно.

4.3. Дүгнэлт

Өртгийн үр дүн, өртгийн үр ашгийн талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгаа явуулж өртгийн үр дүн, өртгийн үр ашгийн бүтээл туурвисан гадаадын эрдэмтдийн англи, солонгос хэл дээрх эх сурвалжуудад тулгуурлан эх хэрэглэгдэхүүний судалгаа хийсэн. Манай улсын боловсролын салбарын бодлого, хөтөлбөр, төслүүдийн үр нөлөө үнэн зөв тодорхойлоход хэрэгтэй олон улсын туршлага, загваруудыг сонгож энэхүү товч явцын тайланг бичсэн. Уг тайлан дээр тулгуурлан тус төслийн ирэх оны төлөвлөгөөнд заасны дагуу өртгийн үр дүн, үр ашгийн шинжилгээний гарын авлагыг дэлгэрэнгүй тайлбар, тодорхой жишээ дасгалуудаар баяжуулан бодлогын шинжилгээний салбарын хүмүүст зориулсан хялбаршуулсан гарын авлагыг бичиж гаргахаар төлөвлөсөн болно.

4.4. Гарын авлага: Бодлогын шинжилгээ – Боловсролын жишээн дээр

4.4.1. Гарын авлага 1: Зардал үр дүн, зардал үр өгөөжийн шинжилгээ **Хэрэгцээ**

Даяаршсан дэлхийн зах зээл дээр мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэхэд амжилт олсон улс орнууд өөрийн орон зайг тодорхойлж, хөгжиж чадаж байна. Улмаар ашгийн төлөө боловсролын салбарын хөрөнгө оруулалт хурдтай өсөх болжээ. Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын нийгэм, эдийн засгийн зардал, үр дүн, үр ашиг, үр өгөөжийг хэмжих, тогтоох асуудал улам бүр өндөр ач холбогдолтой болсоор байна. Энэ хэрэгцээ, шаардлага дээр үндэслэн энэ гарын авлагыг боловсруулан гаргасан.

Редактор

М. Банзрагч

Зохиогчид

Б.Болормаа, Г.Баттүвшин, Б.Баасандаш, Б.Бат-Өлзий

Хэвлэлийн газар | хуудас

- Содпресс ХХК, Улаанбаатар хот, 2021 он
- Номын хэмжээ: 148x210mm
- Хэвлэлийн хуудас: 6х.х
- Хуудас: 96 хуудас

Агуулга

Уг гарын авлага нь боловсролын салбарын бодлогын шийдвэр гаргах түвшний удирдах ажилтан, бодлого боловсруулагч нар, судлаачид, оюутан залууст зориулан боловсролын салбарын жишээн дээр зардал үр дүн, зардал үр өгөөжийн шинжилгээний аргуудыг хэрхэн хийхийг тайлбарлан танилцуулсан.

- Гарын авлагын нэгдүгээр бүлэг нь боловсролын салбарын төлөвлөгөөнд орсон бодлогын хэрэгжилтийн хүрээнд хийхээр төлөвлөж буй төсөл, хөтөлбөрийн хувилбаруудад зардал үр дүнгийн шинжилгээ хийж, шийдвэр гаргагч нарт бодлогын

зөв сонголт хийх мэдээлэл, нотолгоогоор хангах зардал үр дүнгийн шинжилгээний аргыг танилцуулсан болно.

- Хоёрдугаар бүлэгт боловсролын салбарт хэрэгжүүлэхээр сонгосон төсөл, хөтөлбөр хувилбаруудын анхны хөрөнгө оруулалтыг хэмжээг тодорхойлох, хөрөнгө оруулалтаас эргээд нийгэм, эдийн засагт орж ирэх мөнгөн орлого, урсгалыг тоймлон гаргах, эдийн засгийн үр дүн, үр өгөөжийн талаар үнэлгээ хийн бодлого боловсруулагч нарыг бодлогын шинжилгээний найдвартай мэдээлэл, өгөгдлөөр хангах зардал үр өгөөжийн шинжилгээний аргын талаар тайлбарлан толилууллаа.

Зураг 18: Зардал үр дүн, зардал үр өгөөжийн шинжилгээ



АГУУЛГА	
ОРШИЛ 1	
БҮЛЭГ 1. ЗАРДАЛ ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?	1
Арга зүй	2
Орцын жагсаалт гаргах	4
Алхам 1: Зардлын тооцоо, үнэлгээ хийх арга	8
Алхам 2: Үр дүнгийн шинжилгээ хийх	15
Алхам 3. Зардал-үр дүнгийн шинжилгээ	21
БҮЛЭГ 2. ЗАРДАЛ ҮР ӨГӨӨЖИЙН ШИНЖИЛГЭЭ	26
Зорилго	26
Зардлын хэмжигдэхүүн	28
"Алдагдсан боломжийн өртөг"	28
"Нийгмийн зардал, хувийн зардал"	30
ҮР АШГИЙН ХЭМЖИГДЭХҮҮН	32
Боловсролын түвшин, орлогын хамаарал	32
"Хорогдуулсан мөнгөний урсгал" концепци	34
"Хорогдуулсан мөнгөн урсгал"-ын шинжилгээ гэж юу вэ?	34
ХОРОГДУУЛСАН МӨНГӨН УРСГАЛЫН АРГААР ЗАРДАЛ ҮР ӨГӨӨЖИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ	37
"Хорогдуулсан мөнгөн урсгал"-ын томъёо	37
"Хорогдуулсан мөнгөн урсгал"-ын аргаар орох мөнгөн урсгалыг тооцоолох	38
БОЛОВСРОЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ, ҮР	

4.4.2. Гарын авлага 2:Боловсролын салбарын төсөл, хөтөлбөрт туршилтын болон туршилтын бус аргаар үнэлгээ хийх тоон ба чанарын арга

Хэрэгцээ

Энэхүү гарын авлага нь боловсролын салбарт шийдвэр гаргах, бодлого боловсруулах түвшинд ажилладаг удирдах ажилтан, төрийн албан хаагч, судлаачдын хэрэгцээнд зориулагдсан болно.

Редактор

Проф. Ч.Баасандаш

Зохиогчид

Б.Болормаа, Ч.Должинсүрэн, Б.Бат-Өлзий

Хэвлэлийн газар | хуудас

- Содпресс ХХК, Улаанбаатар хот, 2021 он
- Номын хэмжээ: 148x210mm
- Хэвлэлийн хуудас: 5.5х.х
- Хуудас: 88 хуудас

Агуулга

Түүврийн стратеги, чанарын судалгааны натуралист, эфнографик судалгааны загварууд, туршилтын болон туршилтын бус тоон судалгааны загваруудын тухай хялбаршуулсан, мэдлэгийг энэхүү гарын авлага агуулсан.

- Бүлэг 1: БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН СУДАЛГААНЫ АРГУУД, ТҮҮВРИЙН СТРАТЕГИ
 - Энэ бүлэгт боловсролын бодлогын судалгааны төрлүүд, чанарын ба тоон судалгааны аргуудтай товч байдлаар танилцах боломжтойгоос гадна түүврийн стратегийг дэлгэрэнгүй үзэж, хэрэглэж сурна.
- Бүлэг 2: ЧАНАРЫН СУДАЛГААНЫ НАТУРАЛИСТ, ЭФНОГРАФИК СУДАЛГААНЫ ЗАГВАРУУД
 - Натуралист болон эфнографик судалгааны загварт түшиглэн чанарын аргаар өгөгдөл цуглуулж, шинжилгээ хийх, судалгааны үр дүнг ойлгох, тайлбарлахын

зэрэгцээ ийм төрлийн загвараар хийгдсэн судалгааны ажлын мэдлэг, ололтыг бодлого боловсруулах, бодлогын сонголт хийхэд ашиглах ур чадвар олгоход энэ бүлгийн зорилго оршино.

- Бүлэг 3: ТУРШИЛТЫН БА ТУРШИЛТЫН БУС СУДАЛГАА: ТООН СУДАЛГААНЫ ЗАГВАРУУД
 - Гуравдугаар бүлэгт туршилтын болон туршилтын бус судалгааны загварууд дээр түшиглэн өгөгдөл цуглуулж, шинжилгээ хийх, судалгааны үр дүнг ойлгох, тайлбарлах, энэ төрлийн загвараар хийгдсэн судалгааны ажлын мэдлэг, ололтыг бодлого боловсруулах, бодлогын сонголт хийхэд ашиглах, ур чадварыг сайжруулахад бүлгийн зорилго чиглэсэн.

Зураг 19: Гарын авлагын нүүр хуудас, агуулгын зураг



АГУУЛГА	
ОРШИЛ	5
БҮЛЭГ 1. БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН СУДАЛГААНЫ АРГА, ТҮҮВРИЙН СТРАТЕГИ	7
Боловсролын бодлогын судалгаа гэж юу вэ?	7
Түүвэр	10
БҮЛЭГ 2. ЧАНАРЫН СУДАЛГААНЫ НАТУРАЛИСТ, ЭФНОГРАФИК СУДАЛГААНЫ ЗАГВАРУУД	23
Натуралист судалгаа	23
Эфнографик судалгаа	31
Дотоод соёл, ёс зүйн өнцөг	31
Эфнографик судалгааны арга зүйн зарчим	32
Судалгаа хийх үйл явц	32
БҮЛЭГ 3. ТУРШИЛТЫН БА ТУРШИЛТЫН БУС СУДАЛГАА: ТООН СУДАЛГААНЫ ЗАГВАРУУД	37
Тоон судалгааны төрлүүд	37
Хэрхэн туршилтын судалгааг загварчлах вэ?	38
Судалгааны зорилго, зорилтуудыг тодорхойлох	38
Судалгааны загвар сонгох	40
Т-тест хийх	41
Туршилтын үр дүнд дүн шинжилгээ хийх	45
Бие даасан түүврүүдийн туршилтын арга	46

4.4.3. Гарын авлага 3: Квази туршилтын судалгаа – Боловсролын салбарын жишээн дээр

Хэрэгцээ

Төрийн оролцооны хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг судлахад санамсаргүй түүврийн аргыг хэрэглэх боломжгүй тохиолдол их байдаг. Энэ тохиолдолд квази туршилтын дизайн (quasi-experimental design)-ыг өргөн хэрэглэдэг. Тиймээс квази туршилтын дизайны (quasi-experimental design) тухай гадаад, дотоодын шилдэг эх хэрэглэгдэхүүнийг судалж олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц гарын авлага боловсруулан бичсэн.

Редактор

Проф. Г.Баттүвшин

Зохиогчид

Б.Болормаа, Б.Бат-Өлзий

Хэвлэлийн газар | хуудас

- Содпресс ХХК, Улаанбаатар хот, 2021 он
- Номын хэмжээ: 148x210mm
- Хэвлэлийн хуудас: 7.6х.х
- Хуудас: 124 хуудас

Агуулга

Энэхүү гарын авлагыг дор бичсэн агуулгын хүрээнд бичсэн.

- Квази туршилтын дизайн
- Эковалент бус (non-equivalent) бүлгийн дизайн
- Регрессийн тасралтын дизайн
- Тасалж авсан хугацааны цуваа
- Квази туршилтын судалгаа

Зураг 20: Гарын авлагын нүүр хуудас, агуулгын хуудасны зураг



КВАЗИ ТУРШИЛТЫН СУДАЛГАА

ТАСАЛЖ АВСАН ХУГАЦААНЫ ЦУВАА	66
Энгийн Тасалж авсан хугацааны цуваа	68
Хяналтын бүлэгтэй хугацааны цуваа шинжилгээ	70
Хяналтын бүлэгтэй тасалж авсан хугацааны цуваа шинжилгээ	72
Хяналтын бүлэгтэй хугацааны цуваа шинжилгээний үед хяналтын бүлгийг сонгох.....	76
ДҮГНЭЛТ: КВАЗИ ТУРШИЛТЫН ДИЗАЙНЫ ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛ	83
Давуу тал	83
Сул тал	84
ХАВСРАЛТ 1: ЦАХИМ ХИЧЭЭЛИЙН МАТЕРИАЛ	89
Квази туршилтын дизайны судалгаа	89
ХАВСРАЛТ 2:	119
Критикал утга гэж юу вэ?	119
НОМ ЗҮЙ	121

5. Бодлогын зөвлөмж: Боловсролын бодлогын судалгааны институт байгуулах асуудал

5.1. Хураангуй

Үр дүнтэй, үр нөлөө бүхий боловсролын салбарын бодлогын судалгааны хүрээлэн, үндэсний тогтолцоо бүрдүүлэх асуудлаар төслийн хугацаанд зохион байгуулсан хэлэлцүүлэг, судалгаа, ажиглалтын явцад хуримтлуулсан баримт, мэдээлэл, мэдлэг, туршлага дээр тулгуурлан тойм бодлогын зөвлөмж бэлтгэн хүргэж байна. Улс орон болгон өөр өөрийн түүхэн хөгжил, нийгэм-эдийн засгийн хэрэгцээ, улс төрийн нөхцөл байдалд тохируулан янз бүрийн стратеги, арга зам хэрэглэн үр нөлөө бүхий боловсролын салбарын үндэсний бодлогын судалгааны тогтолцоог хөгжүүлэхийг зорьж ирсэн байдаг. Тиймээс бодлогын судалгааны тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх нэгдсэн нэг арга зүй, менежмент гэж байхгүй. Гэхдээ өндөр хөгжсөн орнуудын боловсролын салбарт амжилттай хэрэгжээд сайн туршлага болчихсон хөгжлийн загвар, стратеги энэ чиглэлээр хангалттай бий болсон байна. Тухайлбал газар зүйн байрлал, соёл уламжлал, түүхэн хөгжлийн ижил төстэй талууд ихтэй БНСУ-ын засгийн газар “Солонгосын боловсролын хөгжлийн институт” гэсэн боловсролын бодлогын судалгааны хүрээлэн байгуулан амжилтад хүрсэн түүх байна. Тиймээс энэхүү бодлогын зөвлөмжийг бичихдээ БНСУ, Сингапур улс, Япон улсын сайн туршлагыг ашигласан.

Бидний ажиглалтаас харвал манай улсад боловсролын бодлогын судалгааны үндэсний тогтолцоог бүрдүүлэх хоёр гол арга зам байна. Энэ нь нэгдүгээрт төрийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг засгийн газрын харьяа бодлогын судалгааны хүрээлэнг байгуулах хэрэгтэй байна. Өнөөгийн Боловсролын хүрээлэнгийн чиглэл, үйл ажиллагааг нийтийн бодлогын шинжилгээний чиг үүрэг, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр шинэчлэн өргөжүүлэх замаар үндэсний бодлогын судалгааны хүрээлэнг байгуулах боломж байна. Хоёрдугаарт боловсролын бодлогын судалгааны үндэсний тогтолцоог иж бүрэн бүрдүүлэхийн тулд төрөөс хараат бус эсхүл хагас хараат бие даасан бодлогын судалгааны байгууллагуудыг бэхжүүлэх, шинээр байгуулагдах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байна. Монгол улсын Засгийн газар энэ асуудалд анхаарлаа хандуулж янз бүрийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нь маш чухал юм.

Энэхүү бодлогын зөвлөмжид дээр дурдсан хоёр арга замыг онцлон авч үзэхийг зориогүй, зөвхөн дурдаад орхихыг л хүссэн юм. Харин энэ бодлогын зөвлөмжөөр эхлээд “Бодлогын судалгааны хүрээлэн – Тинк танк” гэж юуг ойлгох вэ, үр дүнтэй, үр нөлөө бүхий үндэсний боловсролын бодлогын судалгааны тогтолцоог бүрдүүлэх, бодлогын хүрээлэн буюу тинк танкуудыг нэмэгдүүлэхэд ямар урьдчилсан нөхцөлүүд хэрэгтэй байна вэ, энэ чиглэлээр улс орнууд ямар туршлага хуримтлуулсан вэ, манайд ямар туршлагыг нутагшуулах хэрэгтэй вэ, цаашдаа юу хийх хэрэгтэй вэ зэрэг асуудлыг авч үзэх болно.

5.2. Бодлогын судалгааны хүрээлэн буюу “тинк танк”

5.2.1. Товч түүх ба тодорхойлолт

Анхны бодлогын судалгааны төв нь 19-р зууны сүүлчээр Их Британид байгуулагдсан социалист Фабиан нийгэмлэг байсан бөгөөд энэ нь тус улсын төрийн бодлогод нөлөөлөхийг эрмэлздэг байв (Ladi S. , 2015). Бодлогын судалгааны хүрээлэнгүүдийг ихэнх тохиолдолд “Тинк танк(Think Tanks)” гэж нэрлэдэг. “Тинк танк” гэсэн нэр томъёог анх дэлхийн 2-р дайны үед төлөвлөгөө, стратегийн талаар ярилцаж болох аюулгүй газрыг тодорхойлох зорилгоор цэргийн хэллэгээр хэрэглэж байсан боловч 1960-аад оны үед АНУ-д хувийн, ашгийн бус бодлогын судалгааны байгууллагыг ингэж нэрлэх болсноор утга нь өөрчлөгдөж эхэлсэн байна.

Тинк-танкууд нь бодлого боловсруулагчид болон олон нийт төрийн бодлогын асуудлаар мэдээлэлтэй шийдвэр гаргах боломж олгодог дотоод болон олон улсын асуудлаар бодлогын зорилготой судалгаа, дүн шинжилгээ, зөвлөмж гаргадаг төрийн бодлогын судалгаа, шинжилгээ, оролцооны байгууллага юм (LadiStella., 2009).

Сүүлийн жилүүдэд манай оронд төрийн бодлогын асуудлаар бодлого боловсруулагч нар нийгмийн сүлжээний үйл явдал, улс төрийн дарамт, шахалтын нөлөөгөөр баримт, мэдээлэл муутайгаар шийдвэр гаргах тохиолдол нэмэгдэж байна. Энэ асуудал боловсролын салбарын бодлого боловсруулагч нарт хүртэл тохиолддог болохоор боловсролын бодлогын судалгааны үндэсний тогтолцоог хөгжүүлэх хэрэгцээ шаардлага их байна.

5.2.2. Бодлогын судалгааны хүрээлэн буюу тинк танкийн үүрэг

Иж бүрэн үндэсний бодлогын судалгааны үндэсний тогтолцоог хөгжүүлэх ажил нь бодлогын судалгааны хүрээлэн, тинк танкуудын үүргийг тодорхойлохоос эхэлдэг. Олон улсын нийтлэг хөгжлийн хандлагыг харахад манай улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, шинээр байгуулагдах боловсролын салбарын бодлогын судалгааны хүрээлэн буюу тинк танкууд гол гурван үүргийг хүлээдэг байх нь зүйтэй (Sammut Jeremy, 2016; Namre, John. 2008). Энэ нь нэгдүгээрт бодлогын мэдээлэл, боловсролын үйлчилгээ үзүүлэх, хоёрдугаарт төрийн бодлогын сонголт хийх, шийдвэр гаргах шинжлэх ухаанч хэм хэмжээг тогтоох, гуравдугаарт төрийн бодлогод нөлөөлөх үүргийг хүлээнэ.


Зураг 21: Бодлогын институцийн үүрэг ба үр нөлөө



5.2.3. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Гол гурван үүргийн үйл ажиллагааны хүрээнд боловсролын бодлогын судалгааны хүрээлэн буюу тинк танкууд хэрэгжүүлэх ёстой таван үйл ажиллагаа байна. Үүнд нэгдүгээрт төрийн бодлогын асуудлуудын талаарх мэдлэг, мэдээллийг сайжруулах, хоёрдугаарт баримтаар баталгаажсан бодлогын шийдлийг олж тогтоох, гуравдугаарт бодлого боловсруулагч, олон нийт, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийг мэдээллээр хангах, дөрөвдүгээрт төрийн бодлогын асуудлаар олон нийтийн хэлэлцүүлгийг өрнүүлэх, тавдугаарт төрийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаа орно (Singh, R., Sharma, N. N., & Jha, U., 2014).

Зураг 22: Бодлогын судалгааны хүрээлэн буюу тинк танк хэрэгжүүлэх таван үйл ажиллагаа



5.2.4. Бодлогын судалгааны хүрээлэнгийн ангилал

Хоёр гол шинж чанарт тулгуурлан бодлогын судалгааны тинк танкуудын ангиллыг хийдэг. “Стратеги” болон “санхүүжилтийн эх сурвалж” гэсэн хоёр шинж чанарт тулгуурлан бодлогын судалгааны хүрээлэн буюу тинк танкийг 7 төрөл болгон ангилна. Үүнд (1) бие даасан болон хараат бус, (2) хагас бие даасан, (3) их сургуулийн харьяа, (4) улс төрийн намын харьяа, (5) засгийн газрын харьяа, (6) хагас засгийн газрын болон (7) ашгийн төлөө гэсэн ангилал орно. Манай орны хувьд энэ долоон төрлийн бодлогын судалгааны хүрээлэн буюу тинк танкийн бүх төрлийг хөгжүүлэх бодлого баримтлан ажиллах нь зүйтэй юм (Markus Mykkänen, Neil Freshwater, 2021). Учир нь бүх төрлийн бодлогын судалгааны тинк танкууд үйл ажиллагаа явуулах тохиолдолд боловсролын салбарын иж бүрэн үндэсний бодлогын тогтолцоо бүрдэх боломж бий болно (Abelson, 2019).

Хүснэгт 10: Бодлогын судалгааны тинк танкийн ангилал ба жишээ

№	Тинк танкийн ангилал	Тайлбар	Жишээ
1.	Бие даасан, хараат бус тинк танк	Нэг хандивлагч болон эх орныхоо засгийн газраас хараат бус тинк танкийг хэлнэ	АНУ-ын Петерсоны олон улсын эдийн засгийн хүрээлэн
2.	Хагас бие даасан тинк танк	Засгийн газраас хараат бус боловч сонирхлын бүлэг, хандивлагч эсвэл гэрээт байгууллага санхүүжилтийн дийлэнх хувийг бүрдүүлдэг, үйл ажиллагаанд нөлөөлдөг тинк танк (Landry, J, 2021)	Америкийн өндөр насны тэтгэвэрт гарсан хүмүүсийн нийгэмлэгийн судалгааны салбар
3.	Их сургуулийн харьяа тинк танк	Дээд боловсролын сургалтын байгууллагын бүтэц, удирдлагын дор байрлах бодлогын судалгааны хүрээлэн.	Стэнфордын их сургуулийн харьяа Хүүвер институт
4.	Улс төрийн намын харьяа тинк танк	Улс төрийн намтай ил тод, албан ёсны холбоотой тинк танк	Фридрих Эбертийн сан

№	Тинк танкийн ангилал	Тайлбар	Жишээ
5.	Засгийн газрын харьяа тинк танк	Засгийн газрын албан ёсны бүтцийн нэг хэсэг тул засгийн газрын эрх мэдлийн дор ажилладаг	Солонгосын боловсролын хөгжлийн институт
6.	Хагас засгийн газрын харьяа тинк танк	Зөвхөн засгийн газрын буцалтгүй тусламж, гэрээгээр санхүүждэг боловч засгийн газрын албан ёсны бүтцэд хамаарахгүй.	АНУ дахь Вудро Вилсоны нэрэмжит олон улсын эрдэмтдийн төв, Солонгосын хөгжлийн хүрээлэн
7.	Ашгийн төлөө тинк танк	Бизнесийн загвар дээр суурилан байгуулагдсан, ашгийн төлөө зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компанийн шинж чанарыг агуулсан тинк танк	Микенси глобал институт

5.2.5. Тинк танкийн бүтэц зохион байгуулалт

Шинэ зууны сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд өмнөх үеийн тинк танкуудаас нэлээн ялгаатай үйл ажиллагааны загвар, ажилтан авах хэв маяг, судалгааны зорилготой тинк танкийн зохион байгуулалтын өвөрмөц хэлбэрүүд бий болсон байна. Судлаачид зохион байгуулалтын хэлбэрийг харгалзан үзэж бодлогын судалгааны тинк танкуудыг академик, гэрээт судалгаа, нөлөөллийн гэсэн гурван ерөнхий ангилалд хуваадаг.

Академик тинк танкууд өндөр ур чадвартай судалгааны гишүүдийг элсүүлэн үйл ажиллагаа явуулдаг. Энэ хэлбэрийн зохион байгуулалттай тинк танкууд асуудлын өргөн цар хүрээнд судалгаа хийж, бодлогын чиглэлд урт хугацааны өөрчлөлтийг бий болгох зорилтыг тавин ажилладаг.

Гэрээт судалгааны тинк танкууд нь гэрээт судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх үйл ажиллагаа явуулдаг. Ихэнх тохиолдолд төрийн байгууллагууд энэ хэлбэрийн тинк танкуудтай гэрээ байгуулан, санхүүжүүлж, судалгааны ажил гүйцэтгүүлэх зэргээр хамтран ажилладаг. Эдгээр хэлбэрийн тинк танкууд нь гэрээ хийсэн захиалагч байгууллагын ажлыг сайжруулахад хэрэгтэй бодлогын зөвлөмжийг бэлтгэн хүргэдэг. Харин төрийн байгууллагууд гол санхүүжүүлэгч гэдэг үүднээсээ гэрээт тинк танкуудын зорилго, үйл ажиллагаанд үлэмж ихээр нөлөөлдөг.

Нөлөөллийн судалгааны тинк танкууд хоёр гол чиглэлийн аль нэгийг сонгон үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь нэгдүгээрт тодорхой нэг хүчирхэг үзэл суртлыг сурталчлан ажиллах эсвэл хоёрдугаарт тодорхой нэг бодлогын сэдвээр олон нийтийн санаа бодолд нөлөөлөх,

бодлого боловсруулагчдын бодлогыг өөрчлөх үйл ажиллагаа орно. Нөлөөллийн судалгааны тинк танкууд албан ёсны хараат байдлаа хадгалахын зэрэгцээ тодорхой үзэл суртлын бүлэглэл, ашиг сонирхлын бүлэгтэй хамтран ажилладаг. Энэ хэлбэрийн судалгааны тинк танкууд бодлого боловсруулах үйл явцад гүйцэтгэх өөрсдийн үүргээ үзэл бодлын дайнд ялах асуудал гэж үздэг. Нөлөөллийн судалгааны тинк танкууд өөрийн хүний нөөцөө их сургуулийн багш нараас илүүтэйгээр засгийн газар, улс төрийн нам, сонирхлын бүлгээс сонгодог бөгөөд нийгмийн шинжлэх ухааны мэдлэг, ур чадварын харьцангуй бага байх магадлалтай байдаг (Abelson, 2018).

Хүснэгт 11: Тинк танкийн зохион байгуулалтын хэлбэрүүд

Тинк танкийн хэлбэр	Гол шинж чанар ба бүтээгдэхүүн				
	Хүний нөөц	Санхүүжилт	Зорилгыг тогтоох	Бүтээгдэхүүн, түүний хэв маяг	Дэмжих нөхцөл
Академик тинк танк	Үзэл суртлаас ангид мэргэжлийн өндөр ур чадвартай ажилтанд тулгуурладаг.	Сан, хувь хүн, корпорац	Судлаачид, сан зорилгыг тодорхойлдог	Үзэл суртал ороогүй нэг сэдэвт бүтээл, өгүүлэл, сэтгүүл	Үзэл суртал ороогүй соёл, сайн үйлсийн аян
Гэрээт судалгааны тинк танк	Үзэл суртлаас ангид мэргэжлийн өндөр ур чадвартай ажилтанд тулгуурладаг.	Засгийн газрын байгууллага	Гэрээлэгч байгууллага тодорхойлдог	Үзэл суртал ороогүй засгийн газарт хүлээлгэн өгсөн тайлан	Бодлогын судалгааны засгийн газрын дэмжлэг
Нөлөөллийн судалгааны тинк танк	Улс төр, философи, үзэл суртлын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн ажилтанд тулгуурладаг	Сан, хувь хүн, корпорац	Байгууллагын удирдлага тогтоодог	Тодорхой сэдвийг хамарсан товч өгүүлэл	Сан, бизнесийн байгууллага, сонирхлын бүлгийн дэмжлэг
Намын тинк танк	Намын гишүүд, намд үнэнч хүмүүст тулгуурладаг	Улс төрийн нам, засгийн газрын татаас	Улс төрийн намын үзэл сурталтай уялдуулан тогтоодог	Олон төрлийн бүтээгдэхүүн	Улс төрийн намын, судалгааны, засгийн газрын дэмжлэг

5.2.6. Бодлогын судалгааны тинк танк байгууллагуудын санхүүжилт

Бодлогын судалгааны тинк танкуудын санхүүжилтийн эх үүсвэр ангилал, хэлбэрээсээ хамааран олон төрөл байдаг. Роберт Брукингс, Эндрю Карнеги зэрэг буяны үйл хийдэг

хүмүүсийн өгөөмөр санхүүжилт бодлогын судалгааны тинк танкууд бий болоход чухал үүрэг гүйцэтгэсэн. Олон улсын туршлагаас харахад бодлогын судалгааны тинк танк байгууллагын санхүүжилтийн эх үүсвэрийн дөрвөн төрөл байна. Үүнд нэгдүгээрт хандивын сангийн санхүүжилтээр, хоёрдугаарт сэтгүүл, судалгааны бүтээгдэхүүний борлуулалтын орлогоор, гуравдугаарт төрийн байгууллагын захиалга, гэрээт ажлын санхүүжилтээр, дөрөвдүгээрт толгой байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр гэсэн дөрвөн төрөл байдаг.

Орчин цагт санхүүжилтийн эх үүсвэрийг олон талт болгох нь бодлогын судалгааны тинк танк байгууллагуудын тэргүүлэх зорилтын нэг болжээ. Учир нь санхүүжилтийн эх үүсвэр олон болох тусам бодлогын судалгааны тинк танк байгууллагын хараат бус байдал нэмэгддэг. Санхүүжилтийн 60-80 хувь нь олон тооны хувь хүмүүсийн хандиваас бүрдсэн бодлогын судалгааны тинк танкийн хараат бус байдал баталгаатай болдог. Тэр байтугай засгийн газрын гэрээт захиалга, санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг бодлогын судалгааны тинк танк байгууллагууд хүртэл санхүүжилтийн эх сурвалжаа олон талт болгох тал дээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг болжээ (McLevey, 2014).

5.3. Бодлогын санал, зөвлөмж

Боловсролын бодлогын судалгааны хүрээлэн, үндэсний тогтолцоо бий болгоход өмнөх бүлэгт дурдсан олон улсын сайн туршлага, хөгжлийн загвар, стратегийн мэдлэгийг суралцан нутагшуулахаас гадна дараах асуудлуудад анхаарч ажиллах хэрэгтэй байна. Үүнд:

5.3.1. Боловсролын хүрээлэн” дээр суурилан бодлогын судалгааны хүрээлэнг байгуулах

Нэн тэргүүнд БШУЯ-ны зүгээс манлайлал үзүүлэн засгийн газрын харьяа үндэсний бодлогын судалгааны хүрээлэнг байгуулах хэрэгтэй байна. Энэ зорилтыг биелүүлэхдээ өнөөгийн Боловсролын хүрээлэнгийн чиглэл, үйл ажиллагааг нийтийн бодлогын шинжилгээний чиг үүрэг, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр шинэчлэн өргөжүүлэх арга замаар үндэсний бодлогын судалгааны институтийг байгуулах нь зардал багатай, илүү үр дүнтэй шийдэл юм. Боловсролын хүрээлэн дээр түшиглэн засгийн газрын боловсролын бодлогын судалгааны хүрээлэнг байгуулахад дөрвөн гол асуудлыг анхаарч ажиллах хэрэгтэй. Үүнд нэгдүгээрт бүтэц зохион байгуулалт, хоёрдугаарт үйл ажиллагааны чиглэл, гуравдугаарт хүний нөөцийн бодлого, дөрөвдүгээрт ажлын орчны менежмент гэсэн таван асуудал орно.

Бүтэц зохион байгуулалт

Засгийн газрын харьяа үндэсний бодлогын судалгааны хүрээлэнгийн бүтэц зохион байгуулалтыг боловсруулахад дараах зарчмуудыг баримтлах хэрэгтэй. Үүнд:

- Бүтэц зохион байгуулалтын нэн тэргүүний зорилго нь хүрээлэнгийн ажлыг хөнгөвчлөх, саад бэрхшээлийг бууруулах асуудал байх ёстой,
- Байгууллагын үүрэг, хариуцлагын хоорондын хамаарлыг илэрхийлдэг албан ёсны хэрэгсэл байх ёстой,
- Ажлын байранд ажилтны хариуцах ажлыг албан ёсоор тодорхой зааж өгөх ёстой.

Боловсролын бодлогын судалгааны олон улсын сайн туршлага, Боловсролын хүрээлэнгийн өнөөгийн бүтцийг судалж үзэхэд үндэсний бодлогын судалгааны хүрээлэнгийн бүтэц зохион байгуулалтыг хийж болох юм. Нэн ялангуяа манай орны хувьд анхаарал бага хандуулж ирсэн ирээдүй, иргэний боловсролын судалгааны салбар, мөн боловсролын өгөгдөл, санхүү, орчин, дэд бүтцийн судалгааны салбарын бүтэц зохион байгуулалтын дотор оруулж, хөгжүүлэх бодлого баримтлан ажиллах нь зүйтэй юм.

Зураг 23: Жишиг бүтэц зохион байгуулалтын хувилбар



Үйл ажиллагааны чиглэл

Засгийн газрын харьяа бодлогын судалгааны хүрээлэн үндэсний хэмжээний төрийн өмчийн судалгааны хүрээлэн гэдэг талаасаа гурван гол чиглэлээр үйл ажиллагаа явуулбал зохистой юм. Нэгдүгээрт бодлогын орчны шинжилгээг тасралтгүй явуулах ёстой. Нэн ялангуяа төрийн боловсролын бодлогын орчинд гарч ирсэн зайлшгүй шийдэх тулгамдсан асуудлуудыг олж тогтоох үйл ажиллагаа үүнд орно. Энэ үйл ажиллагааг биелүүлэхдээ бодлогын судалгааны байгууллага асуудал ба зорилтын модны шинжилгээ, оролцогч талуудын шинжилгээ, хүчний талбарын шинжилгээ, нөлөөллийн зураглал, SWOT шинжилгээ, гурвалжны шинжилгээ гэх мэт олон төрлийн хэрэгслийг хэрэглэдэг байх нь зүйтэй юм. Хоёрдугаарт боловсролын салбарын төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, нотолгоо цуглуулах, сайжруулах санал зөвлөмж боловсруулах үнэлгээний судалгаа, үйл ажиллагааны судалгаа явуулах үйлчилгээ үзүүлэх үүрэг орно. Гуравдугаарт бодлогын судалгаагаар дамжуулан олон нийтийн хэрэгцээг тогтоож судалгааны үр дүнг мэдээлэх замаар хууль тогтоох, бодлого боловсруулах төрийн байгууллагуудын анхаарлыг уг хэрэгцээнд хандуулж төрийн бодлогод нөлөөлөх үйл ажиллагаа явуулна.

Зураг 24: Гурван гол үйл ажиллагааны чиглэл




Хүний нөөцийн бодлого

Бодлогын судалгааны хүрээлэнгийн амжилтыг тодорхойлдог хамгийн гол хүчин зүйл нь хүний нөөцийн мэдлэг, ур чадвар, хандлага юм. Тиймээс өнөөгийн Боловсролын хүрээлэнгийн үндэс суурин дээр тулгуурлан үндэсний бодлогын судалгааны хүрээлэнг байгуулахад хүний нөөцийн талаар дараах гурван бодлогыг явуулах хэрэгтэй. Үүнд нэгдүгээрт өнөөгийн хүний нөөцийн нийтийн бодлогын шинжилгээний мэдлэг, ур чадварыг сайжруулах, хоёрдугаарт шилдэг хүний нөөцийг татах өрсөлдөхүйц цалин, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх, гуравдугаарт ажлын гүйцэтгэлийн шударга, оновчтой үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх бодлого орох ёстой.

Хүний нөөцийг чадавхжуулах сургалт

Өнөөгийн Боловсролын хүрээлэнгийн хүний нөөцийн нийтийн бодлогын шинжилгээ хийх мэдлэг, ур чадварыг сайжруулах цуврал сургалтыг тогтмол явуулах хэрэгтэй. Энэ зорилгыг биелүүлэхэд манай төслийн хүрээнд бэлтгэж, боловсруулж, хэвлэн гаргасан гурван гарын авлага, цахим хичээлийг ашиглаж болно.

Зураг 25: Чадавхжуулах сургаалтанд зориулсан гурван гарын авлага



Шилдэг хүний нөөцийг татах өрсөлдөхүйц цалин

Үндэсний бодлогын судалгааны хүрээлэнг байгуулахад хүний нөөцийн бодлогын хүрээнд шийдэх ёстой хоёр дахь асуудал нь өндөр мэдлэг, ур чадвартай шилдэг судлаачдыг татах,

тогтвор суурьшилтай ажиллуулах өрсөлдөхүйц цалин юм. Манай орны хувьд хамгийн багадаа төрийн өмчийн их сургуулийн багш нарын түвшинд засгийн газрын харьяа бодлогын судалгааны хүрээлэнд ажиллах судлаачдын цалинг хүргэх шаардлага байна. МУИС болон ШУТИС-ийн жишгээр бол цалинг ₮2,000,000-₮2,500,00 хүргэх хэрэгтэй. Боллоцотой бол цалингийн доод хэмжээг ₮2,500,00-₮3,000,00 хүртэл хэмжээнд хүргэж чадвал шилдэг хүний нөөцийг татах өрсөлдөөний давуу талтай болж чадна.

Гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоо

Судалгааны ажилчдын бүтээмжийг нэмэгдүүлэх асуудал нь хүний нөөцийн бодлогын гурав дахь гол зорилго байдаг. Бодлогын судлаачийн амжилтыг үнэлэх, хүлээн зөвшөөрөх үр ашигтай, үр дүнтэй бодлого нь шилдэг судлаачдын бүтээмжийг нэмэгдүүлэх хамгийн үр дүнтэй аргуудын нэг юм. Үндэсний бодлогын судалгааны хүрээлэнг байгуулсан тохиолдолд судалгааны бүтээмжийг нь дээшлүүлэхийн тулд дор бичсэн сайн гүйцэтгэлийг дэмжих, урамшуулах бодлогуудыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй юм.

- Судалгааны үр дүн болсон өгүүллийг судлаач өөрийн нэр дээр хэвлүүлэх зөвшөөрөл өгдөг байх,
- Бодлого боловсруулагч нартай хэлэлцүүлэг хийх, уулзах боломжийг олгодог арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг байх,
- Судлаачдыг дэмжих олон төрлийн шагнал урамшуулалтай байх,
- Судалгааны өгүүлэл, ном бичих цаг хугацааны боломж олгодог байх,
- Олон улсын хуралд оролцох томилолтын зардал олгодог байх,
- Нэмэлт цалин урамшуулал олгодог байх.

Ажлын орчны менежмент

Ажлын байрны нөхцөл бол байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэх, ажиллах урам зоригийг ажилчдад өгдөг хамгийн гол хүчин зүйлсийн нэг юм. Тиймээс үндэсний бодлогын судалгааны хүрээлэнг байгуулсан тохиолдолд бодлогын шинжээчид бүтээлчээр ажиллах, нийгмийн үр нөлөө ихтэй бодлогын судалгаа явуулах нөхцөлийг хангаж өгөхийн тулд дор бичсэн ажлын орчныг бүрдүүлж өгөх хэрэгтэй юм.

- Хүчин чадал сайтай ширээний болон зөөврийн компьютер
- Хурдтай интернэт сүлжээ
- Олон улсын шилдэг шинжлэх ухааны сэтгүүлүүдийн санг ашиглах эрх
- Олон нийттэй харилцах туслах ажилтны дэмжлэг, тусалцаа
- Шинжилгээ хийх чимээгүй орчныг бүрдүүлсэн хувь судлаачид зориулсан судалгааны өрөө
- Хамтын хэлэлцүүлэг, хурлын танхим гэх мэт

Засгийн газрын харьяа бус бодлогын судалгааны тинк танк байгуулагдах, хөгжих санаачилгуудыг дэмжих

Боловсролын бодлогын судалгааны үндэсний тогтолцоо бүрдүүлэхийн тулд засгийн газрын бодлогын судалгааны хүрээлэнг байгуулахаас гадна засгийн газрын харьяа бус бодлогын судалгааны тинк танк байгуулагдах, хөгжих санаачилгуудыг дэмжих хэрэгтэй юм. Манай оронд өмчийн олон хэлбэрийн бодлогын судалгааны байгууллагуудыг байгуулах, байгуулагдах нөхцөлийг бүрдүүлж болох юм. Манай энэ удаагийн төслийн ажлын судалгаанаас харахад эхний ээлжид засгийн газрын харьяа бус өмчийн гурван хэлбэрийн тинк танк байгуулах, байгуулагдах нөхцөлийг бүрдүүлэх боломж байна.

Нэгдүгээрт Монголын төрийн өмчийн их дээд сургуулийн хүний нөөц, материаллаг бааз дээр тулгуурлан их сургуулийн харьяа боловсролын бодлогын судалгааны тинк танк төвүүдийг байгуулж болно. Жишээ нь ШУТИС дээр Дээд боловсрол, дижитал боловсролын бодлогын судалгааны тинк танк төвийг байгуулах бүрэн бололцоо байна.

Хоёрдугаарт төрийн санхүүжилттэй төсөл, хөтөлбөрт оролцох боломжийг бүрдүүлэх замаар хувийн хэвшлийн сургууль эсхүл хувийн хэвшлийн байгууллага дээр ашгийн төлөө бодлогын судалгааны тинк танк төвүүд байгуулагдах санаачилгыг дэмжих бодлогыг БШУЯ-ны зүгээс хэрэгжүүлэх хэрэгтэй.

Харин гуравдугаарт дэлхийн олон орны жишгээр улс төрийн боловсрол, хөгжлийн бодлогын чиглэлээр судалгаа, сургалтын үйл ажиллагаа бодлогын судалгааны тинк танкуудыг улс төрийн намын харьяанд байгуулж болно. Тухайлбал манай Монгол улсад

болон дэлхийн олон оронд үйл ажиллагаа явуулдаг ХБНГУ-ын Конрад Эднаурын сан, Фредерик Эбертийн сан гэх мэт улс төрийн бодлогын судалгаа, боловсролын байгууллагууд бүгд Германы улс төрийн намын харьяа тинк танкууд юм. Төрийн санхүүжилтээр улс төрийн боловсрол болон бодлогын судалгааны үйл ажиллагаа явуулдаг ийм төрлийн тинк танкуудыг манай улсад байгуулах хэрэгтэй юм. Учир нь ардчилсан ёсыг бэхжүүлэх, сонгогч нарын улс төрийн боловсролыг сайжруулахад улс төрийн намын харьяа улс төрийн болон иргэний боловсролын бодлогын судалгааны тинк танкуудыг УИХ-д суудалтай улс төрийн намуудын дэргэд байгуулах хэрэгцээ их байна. Гэхдээ ийм улс төрийн намын харьяа тинк танкуудыг байгуулахын тулд манай улсын улс төрийн намын тухай хууль, улс төрийн намын санхүүжилтийн эрх зүйн орчныг шинэчлэх шаардлага байна. Өнөөгийн улс төрийн намын тухай хууль, түүний санхүүжилтийн тухай хууль эрх зүйн орчинд улс төрийн намын харьяа бодлогын судалгааны тинк танкууд байгуулагдах нөхцөл бүрдээгүй байна.

Энэ мэтчилэн системтэйгээр нийгмийн янз бүрийн тоглогч нарын онцлог, давуу талууд дээр тулгуурлан олон төрлийн бодлогын судалгааны тинк танкууд байгуулах, байгуулагдах эрх зүй, санхүүжилтийн орчныг бүрдүүлж өгөх нь зүйтэй юм.

Зураг 26: Үндэсний бодлогын судалгааны тогтолцоог байгуулах хугацааны зураглалын санал



5.4. Дүгнэлт

Үндэсний боловсролын бодлогын судалгааны тогтолцоог хөгжүүлэх хэрэгцээ, түүний эко орчныг бүрдүүлэхэд юунд анхаарч ажиллах ёстойг дурдсан манай төслийн багийн бичсэн энэхүү бодлогын санал, зөвлөмжийг тоймлон дүгнэвэл гурван гол асуудлыг онцгойлон анхаарах хэрэгтэй байна.

Нэгдүгээр асуудал нь Монгол улсын боловсролын салбарын засаглал болон бодлогыг боловсронгуй болгох, түүний үр дүн, үр өгөөжийг сайжруулахад үндэсний боловсролын бодлогын судалгааны тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага байна.

Хоёрдугаарт дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг хангах үүргийг биелүүлэхэд нэн тэргүүний ээлжид өнөөгийн Боловсролын хүрээлэнгийн хүний нөөц, туршлага, материаллаг бааз дээр тулгуурлан Монголын улсын БШУЯ манлайлан засгийн газрын харьяа Үндэсний боловсролын бодлогын судалгааны хүрээлэнг байгуулах хэрэгтэй байна.

Гуравдугаарт засгийн газрын харьяа боловсролын бодлогын судалгааны хүрээлэн дангаараа үндэсний боловсролын бодлогын судалгааны тогтолцооны эко орчныг бүрдүүлэх боломжгүй юм. Тиймээс үндэсний боловсролын бодлогын судалгааны тогтолцооны эко орчныг бүрдүүлэхэд БШУЯ их сургууль, төрийн бус байгууллага, улс төрийн нам, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгтэй байна.

6. Хэлэлцүүлэг болон түгээн дэлгэрүүлэх сургалт

6.1. “Боловсрол ба бодлогын судалгааны институц: Олон улсын туршлага” хэлэлцүүлэг

Удирдамж

“Боловсролын салбар ба бодлогын судалгааны институц: Олон улсын туршлага” сэдэвт хэлэлцүүлэг нь боловсролын салбарын бодлогын судалгааны хүрээлэн, тинк танк, үндэсний тогтолцоо бий болгох хэрэгцээ, олон улсын шилдэг туршлагыг танилцуулах, салбарын экспертүүд, мэргэжлийн хүмүүс, эрдэмтэн судлаачдын санал, шүүмжийг цуглуулах зорилготой.

Хэзээ, хаана

- Хэзээ: 2019.12.25
- Хаана: ММС Поларис ХХК, Хурлын заал, Улаанбаатар хот

Зохион байгуулагч

- Хүний хөгжил, сургалт судалгааны төв
- ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургууль

Хамрах хүрээ

Засгийн газар, БШУСЯ, боловсролын байгууллагуудын төлөөлөл, бодлогын судалгааны ахисан түвшний судлаач, шинжээч, боловсролын удирдлагын салбарын оюутан залуус

Уригдсан хүмүүс

- С. Мөнхбат, БСШУСЯ-ны Шинжлэх ухаан, технологийн бодлогын газрын дарга; А. Цолмон, БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн; Д. Баяр, БСШУСЯ-ны Дээд боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн; Лхагвасүрэн, Боловсролын Хүрээлэнгийн захирал; Тунгалаг, ШУТ сангийн захирал; Д. Ганбат, ШУТИС-ийн Нээлттэй боловсролын төвийн захирал; Б. Ганбат, Хөдөө аж ахуйн их сургуулийн Инновацын зөвлөх; Б. Арвинбаяр, Азийн хөгжлийн банкны “Судалгааны их сургууль” төслийн зөвлөх; Г. Цэрэнжаргал, Хүний хөгжил судалгаа, сургалтын төвийн захирал; Г. Батзориг, Боловсрол судлаач; Ч. Лодойравсал, МУИС; Н. Алтанзул, Олон улсын дээд боловсрол судлалын судлаач; Б. Энхчимэг, ШУТИС-ийн КООСЭН сургуулийн

багш, Олон улсын дээд боловсрол судлалын судлаач; Ц. Мөнхмандах, Боловсрол судлаач; Г. Алтаншагай, Насан туршийн боловсрол судлаач, багш, Я. Байгалмаа, Нийгмийн хамгааллын бодлогын судлаач гэх мэт


Семинарын үр дүн

Семинарт оролцогч нарын бодлогын судалгааны тогтолцоо, тинк танк байгууллагуудын үүрэг, хэлбэр, үр нөлөөний тухай мэдлэг, ойлголт сайжирна. Үүнд:

- Боловсролын салбарын бодлогын судалгааны институцийг хөгжүүлсэн олон улсын туршлага,
- Олон улсын шилдэг туршлагыг Монгол улсад нутагшуулах боломжууд,
- Бодлогын судалгааны хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага
- Бодлогын судлаачдыг бэлтгэх ахисан түвшний хөтөлбөр, түүний хэрэгцээ ба шаардлага,
- Бодлогын судалгааны дэд бүтцийн талаарх олон нийтийн санаа бодол, хэрэгцээг ойлгож мэдэх, тодорхойлох.

Хэлэлцүүлгийн агуулга

- Боловсролын салбарын бодлогын судалгааны институцийг хөгжүүлсэн олон улсын туршлага: Монгол улсад нутагшуулах боломжууд
- Бодлогын судалгааны хүний нөөцийн асуудал ба тусгай ахисан түвшний сургууль
- Хэлэлцүүлэг: Засгийн газар, БСШУСЯ, Боловсролын байгууллагуудын төлөөлөл, судлаачид



“Монгол Улсын боловсролын бодлого, хөтөлбөрийн үр дүнг дээшлүүлэх арга, бодлогын судалгааны дэд бүтцийг хөгжүүлэх загвар боловсруулах” захиалгат төсөл

Цаг	Илтгэл	Хариуцагч
14:00-14:10	Нээлт	Доктор, дэд проф. Г. Баттүвшин төслийн удирдагч, ШУТИС-ийн БАТС-ийн Захирал
14:10-14:30	Боловсролын салбарын бодлогын судалгааны институцийг хөгжүүлсэн олон улсын туршлага: Монгол улсад нутагшуулах боломжууд	Доктор. Т. Ууганбаяр ШУТИС-ийн БАТС-ийн дэд профессор, зочин судлаач
14:30-14:50	Бодлогын судалгааны хүний нөөцийн асуудал ба тусгай ахисан түвшний сургууль	Доктор. Б. Болормаа ШУТИС-БухС-ийн ахлах багш, төслийн багийн гишүүн
14:50-15:05	Цайны завсарлага	
15:05-16:00	ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: Засгийн газар, БСШУСЯ, Боловсролын байгууллагуудын төлөөлөл, судлаачид	Доктор, дэд проф. Г. Баттүвшин Доктор Ч. Баасандаш, Доктор Банзрагч

Зураг 27: Хэлэлцүүлгийн зураг



6.2. Боловсролын бодлогын шинжилгээ | семинар – 2021

Удирдамж

“Боловсролын салбарын бодлогын шинжилгээний аргууд” сэдэвт түгээн дэлгэрүүлэх семинар нь боловсролын салбарын бодлогын шинжилгээ хийх тоон судалгааны сүүлийн үеийн мэдлэг, ур чадварыг оролцогч нарт олгох, улмаар цаашид хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх зорилготой.

Зохион байгуулагч

- Хүний хөгжил, сургалт судалгааны төв
- ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургууль

Хэзээ, хаана

Боловсролын бодлогын шинжилгээ сэдэвт түгээн дэлгэрүүлэх сургалт семинарыг нийт 4 удаа зохион байгуулсан. Үүнээс Улаанбаатар хотод цахимаар нэг, танхимаар нэг нийт 2 удаа зохион байгуулсан. Харин орон нутагт 2 удаа танхимаар сургалт зохион байгуулсан. Увс, Орхон аймагт тус бүр нэг удаа зохион байгуулсан. Бүх сургалтыг ижил агуулга, семинараар зохион байгуулсан.

Хүснэгт 12: Боловсролын бодлогын шинжилгээ сэдэвт түгээн дэлгэрүүлэх сургалт семинарын мэдээлэл

№	Семинарын сэдэв	Газар	Хугацаа
1	Боловсролын бодлогын шинжилгээ	Улаанбаатар цахим <ul style="list-style-type: none">○ Линк: https://zoom.us/j/99093553966?pwd=cjhlaWJTQXI3czF4bFh1bWJnSDUrQT09○ Уулзалтын код: 990 9355 3966○ Нууц үг: 174929	2021 оны 5-р сарын 13-аас 14-ний өдөр
2	Боловсролын бодлогын шинжилгээ	Улаанбаатар танхим <ul style="list-style-type: none">○ ММС Поларис ХХК, Хурлын заал	2021 оны 6-р сарын 21-ны өдөр
3	Боловсролын бодлогын шинжилгээ	Увс танхим <ul style="list-style-type: none">○	2021 оны 7-р сарын 31-ны өдөр
4	Боловсролын бодлогын шинжилгээ	Орхон танхим <ul style="list-style-type: none">○	2021 оны 11-р сарын 22-ны өдөр

Хамрах хүрээ

Бодлогын судалгааны ахисан түвшний судлаач, шинжээч, боловсролын удирдлагын салбарын оюутан залуус

Семинарын үр дүн

Семинарт оролцогч нарын бодлогын шинжилгээ хийх дараах мэдлэг, ур чадвар сайжирна.


- Зардал үр дүн, зардал үр өгөөжийн шинжилгээ хийх мэдлэг ур чадвар нэмэгдэх,
- Бодлогын туршилтын судалгааны ерөнхий ойлголт, статистик шинжилгээний мэдлэг, ур чадвар сайжрах,

- Хагас туршилтын буюу квази шинжилгээний аргуудыг бодлогын шинжилгээнд хэрэглэх мэдлэг, ур чадвар нэмэгдэх.


Модуль сургалтын агуулга

- Зардал үр дүн, үр өгөөжийн шинжилгээ: Боловсролын салбарын жишээн дээр
- Боловсролын салбарын туршилтын судалгаа
- Квази туршилтын судалгааны арга: Бодлогын судалгааны жишээн дээр

Зураг 28. Семинарын агуулгын жишээ зураг




Зардал үр дүн



Зардал үр өгөөж



Жинхэнэ туршилт загвар



Квази (хагас) туршилтын загвар

ХӨТӨЛБӨР

Семинар 1. Модуль 1-2 | өдөр 1

5-р сарын 13-ны өдөр | 9:45 – 12:00

Чиглүүлэгч: Доктор, профессор Г. Баттүвшин

Зохион байгуулагч: Хүний хөгжил судалгаа, сургалтын төв

Илтгэгч: Доктор Т. Ууганбаяр

Техникийн баг Доктор Б. Болормаа, Г. Цэрэнжаргал

09:45 – 10:00	Бүртгэл	
10:00 – 10:05	Нээлт БШУЯ-ны Шинжлэх ухааны газрын дарга Доктор, профессор С. Мөнхбат	Зүүм
10:05 – 10:50	Зардал үр дүнгийн шинжилгээ + Өмнөх хэлэлцүүлгийн тойм Илтгэгч ШУТИС-ийн БАТС-ийн дэд профессор, доктор Т. Ууганбаяр	Зүүм
10:50 – 11:00	Завсарлага	Зүүм
11:00 – 11:50	Зардал үр өгөөжийн шинжилгээ Илтгэгч ШУТИС-ийн БАТС-ийн дэд профессор, доктор Т. Ууганбаяр	Зүүм

Нэмэлт мэдээлэл

Модуль сургалтын гурван гарын авлага хэвлэгдэн гарсны дараа сургалтад оролцогч нарт дижитал контентын хамт хүргүүлнэ.

ХӨТӨЛБӨР

Семинар 2. Модуль 2-3 | өдөр 2

5-р сарын 14-ны өдөр | 9:45 – 12:00

Чиглүүлэгч: Доктор, профессор Г. Баттүвшин

Зохион байгуулагч: Хүний хөгжил судалгаа, сургалтын төв

Илтгэгч: Доктор Т. Ууганбаяр

Техникийн баг Доктор Б. Болормаа, Г. Цэрэнжаргал

09:45 – 10:00	Бүртгэл	
10:00 – 10:50	Жинхэнэ туршилтын судалгаа Илтгэгч ШУТИС-ийн БАТС-ийн дэд профессор, доктор Т. Ууганбаяр	Зүүм
10:50 – 11:00	Завсарлага	Зүүм
11:00 – 11:50	Хагас туршилтын судалгааны загвар Илтгэгч ШУТИС-ийн БАТС-ийн дэд профессор, доктор Т. Ууганбаяр	Зүүм
11:50 – 12:00	Хаалтын үг Төслийн багийн ахлагч Доктор, профессор Г. Баттүвшин	Зүүм

Нэмэлт мэдээлэл

Модуль сургалтын гурван гарын авлага хэвлэгдэн гарсны дараа сургалтад оролцогч нарт дижитал контентын хамт хүргүүлнэ.

Даваа гариг | 2021.06.21

14:30-15:00	Бүртгэл
-------------	---------


Нээлт

	Нээлтийн
15:00-15:15	Төслийн удирдагч Доктор, профессор Г. Баттүвшин Сургагч багш Доктор, дэд профессор Т. Ууганбаяр

Семинар


	Илтгэл 1
15:15-15:45	Зардал үр дүн, үр өгөөжийн шинжилгээ: Боловсролын салбарын жишээн дээр <i>Сургагч багш Доктор, дэд профессор Т. Ууганбаяр</i>
	Илтгэл 2
15:45-16:15	Боловсролын салбарын туршилтын судалгаа <i>Сургагч багш Доктор Б. Болормаа</i>
16:15-16:30	<i>Цайн завсарлага</i>
	Илтгэл 3
16:30-17:00	Квази туршилтын судалгааны арга: Бодлогын судалгааны жишээн дээр <i>Төслийн удирдагч Доктор, профессор Г. Баттүвшин</i>
17:00-17:15	Хэлэлцүүлэг: Асуулт, хариулт
17:15-17:25	Хаалтын үг

Зураг 29: Сургалтын зургууд



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА, БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЗАГВАР БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

ШУТС төсөл 2019-2021 он



Ном зүй

- Abelson, D. (2018). *Do Think Tanks Matter? Assessing the Influence of Public Policy Institutes*. Kingston and Montreal: McGill-Queen's University Press.
- Abelson, D. E. (2019). "From Generation to Generation. Reflections on the Evolution of Think. *International Review of Public Policy*, 1(2), 238–49.
- Hamre, J. J. (2008). The Constructive Role of Think Tanks in the Twenty-first Century. *Asia-Pacific Review*, 15:2, 2-5. doi:DOI: 10.1080/13439000802511067
- Ladi, S. (2009). Think Tanks and Policy Advice in the US: Academics, Advisors and Advocates. (J. G. McGann, Хян.) *Public administration*, 87. doi:10.1111/j.1467-9299.2008.01746_5.x.
- Ladi, S. (2015, January 13). *think tank*. Retrieved from Encyclopedia Britannica: <https://www.britannica.com/topic/think-tank>
- Landry, J. (2021). Business-Backed Think Tanks Represent Class Interests? The Co-evolution of Policy Learning and Economic Elites in the Canadian Knowledge Regime. *Administration & Society*. doi:<https://doi.org/10.1177/00953997211065340>
- Markus Mykkänen, Neil Freshwater,. (2021). Typology of think tanks: A comparative study in Finland and Scotland. *Academicus International Scientific Journal*, 72-90.
- McLevey, J. (2014). Think tanks, funding, and the politics of policy knowledge in. *Canadian Review of Sociology*, 51(1), 54-75.
- Sammut, J. (2016 оны June). The Role of Think Tanks: Reply to the Critics. Sydney, Australia.
- Singh, R., Sharma, N. N., & Jha, U. (2014). Think Tanks, Research Influence and Public Policy in India. *Vision*, 18(4), 289–297. doi:<https://doi.org/10.1177/0972262914552173>